

С
363.2
Б-342

Албан хэрэгцээнд зориулав

ЦАГДАА СУДЛАЛ

Онол арга зүйн
улирал тутмын
сэтгүүл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Баянмөнх

Хэвлэлийн хуудас: 9.9 х/х

Цаасны хэмжээ: А.4

Өрөлтөд орсон огноо: 2023.12.23

Дугаарыг эрхлэн гаргасан: Доктор (Ph.D) Б.Баянмөнх

ISBN 978-99962-8882-2-7

2023 №4 (37)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: **Ж.Болдбаатар** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

Ж.Долгорсүрэн Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Б.Пүрэв Хууль зүйн доктор (Ph.D), хүндэт профессор

Ж.Заанхүү Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор

Г.Гантөмөр Хууль зүйн доктор, (Ph.D), профессор

Ч.Нямсүрэн Хууль зүйн доктор (Ph.D), профессор

З.Төрмандах Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Т.Оюунчимэг Хууль зүйн доктор (Ph.D), профессор

Сэтгүүлийн эрхлэгч: Хууль зүйн доктор (Ph.D), профессор **Бө.Бат-Эрдэнэ**

Нарийн бичгийн дарга: Хууль зүйн доктор (Ph.D) **Б.Баянмөнх**

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

Т.Бямбаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

О.Цэцэгмаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Д.Энхжаргал Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D)

Д.Мягмарцэрэн Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Ш.Ариунбилэг Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Б.Баянмөнх Хууль зүйн доктор (Ph.D)

Г.Бямбадорж Хууль зүйн доктор (Ph.D)

*Манай хаяг: Дотоод хэргийн их сургууль Баян зүрх дүүрэг, Цагдаагийн Академийн өргөн чөлөө, хилчиний гудамж-1, утас: 99878219
мэйл хаяг: b.bayadaa2007@gmail.com*

ЦАГДАА СУДЛАЛ
Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл
(дугаар 2023 №4)

АГУУЛГА

ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Ү.Хосбаяр. Гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналтын тухай.....	4
Б.Ганболд. Кибер гэмт хэрэг ба нийгмийн инженерчлэлийн тухай.....	8

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Баярболд. Монгол Улсад 2018-2022 онуудад бүртгэгдсэн гэмт хэргийн ерөнхий нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ.....	13
Г.Болор-Эрдэнэ. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн профайлинг, нийгэм-сэтгэл зүйн онцлог.....	26

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б. Одбаатар Мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны даргын эрх хэмжээ, түүний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт.....	35
---	----

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Баянмөнх. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа ба түүний үндсэн агуулга, элемент.....	44
Б.Батбаяр. Цагдаагийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэх явцад тулгамдаж буй асуудал.....	53
Д.Нямдорж. Унадаг дугуйн болон цахилгаан унадаг дугуйн эрх зүйн орчны зохицуулалтын хөгжилтөд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломжууд.....	58

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Д.Энх-Амар. Замын хөдөлгөөни аюулгүй байдлын эсрэг зөрчлийн ойлголт, шинж.....	66
Х.Уянга. Замын хөдөлгөөнд оролцогчдын эрх зүйн байдал, анхаарах зарим асуудал.....	74

ДОТООДЫН ЦЭРЭГ СУДЛАЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

В.Номинчулуун, Э.Хандармаа. Дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага.....	81
Б.Ариунтөгс. Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагаанд анхаарвал зохих зарим асуудал.....	85
Э.Буман-Аюуш. Улсын онц чухал объектын хамгаалалтын инженер, техник хэрэгслийн ашиглалт, сайжруулах арга зам.....	93

ГҮЙЦЭТГЭХ АЖИЛД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН ТУХАЙ
ON THE SUPERVISION OF THE PROSECUTOR OVER
INTELLIGENCE ACTIVITIES

Ү.Хосбаяр
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Гүйцэтгэх Ажлын Тэнхимийн эрхлэгч,
доктор (Ph.D), цагдаагийн хурандаа
U. Hosbayar
University of Internal Affairs, Head of
the Criminal intelligence Department
of the Polive school,
Doctor (Ph.D), police colonel

Товч агуулга. Монгол Улсын хэмжээнд гүйцэтгэх ажил эрхлэн явуулах эрх бүхий байгууллагуудын эрх хэмжээ, үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл, үр дүнг хэрхэн ашиглах нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Гүйцэтгэх ажлын тухай хуульд нарийвчлан сайн тусгалаа олоогүй, тодорхой бус байгааг судалж, дүгнэлт, санал дэвшүүлэхэд оршино.

Abstract. To study the fact that the powers, legal basis and results of operations of the organizations authorized to carry out execution work throughout Mongolia are not well reflected in the Law on Execution Work that is currently in force and are unclear, and to make conclusions and suggestions. exists.

Түлхүүр үг. Нууцлал, Гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа, нэр томъёо, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шат, прокурор, прокурорын хяналт.

Key words. Confidentiality, Executive work, secret investigation, terminology, investigation, investigative stage, prosecutor, prosecutorial control.

Нэг. Удиртгал хэсэг. Монгол Улсад анх удаа гүйцэтгэх ажил, түүний зарчим, үндэслэл, хүрээ, гүйцэтгэх ажил эрхлэх төрийн байгууллага, ажилтны эрх, үүргийг тодорхойлж, гүйцэтгэх ажил явуулах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан хуулийг “Гүйцэтгэх ажлын тухай” нэртэйгээр 1997 оны 12 сарын 19-ний өдөр Улсын Их Хурлаас баталж эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж байна. Батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш уг хуульд нийт 11 удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд ихэнх нь гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэгтэй холбоотой өөрчлөлтүүд хийгджээ.

Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хуулийн 23 дугаар зүйлд: “Улсын ерөнхий прокурор, түүний тусгайлан эрх олгосон прокурор нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд урьдчилан бичгээр зөвшөөрөл өгсний үндсэн дээр хэрэгжүүлэх гүйцэтгэх ажлын 6-н арга”-ыг хуульчилсан байдаг. Энэ нь нууц эх сурвалжаас авагдсан мэдээллийг шалгах болон Гүйцэтгэх ажлын хэрэг нээн шалгах ажиллагаа явагдаж байгаа тохиолдолд прокуророос зөвшөөрөл шаардахгүй гэсэн санааг илэрхийлж байна. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд: “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял

эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”¹, Прокурорын байгууллагын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт: “Прокурорын байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн”² гэж тус тус заажээ.

Хуулийн энэ заалт нь нэг талаас прокурорын байгууллагад хуулиар хүлээлгэсэн чиг үүрэг, нөгөө талаас прокурорын байгууллагаас явуулах үйл ажиллагааны хүрээ хязгаарыг тогтоож өгсөн гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл прокурорын байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг нь:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах;
2. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих;
3. Шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох; гэж тодорхойлогджээ.

Гэтэл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгт хамтатгаж гүйцэтгэх ажилд хяналт тавьж байгаа нь прокурорын байгууллагаас хуулиар олгогдоогүй чиг үүргийг хэрэгжүүлж иржээ гэж үзэх үндэслэл байна. Үүнийг дараах байдлаар тайлбарлая. Тухайлбал:

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт нь гүйцэтгэх ажлаас ялгаатай ойлголт юм. Гүйцэтгэх ажил гэх томъёололыг Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар зүйлд: “Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх ажил гэнэ.”³ гэж тодорхойлсон бол хэрэг бүртгэлт гэж “Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл хүлээн авснаас эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл явуулж байгаа энэ хуульд заасан ажиллагааг хэрэг бүртгэлт гэнэ”⁴.

Мөрдөн байцаалт гэж “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэнээс хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл хэргийн талаар нотлогдвол зохих байдлыг тогтоох зорилгоор явуулж байгаа энэ хуульд заасан ажиллагааг мөрдөн байцаалт гэнэ.”⁵ гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тус тус тодорхойлжээ. Энэхүү тодорхойлолтоос дүгнэвэл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт нь зөвхөн ЭХХШтХуульд заасан ажиллагаа байдаг бол гүйцэтгэх ажил эрхлэн явуулахтай холбогдсон харилцааг Гүйцэтгэх ажлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон дээрхи хуулиудтай нийцүүлж боловсруулан баталсан гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагуудын заавраар зохицуулдагаараа ялгаатай байна. Нөгөөтэйгүүр хэрэг бүртгэлт гэж гэмт хэрэг буюу гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан үйлдэл, эс үйлдэхүйн тухай гомдол, мэдээлэл дээр явагдах ажиллагаа бол гүйцэтгэх ажил нь Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөний эсрэг чиглэсэн гэмт халдлага байна. Өөрөөр хэлбэл хэрэг бүртгэлт,

¹ Үндсэн хууль//Төрийн мэдээлэл.,Уб.,1992.№1

² Прокурорын тухай хууль // Төрийн мэдээлэл. Уб.,2017.№24

³ Гүйцэтгэх ажлын тухай хууль // Төрийн мэдээлэл. Уб., 1998. №3

⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.1 дэх хэсэг //Төрийн мэдээлэл.Уб.,2017.№23

⁵ Мөн хуулийн 31 дугаар зүйлийн 31.1 дэх хэсэг

мөрдөн байцаалт нь нэгэнт үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, сэжигтэн, яллагдагчийн гэм буруугийн байдлыг тогтоох, тухайн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хохирсон хүний зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн ажиллагааг ЭХХШТХуульд заасны дагуу явуулдаг ажиллагаа бол гүйцэтгэх ажил нь үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, гэмт халдлага түүний улмаас учирч болзошгүй хор уршигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн ажиллагаа байдгаараа онцлогтой. Иймээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах гол үндэслэл нь тодорхой хууль зүйн факт буюу гэмт хэрэг үйлдэгдсэн байх бодит нөхцөл байдлыг шаарддаг бол гүйцэтгэх ажил явуулах үндэслэл нь гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй, эсхүл үйлдэгдэж байгаа, үйлдэгдээд өнгөрсөн тухай мэдээлэл байна

2. Дээрх ойлголттой холбоотой дараагийн асуудал гэмт хэрэг илрэх тухай асуудал юм. Цагдаагийн байгууллагаас гаргасан статистик мэдээлэлд 2023 оны эхний 6-н сарын байдлаар Монгол Улсын хэмжээнд 22032 гэмт хэрэг бүртгэгдсэн талаар дурьджээ⁶. Нэгэнт Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн тохиолдолд дээрх бүх гэмт хэрэг нь илэрч бүртгэгдсэн гэмт хэрэг бөгөөд эдгээр хэргүүдийг үйлдсэн эзэн холбогдогч нь тогтоогдох эсэх нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны үр дүнгээс хамаарна. Нөгөө талаас Цагдаагийн байгууллагад илэрч бүртгэгдэхгүй байгаа, бэлтгэл, завдалтын шатанд байгаа гэмт хэрэг, гэмт хэргийн талаарх мэдээллийг шалгах ажиллагааг хууль зүйн үндэслэлтэй хэрхэн явуулах вэ? гэдэгт гүйцэтгэх ажил чиглэх ёстой. Энэ ажиллагаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт биш тул гагцхүү гүйцэтгэх ажлаар явагдах шаардлага тулгарна. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийг үйлдсэн эзэн холбогдогчийг олж тогтоох, тухайн хэргийг хуулийн дагуу шийдвэрлэхэд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд гүйцэтгэх ажил нь дэмжлэг үзүүлэх хэлбэрээр явагдах ёстой.

3. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлд гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналтыг “Гүйцэтгэх байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд дор дурдсан ажиллагаа явуулахад прокурор бичгээр урьдчилан зөвшөөрөл өгнө.”⁷ гэж хуульчилжээ. Хуулийн энэ заалт нь нэгэнт үйлдэгдэж бүртгэгдсэн гэмт хэрэгт явуулж буй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илэрхий болсон сэжигтэн, яллагдагч руу чиглүүлэн явуулах гүйцэтгэх ажлын арга, хувилбаруудыг тусгаж өгсөнөөс бус эрх бүхий байгууллагаас явуулах хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтад үл хамаарах. Гүйцэтгэх ажлын тухай хуулиар зохицуулагдах нийгмийн харилцаатай холбоотой ажиллагаанд прокурор хяналт тавих тухай асуудал биш юм.

Тухайлбал, Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан нэр бүхий 6-н төрлийн ажиллагааг хэн нэгэн хувь хүн буюу тодорхой эзэн биетэй байж явуулах боломжтой ба өөрөөр хэлбэл сэжиглэгдэх хуулийн үндэслэл бүхий сэжигтэн, яллагдагч руу чиглүүлэн явуулахаас бус гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагаас иргэд рүү чиглүүлэн нийтээр нь нууцаар ажиглалт явуулах, бүх иргэдтэй хяналтын худалдан авалт хийгээд байх боломжгүй юм.

Иймд прокурорын байгууллагаас тодорхой эрүүгийн хэрэгт сэжиглэгдэж буй этгээд рүү чиглүүлэн явуулах гүйцэтгэх ажлын ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангах зорилгоор тухайн этгээд сэжиглэгдэх хуулийн үндэслэл бүрэн байгаа эсэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад цуглуулсан нотлох баримтууд нь тухайн этгээдийг сэжиглэх хангалттай үндэслэл мөн эсэхэд хяналт тавих ба тухайн хэргийг хуулийн дагуу шийдвэрлэхэд ач холбогдол бүхий эд мөрийн болон нотлох баримт устах, үрэгдэх, цаашид

⁶ Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал. УБ., 2023.

⁷ Гүйцэтгэх ажлын тухай хууль //УБ.,1998.Төрийн мэдээлэл №3

илүү сөрөг үр дагавар учирч болзошгүй байдлыг үнэлэн, ил аргаар буюу ЭХХШтХуульд заасан ажиллагаагаар тогтоох боломжгүй нөхцөл байдал үүссэн эсэхийг тухайн эрүүгийн хэргийн материалд үндэслэн шийдвэр гаргах ойлголт юм. Шийдвэр нь зөвшөөрөх эсхүл үл зөвшөөрөх гэсэн хувилбартай бичгээр үйлдэгдэх хэлбэртэй байна. Шийдвэр гаргах үндэслэл нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн материал байна.

4. Хүчин төгөлдөр үйлчилж буй Прокурорын тухай хуулийн 25 дугаар зүйлд “Мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавих” гэсэн зохицуулалт тусгагджээ.⁸ Хуулийн энэ заалт нь мөрдөн шалгах нууц ажиллагаа болон гүйцэтгэх ажил нь тусдаа ойлголт гэдгийг илэрхийлж байна. Учир нь мөрдөн шалгах нууц ажиллагаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаатай адил зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу явагдаж буй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын аль ч шатанд хэрэгжих бололцоотой ажиллагаа ба гагцхүү нууц гэдэг ойлголтоороо ялгагдана. Иймд мөрдөн шалгах нууц ажиллагаанд прокурор хяналт тавих хуулийн бүрэн үндэслэл байгаа ба мөрдөн шалгах нууц ажиллагааны нууц гэх ойлголт нь Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан нууцын ямар зэрэглэлд хамаарахаас шалтгаалж эрүүгийн хэрэгт хяналт тавих эрх бүхий бүх прокурор хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх эсэх нь шийдвэрлэгдэнэ.

Дүгнэлт

1. Эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэл нь ЭХХШтХууль ба уг хуулийн 16.8 дугаар зүйлийн 16.8.5-д: “Хавтаст хэрэгт тусгагдаагүй баримт сэлт, мэдээлэл, мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн, бусад баримт болон гүйцэтгэх ажилтай холбоотой ямар ч баримт мэдээллийг шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг явуулах, хэрэг хянан шийдвэрлэх шүүхэд танилцуулахыг хориглоно”⁹ гэснээс өөрөөр гүйцэтгэх ажил эрхлэн явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан заалт байхгүй байна.

2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт нь ЭХХШтХуулиар зохицуулагдаж буй ажиллагаа бол гүйцэтгэх ажил нь Гүйцэтгэх ажлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулагддаг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж буй бие даасан ажиллагаа мөн.

3. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт нь цаг хугацааны хувьд болж өнгөрсөн үйл явдал (гэмт хэрэг)-н араас мөрдөж хөөх хэлбэрээр явагддаг бол гүйцэтгэх ажил нь угтах хэлбэрээр, учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор явагдана.

4. Гүйцэтгэх ажил нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас тусдаа бие даасан ажиллагаа тул прокурор гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх зүйн үндэслэл байхгүй байна гэж үзсэн бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль болон Прокурорын тухай хуульд заасан прокурорын чиг үүрэгт гүйцэтгэх ажилд хяналт тавих чиг үүргийг хуульчлаагүй байна.

⁸ Прокурорын тухай хууль // Төрийн мэдээлэл. Уб., 2017. №24

⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.1 дэх хэсэг // Төрийн мэдээлэл. Уб., 2017. №23

КИБЕР ГЭМТ ХЭРЭГ БА НИЙГМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ТУХАЙ

CYBER CRIME AND SOCIAL ENGINEERING

Б.Ганболд, Дотоод Хэргийн Их
Сургуулийн Цагдаагийн сургуулийн
Гүйцэтгэх ажлын тэнхимийн багш,
цагдаагийн ахмад

B. Ganbold, lecturer of the Department of
Criminal intelligence at the Police School of
the University of Internal Affairs, police
captain

Хураангуй: Орчин үед программ хангамж үйлдвэрлэгчид программ бүтээх тал дээр илүү ур чадвартай болж, тухайн программыг эвдэж нэвтрэхэд илүү төвөгтэй болсон. Кибер гэмт хэрэгтнүүд урьдын адил программ хангамжийг эвдэн нэвтрэх, тэр дундаа алсаас нэвтрэх нь улам хэцүү болж байгаа тул нийгмийн инженерчлэлийн аргыг илүү түлхүү ашиглан, аюулгүй байдлын систем, дэд бүтцийн хамгийн сул хэсэг болох хүн рүү чиглэн довтлох болсон. Дэлхий даяар кибер гэмт хэрэгтнүүд мэдээлэл харилцаа холбооны технологийг, нийгмийн инженерчлэлийн аргатай хослуулан ашиглаж төрөл бүрийн халдлагыг үйлдсээр байна. Хэлэхэд харамсалтай ч амжилттай хэрэгжүүлсэн кибер халдлага, кибер гэмт хэрэг бүрийн ард нийгмийн инженерчлэлийн зарим нэг аргыг заавал ашигласан байдаг.

Abstract: Nowadays, software developers have become more skilled at creating software, making it more difficult to break into it. As it becomes more difficult than ever to break into software, including remote access, cybercriminals are increasingly using social engineering techniques to attack the weakest part of security systems and infrastructure: humans. Cybercriminals around the world continue to use a combination of information and communication technology and social engineering techniques to carry out a variety of attacks. Sad to say, behind every successful cyber attack and cyber crime, some form of social engineering is bound to be used.

Түлхүүр үгс: Нийгмийн инженерчлэл, Фишинг халдлага, Кибер гэмт хэрэг.

Keywords: Social engineering, Phishing attack, cyber crime.

Оршил: Нийгмийн инженерчлэлийн арга гэж юу болох талаар нээлттэй эх сурвалжид "Хүмүүсийг хууран мэхлэх замаар ямар нэг үйлдэл хийлгэх, эсвэл нууц мэдээллийг задруулахад хүргэх үйл ажиллагаа юм"¹⁰ гэж тодорхойлсон байдаг. Орчин үед нийгмийн инженерчлэл гэх энэ нэр томъёог ихэвчлэн кибер гэмт хэрэгтнүүд, хор хөнөөлтэй хакерууд ашиглаж байна. Ихэнх тохиолдолд гэмт этгээд нь хохирогчтой хэзээ ч нүүр тулдаггүйгээрээ онцлог байдаг.

¹⁰ <https://www.cisco.com>

Тэгэхээр **нийгмийн инженерчлэл** гэдэг нь амьдралын зарим нэг нөхцөл байдалд тохируулан, заль мэх ашиглан, бусдыг төөрөгдөлд оруулж эсвэл зохиомол хомсдол үүсгэн ятгаж, хүнийг сэтгэлзүйгээр нь удирдах чадвар юм¹¹.

Нийгмийн инженерчлэлийн арга нь дангаараа кибер халдлага биш юм. Кибер гэмт хэргийг үйлдэхэд ашигладаг олон төрлийн халдлагын арга байдаг. Эдгээр аргуудыг үр дүнд хүрэхэд нөлөөлж байдаг гол түлхүүр арга бол нийгмийн инженерчлэлийг арга юм.

Кибер халдлагыг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор кибер гэмт хэрэгтнүүд ирээдүйн хохирогч руу чиглэн хэрэгжүүлж байгаа тоглолт, заль бөгөөд үр дүнд нь хүн хамгаалалтаа бууруулж, хувийн мэдээллээ задруулах, хортой веб холбоос дээр дарах, хортой код агуулсан байж болзошгүй файл, хавсралтуудыг нээх зэрэг аюултай үйлдлийг өөрийн мэдэлгүй хийдэг. Өөрөөр хэлбэл кибер гэмт хэрэгтэн хүмүүсийн итгэл үнэмшил, шунал дээр тулгуурлан мөрөөдөлдөө хүрэх хосгүй боломж эсвэл ямар нэг сандрал хомсдолыг зохиомлоор бий болгон бусдыг өөрийн хавханд оруулан зорилгоо хэрэгжүүлдэг. Тэд ирээдүйн хохирогчдоо маш сайн судалж, тэдний талаар жижиг гэлтгүй мэдээллийг олж өөрсдийнх нь эсрэг ашиглан итгэл үнэмшлийн олж авч, гэмт этгээдтэй харилцаанд орох зохиомол хэрэгцээ шаардлагыг бий болгодог.

НИЙГМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ ХЭРХЭН АЖИЛЛАДАГ ВЭ?

Кибер гэмт хэрэгтэн нийгмийн инженерчлэлийн арга ашиглан хохирогчийн таньж мэддэг хүн, бизнесийн хамтрагчийн имэйл хаяг эсвэл утасны дугаар зэргийг дуурайн харилцаанд орж албан ёсны мэт харагдах нууц үг хулгайлах зорилгоор бүтээсэн хуурамч вэб хуудас руу хөтлөх, зарим тохиолдолд итгэмжлэгдсэн байгууллагын ажилчдыг дуурайх гэх мэт арга ашигладаг. Хэрэв энэ арга заль нь үр дүнд хүрвэл (хохирогч гэмт этгээдэд итгэсэн тохиолдолд) гэмт этгээд хохирогчийг итгэл үнэмшил дээр тулгуурлан нууц үг, төрсөн огноо, банкны дансны дэлгэрэнгүй мэдээлэл гэх мэт хувь хүний нууц мэдээллийг авдаг.

НИЙГМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ ЯАГААД ИЙМ АЮУЛТАЙ ВЭ?

Нийгмийн инженерчлэлийн хамгийн том аюулын нэг нь халдлага үйлдэж буй гэмт этгээд хүн тус бүрд чиглэн ажиллах шаардлагагүй байдаг. Өөрөөр хэлбэл амжилттай хууртагдсан ганц хохирогч байхад л хангалттай бөгөөд түүгээр дамжуулан гэр бүл, найз нөхөд, бүхэл бүтэн байгууллагад нөлөөлж болохуйц халдлагыг хийх боломжтой байдаг. Өнөө үед нийгмийн инженерчлэлийн довтолгоонууд улам боловсронгуй болсон. Бусдын нэвтрэх нэр нууц үгийг хулгайлахаар хийгдсэн хуурамч вэбсайт, цахим шуудан нь хангалттай бодитой харагддаг төдийгүй нийгмийн инженерчлэлийн арга нь кибер гэмт хэргийн ертөнцөд хувь хүн байгууллагын хамгаалалтыг шугамыг давахад ашиглаж байгаа хамгийн түгээмэл арга нь болсон байна.

НИЙГМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ХАЛДЛАГЫН ТӨРЛҮҮД

ФИШИНГ \PHISHING\ ХАЛДЛАГА

Фишинг халдлага нь кибер орчинд хамгийн түгээмэл тархсан нийгмийн инженерчлэлийн халдлагын нэг төрөл юм¹². Үндсэндээ фишинг гэдэг нь иргэдийн нэвтрэх нэр нууц үгийг олж авахад чиглэсэн байдаг. Хуурамч цахим шуудан ашиглах, эсвэл хууль ёсны мэт харагдах веб хуудас ашиглан бусдын нууц үгийг хулгайлдаг. Заримдаа гэмт этгээд

¹¹ Human hacking: win friends, influence people, and leave them better off for having met you, 2021.

¹² Руководство по защите от хакеров/ Коул Эрик. Пер. с англ. – М. Издательский дом «Вильямс», 2002.

хохирогчийг зээлийн картын мэдээлэл эсвэл бусад хувийн мэдээллээ өгөхийг албадах оролдлого хийдэг. Мөн илүү дэвшилтэт халдлагууд мөн ransomware¹³ гэх мэт илүү аюултай халдлагууд ихэвчлэн фишинг халдлагаас эхэлдэг.

УРХИДАХ ХАЛДЛАГА \WATERING HOLE ATTACKS\

Нийгмийн инженерчлэлийн энэ арга нь зорилгот бүлэг хүмүүс рүү чиглэн хэрэгжүүлдэг арга юм. Гэмт этгээд тухайн бүлэгт шууд чиглэхийн оронд тухайн бүлэг хүмүүсийн зочлох дуртай эсвэл зочлох магадлалтай веб сайтыг эвдэн дотор нь мэдээлэл олзлох хортой код бүхий урхи тавьдаг. Жишээлбэл, банк санхүү, төрийн үйлчилгээ гэх мэт тодорхой салбарын ажилтнууд байнга зочилдог тухайн салбарын вебсайтууд гэх мэт. Урхихах халдлагын хэрэгжүүлж байгаа гэмт этгээдүүд вэбсайтыг эвдэж, зорилгот бүлэг хүмүүсээс хэн нэгнийг барьж авахыг зорих бөгөөд хэрэв урхинд нэг л ажилтан орсон бол тухайн хүний дуурайн түүний хувийн мэдээлэл, имэйл хаяг, сошиал хаяг эсвэл төхөөрөмжөөр дамжуулан бусдын итгэлийг олж халдлагаа бүрэн гүйцээн зорилгоо хэрэгжүүлдэг.

- БИЗНЕСИЙН ЦАХИМ ШУУДАНГИЙН ХАЛДЛАГА \ BUSINESS EMAIL COMPROMISE ATTACKS \

Бизнесийн цахим шуудангийн халдлага гэдэг нь гэмт этгээд нь хохирогчийн удирдах албан тушаалтан, эсвэл бизнесийн түнш, ханган нийлүүлэгчдийн имэйл хаягийг дуурайлган хийж, ямар нэг данс руу мөнгө шилжүүлэхийг хүссэн, тушаасан хуурамч цахим шуудан илгээж бусдыг залилдаг бөгөөд цахим шуудан ашиглан үйлдэгддэг залилан мэхлэх гэмт хэргийн нэг төрөл юм.

- НИЙГМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН БИЕТ ХАЛДЛАГА \PHYSICAL SOCIAL ENGINEERING \

Гэмт этгээд танай албан байгууллагад хэн нэг этгээдийн дүрд хувиран нэвтэрч халдлага үйлдэхдээ ашиглаж болох мэдээллүүдийг авах боломжтой байдаг. Албан байгууллагын туслах ажилтнууд, үүдний хүлээн авагчид, гадуур хүргэлт хариуцсан ажилтан гэх мэт эдгээр хүмүүс гэмт этгээдийн хэрэгжүүлж буй нийгмийн инженерийн биет халдлагад өртөх эрсдэлтэй байдаг. Иймд албан байгууллагууд үр дүнтэй хамгаалалттай, хяналттай байх хэрэгтэй. Жишээ нь байгууллагад ирж буй зочдыг бичиг баримттай тулган бүртгэж байх, байгууллага дотор зочдыг хяналтгүй ганцаар нь явуулахгүй байх гэх мэт.

- USB ӨГӨӨШ \ USB BAITING \

USB өгөөш нь бага зэрэг бодитой бус сонсогдож байгаа ч таны бодож байгаагаас илүү илбэг тохиолддог нийгмийн инженерчлэлийн түгээмэл халдлагын нэг юм. Кибер гэмт хэрэгтнүүд USB зөөврийн төхөөрөмж дээр хортой программ суулгаж, стратегийн чухал газруудад орхих ба хэн нэгэн сониуч ажилтан тухайн USB-г авч албан байгууллагын компьютерт залгаснаар өөрийн байгууллага руу хортой кодыг өөрөө ч мэдэлгүй оруулдаг.

ТА ӨӨРИЙГӨӨ БОЛОН БАЙГУУЛЛАГАА НИЙГМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ХАЛДЛАГААС ХЭРХЭН ХАМГААЛАХ ВЭ?

Нууц үг: Нууц үг бүрд байх ёстой тэмдэгтүүдийн тоо, төрлийг нэмэгдүүлэх, нууц үгийг ойр давтамжтайгаар сольж байх. Нууц үгээ хэнд ч задруулахгүй байх.

¹³ Ransomware гэдэг нь хохирогчийн төхөөрөмж дээрх файлуудыг шифрлэн түгжиж барьцаалдаг хортой вирус бөгөөд түгжээтэй файлуудыг тайлахын тулд хохирогчоос мөнгө нэхдэг.

Сэжигтэй холбоос дээр дарахгүй байх: Танихгүй хүнээс сэжигтэй имэйл ирвэл нээхгүй байх. Сошиал сүлжээ ашиглан илгээсэн линк холбоос дээр дарахгүй байх. Хэрэв таньдаг хүнээс дээрх сэжигтэй тохиолдол илэрвэл биечлэн эсвэл утсаар холбогдон лавлаж байх.

Фишингийн эсрэг хамгаалалт ашиглаж байх: Олон давхар имэйл хамгаалалт нь фишинг болон бусад нийгмийн инженерийн халдлагын аюулыг багасгаж чаддаг. Зарим цахим шуудангийн аюулгүй байдлын хэрэгслүүд фишингийн эсрэг программ хангамжийг суулгасан байдаг.

Домейн нэр, линкийг шалгаж байх: Фишинг халдлагыг таних хамгийн сайн аргуудын нэг болох гипертекст холбоосыг шалгаж байх. URL холбоос нь ирсэн веб хуудастай нийцэж байгаа эсэхийг шалгаарай. Нэмж дурдахад хачирхалтай тэмдэгтүүд эсвэл товчилсон холбоосууд дээр дарахдаа болгоомжтой байгаарай. Гар утсан дээрээс орж байгаа үед та холбоос дээр дарахаасаа өмнө холбоос дээр удаан дарах үед очих URL линк жижиг цонхон дээр гарч ирэн холбоосыг ажиглаж болно. Хэрэв веб хуудсаар зочилж байгаа бол URL дээр хулганыг аваачих үед хөтчийн цонхны зүүн доод буланд линкийн очих замыг харуулдаг тул дээрх аргуудыг ашиглан линкийг \холбоос\ шалгаж болно.

Дүгнэлт: Нийгмийн инженерчлэлийн халдлага нь хүний сониуч зан, эрх мэдлийг хүндэтгэх, найз нөхдөдөө туслах хүсэл гэх мэт хүний төрөлхийн шинж чанар, нийгмийн нөхцөл байдлууд дээр тулгуурлан хүнийг төөрөгдөлд оруулахад чиглэсэн байдаг тул үүнийг эсэргүүцэн давж туулахад хэцүү байдаг. Нийгмийн инженерчлэлийн халдлагыг илрүүлэхэд туслах хэд хэдэн зөвлөмж байдаг.

Харилцаа холбоо хаанаас ирж байгааг эргэцүүлэн бодоорой; сохроор бүү итгэ. Таны ширээн дээр өмнө харж байгаагүй USB зөөврийн диск гарч ирсэн бөгөөд та энэ хэнийх болохыг мэдэхгүй байна уу? Гэнэт утсаар, эсвэл цахим шуудангаар таныг их хэмжээний мөнгө өвлөн авсан гэх мэдээ ирсэн үү? Ажлын газрын даргаас чинь яаралтай ажилчдын талаарх мэдээлэл явуулахыг хүссэн имэйл ирсэн үү? Хэрэв тийм бол эдгээр нь бүгд сэжигтэй байх тул яаран ямар нэг үйлдэл хийлгүйгээр эх сурвалжийн заавал шалгаж байгаарай.

Эх сурвалжийг шалгах нь тийм ч хэцүү биш юм. Жишээлбэл, и-мэйл ирсэн бол имэйлийн толгой хэсгийг харж, өмнө ирж байсан ижил илгээгчийн жинхэнэ имэйлтэй харьцуулан шалгана уу. Дээр дурдсанчлан холбоос хаашаа явж байгааг хараарай. Хуурамч холбоос дээр курсороо аваачихад л хялбархан олж харна (холбоос дээр дарж болохгүй!) Үг үсгийн алдааг шалгана уу: Албан байгууллагууд өөрсдийн харилцагч үйлчлүүлэгчтэй харилцахад зориулан чадварлаг ажилчдыг ажиллуулдаг тул ямар нэг үг үсэг утга найруулгын алдаатай имэйл ирсэн бол хуурамч байж магадгүй юм.

Хэрэв та эргэлзэж байвал албан ёсны вэбсайт руу орж, албан ёсны төлөөлөгчтэй холбоо бариарай, учир нь тэд имэйл/мессеж албан ёсны эсвэл хуурамч эсэхийг баталгаажуулах боломжтой. Нийгмийн инженерчлэл нь ихэвчлэн ямар нэг яаралтай мэдрэмж түгшүүрийг бий болгосон зохиомол хомсдолыг үүсгэж байдаг. Тиймээс хэрэв танд даргаас чинь яаралтай мэдээлэл илгээхийг хүссэн имэйл ирсэн бол, эсвэл таны интернэт банкнаас таны дансанд халдлага хийхээр оролдсон байх тул яаралтай нэвтрэх нэр нууц үгээ оруулан баталгаажуулахгүй бол таны дансныг хаалаа гэсэн имэйл ирсэн бол яаран тэдний хүссэн үйлдлийг хийхээсээ өмнө нэг хором тайван бодсоноор эдгээр

халдлагыг таслан зогсоож тэднийг ямар хуурамч болохыг илчлэн ирээдүйд ирэх гарз хохирлоос өөрийгөө болон дотно хүмүүсээ хамгаалж чадах юм.

Иймд утсаар мэдээлэл өгөх эсвэл холбоос дээр дарахын оронд албан ёсны дугаар руу залгаж аль эсвэл албан ёсны веб сайтын URL-аар орж шалгаарай. Мөн эх сурвалжийн найдвартай байдлыг шалгахын тулд харилцааны өөр аргыг ашигла. Жишээлбэл, хэрэв та найзаасаа мөнгө шилжүүлэхийг хүссэн имэйл, чат хүлээн авбал утас руу нь залгаж үнэхээр тэд мөн эсэхийг шалгаж байх хэрэгтэй.

Ашигласан материал:

1. Гүйцэтгэх ажилтан гарын авлага төсөл 2023 он
2. Human hacking: win friends, influence people, and leave them better off for having met you, 2021.
3. Руководство по защите от хакеров/ Коул Эрик. Пер. с англ. – М. Издательский дом «Вильямс», 2002.
4. <https://www.kaspersky.com>
5. <https://www.cisco.com>

МОНГОЛ УЛСАД 2018-2022 ОНУУДАД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ГЭМТ
ХЭРГИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ
ANALYSIS OF THE GENERAL CONDITIONS OF CRIMES
REGISTERED IN MONGOLIA IN 2018-2022

Б.Баярболд

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн
багш, цагдаагийн ахлах дэслэгч
/хууль зүйн магистр/

Bayarbold B.

Police school at University of Internal Affairs,
Department of criminal law and criminology,
lecturer, police senior lieutenant
/master of law/

Хураангуй: Монгол улсад сүүлийн 5 жилийн хугацаанд Ковид-19 цар тахал, түүнтэй холбоотой эдийн засгийн хямрал газар авч, зарим төрлийн аж, ахуй нэгжүүд хаалгаа барьж, хувиараа хөдөлбөр эрхлэгчдэд хүнд цохилт өгсөн билээ. Үүнийг дагаад Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хөдөлгөөнд мөн өөрчлөлт орсон ба чухамхүү ямар төрлийн гэмт хэрэгт өөрчлөлт орж байгааг судлан харуулахыг зорьсон.

Abstract: Over the past 5 years, the Covid-19 epidemic and the economic crisis related to it have spread in Mongolia, some businesses and enterprises have closed their doors, and self-employed people have been hit hard. Along with this, the number and movement of crimes registered in Mongolia has also changed, and it is intended to study and show what kind of crimes are changing.

Түлхүүр үг: Гэмт хэргийн хөдөлгөөн, гэмт хэргийн түвшин, бүртгэгдсэн гэмт хэрэг, нийт гэмт хэрэг, ковид-19 цар тахал

Keywords: Crime movement, crime rate, reported crime, total crime, covid-19 pandemic


Монгол улсад 2015 оны шинэчлэн батлагдсан эрүүгийн хууль 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн билээ. Тухайн хууль тогтоомжид зарим үйлдэл, эс үйлдэхүйг шинээр гэмт хэрэгт тооцож, өмнө нь гэмт хэрэгт тооцдог байсан зарим заалтыг хасаж хуульчилсан. Уг хууль хэрэгжиж, нэг жилийн хугацаа өнгөрсөний дараа буюу 2018 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоог судалгааны эх болгож, түүнтэй харьцуулах замаар сүүлийн 5 жилд Монгол Улс дахь гэмт хэргийн нийт тоо, түүний өсөлт, бууралт, хөдөлгөөнийг, мөн түүнчлэн тэдгээрийн өөрчлөлтөд нийгэм, эдийн засгийн байдал хэрхэн нөлөөлж байгааг тухайн судалгааны явцад харуулав.

Судалгааны он жилүүдэд буюу 2020-2022 онуудад Ковид-19 цар тахал Монгол Улсад газар авч, хөл хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотойгоор тодорхой төрлийн гэмт хэрэг эрс өсч, мөн зарим төрлийн гэмт хэргийн гаралт эрс буурсан үзүүлэлттэй байна. Ялангуяа хорио цээрийн дэглэм арилсан буюу 2022 онд ч хөл хорио тогтоож байснаас

улбаалан өсөн нэмэгдсэн гэмт хэргийг статистик мэдээллийг судлан, харьцуулах замаар харуулав.

Монгол улсад сүүлийн 5 жилд буюу 2018-2022 онд нийт **151977** гэмт хэрэг бүртгэгдсэнээс жилд дунджаар **30395** гэмт хэрэг, хоногт дунджаар **83** гэмт хэрэг бүртгэгдсэн байна.


График №1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг



Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргээс үзвэл 16-аас дээш насны 10000 хүн тутамд 169 гэмт хэрэг оногдож байна.


Монгол улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргүүдийг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бүлэг тус бүрээр нь дүн шинжилж, түгээмэл үйлдэгдэж буй гэмт хэргийн графикт харуулав.

График №2. Улсын хэмжээнд бүртгэгдсэн Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг /2018-2022 он/



Монгол Улсын нутаг дэвсгэрт Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг нийт **2658** буюу жилд дунджаар **532** бүртгэгдсэн байна. Гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл:


График №3. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг /2018-2022 он/



Сүүлийн 5 жилийн хугацаанд:

- Хүнийг алах (ЭХТА 10.1) гэмт хэрэг нь нийт **974** бүртгэгдэж, жилд дунджаар **195** бүртгэгдсэн байх бөгөөд графикаас харахад бүртгэгдсэн тоо алгуур өсөх хандлагатай байна.
- Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (ЭХТА 10.4) гэмт хэрэг нь нийт **1381**, жилд дунджаар **276** бүртгэгдсэн байгаа ба цагдаагийн байгууллагад бүртгэгдэж буй нас барсан тухай дийлэнх гомдол мэдээлэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.4 дүгээр зүйлд зааснаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээдэг нь тухайн төрлийн гэмт хэрэг ихээр бүртгэгдэж байгаа шалтгаан юм.
- Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох (ЭХТА 10.6) гэмт хэрэг нь нийт **322** үйлдэгдсэн бөгөөд тухайн төрлийн гэмт хэрэг цаашид өсөх хандлагатай байгаа нь графикаас харагдаж байна.


График №2. Улсын хэмжээнд бүртгэгдсэн Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /2018-2022 он/



Монгол улсын нутаг дэвсгэрт Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг нийт **41767** буюу жилд дунджаар **8353** бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл:

График №3. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /2018-2022 он/




Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (ЭХТА 11.1) гэмт хэрэг нь графикаас харахад өссөн үзүүлэлттэй, Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах (ЭХТА 11.3) гэмт хэрэг сүүлийн 3 жилийн турш хэвийн түвшинд байна, Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (ЭХТА 11.4) гэмт хэрэг сүүлийн 3 жилийн хугацаанд өссөн үзүүлэлттэй, Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай

учруулах (ЭХТА 11.6) гэмт хэрэг 2022 оны байдлаар огцом өссөн үзүүлэлттэй ба тухайн гэмт хэрэг цаашид өсөх хандлагатай байна, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх (ЭХТА 11.7) гэмт хэрэг буурч байгаа үзүүлэлттэй байна.¹⁴


Монгол улсын нутаг дэвсгэрт Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заагдсан гэмт хэрэг нийт **2954** буюу жилд дунджаар **591** бүртгэгдсэн байна.

График №4. Улсын хэмжээнд бүртгэгдсэн Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /2018-2022 он/



Гэмт хэргийн төрлөөр нь үзвэл:

График №5. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /2018-2022 он/



Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заагдсан гэмт хэргүүдээс Хүчиндэх (ЭХТА 12.1) гэмт хэрэг хамгийн түгээмэл үйлдэгдсэн бөгөөд 5 жилийн хугацаанд нийт 2390 үйлдэгдсэн нь тухайн гэмт хэрэг цаашид нэмэгдэх хандлагатай байгаа нь графикаас харагдаж байна.

Бэлгийн дүр хүслээ хангах (ЭХТА 12.2) гэмт хэрэг, Бэлгийн мөлжлөг (ЭХТА 12.3) гэмт хэргүүдийн хөдөлгөөн тогтвортой байна.


Монгол улсын нутаг дэвсгэрт Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэгт заагдсан нийт **867** буюу жилд дунджаар **173** бүртгэгдсэн байна.

График №6. Улсын хэмжээнд бүртгэгдсэн Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг /2018-2022 он/



Гэмт хэргийн төрлөөр нь үзвэл:

График №7. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг /2018-2022 он/




Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.5 дугаар зүйлд заагдсан Заналхийлэх гэмт хэрэг сүүлийн 5 жилийн хугацаанд нийт **243** удаа, жилд дунджаар **49** бүртгэгдсэн бөгөөд цаашид өсөх хандлагатай байна. Тухайн гэмт хэргийн гаралтаас урьдчилсан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай. Бусад төрлийн гэмт хэргүүд буурах, тогтвортой байх хандлагатай байгаа нь графикаар тодорхойлогдож байна.

График №7. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг /2018-2022 он/



Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлэгт заагдсан Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг **157** удаа, жилд дунджаар **31** удаа бүртгэгдсэн байна.

График №8. Монгол улсад бүртгэгдсэн Хүүхдийн эсрэг гэмт хэрэг /2018-2022 он/



Гэмт хэргийн төрлөөр нь үзвэл:


График №9. Хүүхдийн эсрэг гэмт хэргийг төрлөөр нь үзвэл /2018-2022 он/



Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт заасан Хүүхдийн эсрэг гэмт хэргийн төрлөөр нь авч үзэхэд дээрх 2 төрлийн гэмт хэрэг түлхүү үйлдэгдэх бөгөөд улсын хэмжээнд Хүүхдэд


садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэргийн гаралт 24-өөр өссөн байгаа тул тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай байна.

График №10. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг /2018-2022 он/



Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар бүлэгт заагдсан Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг судалгааны хугацаанд 65527 удаа бүртгэгдсэн нь бусад бүлэгтэй харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлттэй байх ба 2022 оны байдлаар өмнөх оны мөн үеэс 64%-аар өссөн ба цаашид ч мөн өсөх хандлагатай байна. Энэ нь улсын эдийн засаг, ажилгүйдэл, иргэдийн амар хялбар аргаар мөнгө олох хүсэл эрмэлзэл гэх мэт хүчин зүйлсээс хамааралтай.

График №11. Өмчлөх эрхийн эсрэг гэмт төрлөөр нь үзвэл /2018-2022он/




Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс Залилах (ЭХТА 17.3) гэмт хэрэг 2022 оны байдлаар огцом өссөн ба, Хулгайлах (ЭХТА 17.1) гэмт хэрэг аажмаар өсөн нэмэгдэж байна. Харин графикт байгаа бусад гэмт хэрэг ковид-19 цар тахалтай холбоотой хорио цээрийн дараагаар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Цахим хэрэглээ нэмэгдэхийн хэрээр цахим хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслийн тусламжтайгаар Залилах гэмт хэрэг сүүлийн жилүүдэд огцом өсөн нэмэгдэж байгаа ба 2022 оны байдлаар өмнөх оны мөн үеэс 55.4%-аар өссөн нь иргэдийн амар хялбар аргаар мөнгөө өсгөх, тухайн гэмт хэргийн талаарх суурь ойлголт дутмаг байдлаас улбаатай ба цаашид ч эрс нэмэгдэх хандлагатай байна. Улсын хэмжээнд Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Мөн түүнчлэн хулгайлах гэмт хэрэгтэй эрчимтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг идэвхжүүлэх шаардлагатай ба, иргэдийн сонор сэрэмж, анхааралтай байдал, аж ахуй нэгж, байгууллагын, гудамж талбайн хяналтын камерыг сайжруулах, тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинэ технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

График №12. Эдийн засгийн гэмт хэрэг /2018-2022 он/




Эдийн засгийн гэмт хэрэг нь ковид-19 цар тахлын хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор буурсан боловч, сүүлийн 2 жил аажмаар өссөн байна.

График №13. Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг /2018-2022он/




Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралтын тоо жил ирэх тусам буурсан эерэг үзүүлэлттэй байна.

График №14. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг /2018-2022он/




Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн гаралтын тоо 2021 онд өмнөх оны мөн үеэс 2.5 дахин эрс өссөн боловч, 2022 онд өмнөх оны мөн үеэс 35.9% эрс буурч байгаа эерэг үзүүлэлттэй байна.

График №15. Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг /2018-2022он/



Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн гаралтын тоо 2021 онд аажмаар буурсан боловч, 2022 оны байдлаар 42 гэмт хэргээр өссөн үзүүлэлт бүртгэгдсэн байгааг анхаарч, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

График №16 Авилгын гэмт хэрэг /2018-2022он/



Авилгын гэмт хэрэг нь ковид-19 цар тахалтай холбоотой хорио цээрийн үед огцом буурсан буюу 2020 оны байдлаар өмнөх оны мөн үеэс 65 дахин буурсан эерэг үзүүлэлт харагдах боловч 2021 оноос эхлэн тус гэмт хэргийн гаралтын тоо аажмаар нэмэгдсэн. Харин 2022 оны байдлаар өмнөх оны мөн үеэс даруй 79 гэмт хэргээр хэргээр их бүртгэгдэж байгаа нь тухайн гэмт хэрэг цаашид ч огцом өсөх хандлагатай байгааг анхаарч, бууруулах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

График №17 Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг /2018-2022он/




Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн гаралтын тоо 2019 оны байдлаар өмнөх оны мөн үеэс 43.8%-аар өссөн, 2020 оны байдлаар хандлагатай байгааг анхаарах шаардлагатай байна.



График №18 Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг /2018-2022он/

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн гаралтын тоо сүүлийн 3 жилийн хугацаанд 62 гэмт хэргээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

График №19 Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг /2018-2022он/




Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг сүүлийн 5 жилийн байдлаар улсын хэмжээнд 30 үйлдэгдсэн боловч, тухайн гэмт хэрэг аажмаар өсөж буй сөрөг үзүүлэлттэй байна.

График №20 Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг /2018-2022он/




Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2020 оны байдлаар өмнөх оны мөн үеэс 31.5 дахин өссөн байгаан нь ковид-19 цар тахалтай холбоотой хорио цээрийн үед иргэдийн цахим хэрэглээ ердийн үеэс мөн хэмжээгээр нэмэгдэж, улмаар тухайн гэмт хэргийн тоо эрс өссөнийг харуулж байна. 2021 онд өмнөх оны мөн үеэс 11 дахин буурсан ба тухайн гэмт хэрэг аажмаар өсөх хандлагатай байна.

График №21 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг



Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг нь 2020 онд өмнөх оны мөн үеэс 291 гэмт хэргээр бага бүртгэгдсэн боловч цаашид аажмаар өсөх хандлага ажиглагдаж байна.

График №22 Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг



Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг хэрэг нь 2018-2022 оны байдлаар улсын хэмжээнд нийт 54 үйлдэгдсэн ба тухайн гэмт хэргийнг хөдөлгөөн тогтвортой байна.

Монгол улсын хэмжээнд 2018-2022 оны хооронд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо мэдээ.

№	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн гэмт хэрэг				
	Он	2018	2019	2020	2021	2022
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	714	636	382	448	532
	Үүнээс: Хүнийг алах	192	197	192	194	199
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	459	377	122	171	252

Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох		53	59	59	72	79	
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	9134	8265	7405	7637	9326	
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах		295	238	301	370	411	
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах		31	34	40	40	40	
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах		401	319	523	607	58	
Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах		8128	7391	6373	6453	6079	
Гэр бүлийн хүчирхийлэл		210	207	111	118	98	
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	621	610	505	540	678	
Үүнээс: Хүчиндэх		519	481	401	439	550	
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	115	115	189	210	238	
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	6	3	5	2	4	
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	33	39	22	28	35	
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	21	31	17	31	54	
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	22468	18341	12061	13632	21493	
Үүнээс:		Хулгайлах	12328	8968	5100	4579	6077
		Залилах	5372	4668	4270	6558	11839
		Дээрэмдэх	1497	868	404	366	485
		Мал хулгайлах	1096	1809	1041	736	778
9	Эдийн засгийн гэмт хэрэг	242	247	123	158	162	
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	99	29	1	2	0	
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	314	333	291	756	359	
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	196	172	80	52	94	
13	Авлигын гэмт хэрэг	362	523	8	15	13	
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	237	341	211	232	296	
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг	366	489	622	601	559	

	гэмт хэрэг					
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	3	5	5	8	9
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	42	57	1795	151	259
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1231	1276	985	915	1220
Үүнээс: Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1215	1263	981	912	1214
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	15	12	6	11	10
20	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	1	0	0	0	0
Нийт		36220	31524	23064	25429	35340

Олон улсад үйлдэгдсэн гэмт хэргийн ерөнхий нөхцөл байдал

Дэлхийн хот, улс орнуудын хамгийн том мэдээллийн сан болох Numbeo дэлхийн улс орнуудын аюулын түвшний статистикийг нийтэлжээ (Дэлхийн улс, орнуудын гэмт хэргийн индекс). Мэргэжилтнүүд дор дурдсан орнуудын нутаг дэвсгэрийн аюулын зэргийг хүнийг санаатай алах, дээрэмдэх, хүчиндэх гэх мэт хүч хэрэглэсэн гэмт хэрэг бүртгэгдсэн байдлаар нь дүгнэн гаргасан байна.


Үүний зэрэгцээ үнэлгээний мэдээллийн гол эх сурвалж нь эдгээр орны оршин суугчид болон тэдэнд ирсэн жуулчдын тойм байв. Гэмт хэргийн индекс 20-оос доош байвал тус улсад гудамжинд үйлдэгдэх гэмт хэргийн гаралт нэн ховор, 20-40 бол гэмт хэргийн түвшин бага, 40-60 бол дунд, 60-80 бол өндөр, 80-аас 100 хүртэл бол гэмт хэргийн хохирогч болох магадлал хамгийн их байна.

№	Улс	Гэмт хэргийн индекс	Аюулгүй байдлын индекс
1	Венесуэл	83.76	16.24
2	Папуа Шинэ Гвиней	80.79	19.21
3	Өмнөд Африк	76.86	23.14
4	Афганистан	76.31	23.69
5	Гондурас	74.54	25.46
6	Тринидад Тобаго	71.63	28.37
7	Гайана	68.74	31.26
8	Сальвадор	67.79	32.21

9	Бразил	67.49	32.51
10	Ямайка	67.42	32.58

36	Uganda	55.9	44.1
37	Maldives	55.2	44.8
38	France	54.6	45.4
39	Tanzania	54.4	45.6
40	Mexico	54.1	45.9
41	Kyrgyzstan	53.9	46.1
42	Costa Rica	53.7	46.3
43	Mongolia	53.5	46.5
44	Cambodia	53.0	47.0
45	Botswana	52.6	47.4
46	Belize	52.3	47.7
47	Uruguay	51.9	48.1
48	Malaysia	51.6	48.4
49	Belarus	51.4	48.6
50	Algeria	51.4	48.6
51	Ethiopia	51.4	48.6
52	North Korea	50.7	49.3
53	Paraguay	50.6	49.4
54	Nicaragua	50.2	49.8
55	Myanmar	50.0	50.0
56	Iran	49.8	50.2
57	United States	49.2	50.8
58	Belgium	48.9	51.1

Crime Index by Country 2023 Mid-Year



Монгол улсын хувьд тухайн статистикийн жагсаалтад 2023 оны байдлаар нийт 144 орноос гэмт хэргийн индексээр 53.5 буюу ДУНД, аюулгүй байдлын индексээр 46.5 буюу мөн ДУНД үнэлгээтэйгээр 43 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна¹⁵.

ДҮГНЭЛТ:

Монгол улсад 2018-2022 онуудад бүртгэгдсэн гэмт хэргийн тоог харьцуулан судлахад хамгийн их өөрчлөлттэй байгаа нь Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг байна. Судалгааны он жилүүлд буюу 2020-2022 онуудад Ковид-19 цар тахал Монгол Улсад газар авч, хөл хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотойгоор тодорхой төрлийн гэмт хэрэг эрс өсч, мөн зарим төрлийн гэмт хэргийн гаралт эрс буурсан үзүүлэлттэй байна.

Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг хэрэг нь 2020 оны байдлаар өмнөх оны мөн үеэсээ 31.5 дахин өссөн байгаан нь ковид-19 цар тахалтай холбоотой буюу хорио цээрийн үед иргэдийн цахим хэрэглээ ердийн үеэс мөн хэмжээгээр нэмэгдэж, улмаар тухайн гэмт хэргийн тоо эрс өссөнийг харуулж байна. 2021 онд өмнөх оны мөн үеэс 11 дахин буурсан ба цаашид аажмаар өсөх хандлагатай байгааг харуулж байна.

Хорио цээрийн дэглэм арилсан буюу 2022 онд ч хөл хорио тогтоож байснаас улбаалан өсөн нэмэгдсэн гэмт хэргийг статистик мэдээллийг судлан үзэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, тэр дундаа “Залилах” гэмт хэргийн тоо эрс өссөн үзүүлэлттэй байна.

Залилах гэмт хэргийн онцлог нь хохирогч нь тухайн гэмт хэрэгт хохирогч болсон талаараа хожуу ухаардаг, мөн түүнчлэн Ковид-19 цар тахалтай холбоотой хорио цээрийн

¹⁵ [Crime Index by Country 2023 Mid-Year \(numbeo.com\)](https://numbeo.com/crime-index-by-country-2023-mid-year/)

үед санхүүгийн хүнд байдалд орсон иргэд, аж ахуй эрхлэгч нар бусдад өр зээл ихээр тавих, зарим тохиолдолд санхүүгийн асуудлыг шийдвэрлэхийн тулд гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж, аргацаалж явсаар улмаар хохирсон иргэд нь 2022 онд цагдаагийн байгууллагад хандаж, улмаар гэмт хэргийн тоо өсгөсөн үзүүлэлт харагдаж байна.

Бусад гэмт хэргүүдийн хувьд гарсан эрс өөрчлөлтүүд байхгүй байгаа нь сайшаалтай хэдий ч буурахгүй, цаашид өсөх төлөвтэй байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. [Mongolia Corruption Index - 2022 Data - 2023 Forecast - 1999-2021 Historical - Chart \(tradingeconomics.com\)](https://tradingeconomics.com/mongolia/corruption-index)
2. С.Гантулга., Б.Энхболд., Эрүүгийн эрх зүй тусгай анги., 2020он., УБ.,
3. [Статистик тоон мэдээлэл \(police.gov.mn\)](https://police.gov.mn)
4. [Crime Index by Country 2023 Mid-Year \(numbeo.com\)](https://numbeo.com/crime-index-by-country)

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧ ЭТГЭЭДИЙН
ПРОФАЙЛИНГ, НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН ОНЦЛОГ
PROFILING AND SOCIO-PSYCHOLOGICAL CHARACTERISTICS
OF PERPETRATORS OF DOMESTIC VIOLENCE**

Г.Болор-Эрдэнэ

ДХИС-ийн Удирдлагын академийн
ахлах багш, доктор (Ph.D)

Bolor-Erdene.G

University of internal affairs, Mongolia
Academy of Governance teacher doctor Ph.D

Хураангуй: Энэхүү өгүүлэлээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн профайлинг болон нийгэм сэтгэл зүйн онцлогийг тодорхойлж энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг оновчтой зохион байгуулах талаар үнэлэлт дүгнэлт өгч шалтгаан нөхцлийг тайлбарласан.

Abstract: In this article, the determine the profile and socio-psychological characteristics of persons who have committed domestic violence, gave an assessment and explained the reasons for the optimal organization of measures to prevent this type of crime.

Түлхүүр үгс: Гэр бүл, баривчлах шийтгэл, сэтгэл зүй, гэмт хэрэг

Key words. Family, imprisonment, psychology, crime

Оршил

Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн хамгийн том зөрчлийн нэг төдийгүй энэ төлийн гэмт хэрэг, зөрчлийн хохирогчдын дийлэнх нь хүүхэд, эмэгтэйчүүд байдаг. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Байгууллагын мэдээлснээр дэлхий дээр 2020 онд 15-49 насны 243 сая охид, эмэгтэйчүүд нөхөр, хамтрагчийн зүгээс бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна.

Энэ талын мэдээлэл дутмаг, далд хэлбэртэй байдгаас гэр бүлийн болон бусад төрлийн хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авахад бэрхшээлтэй тулгардаг. Тухайлбал, хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийн 40 хүрэхгүй хувь нь аливаа төрлийн тусламж хүсдэгээс 10 хүрэхгүй хувь нь цагдаад ханддаг байна.

Монгол Улс 2016 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлан, 2017 оноос эхлэн мөрдөж эхэлсэн, мөн 2015 онд анх удаа “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” үйлдлийг бие даасан гэмт хэрэгт тооцон Эрүүгийн хуульдаа тусгасан бөгөөд зарим төрлийн гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд оруулсан болно.

Үүний зэрэгцээ Зөрчлийн тухай хуульд “гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” хэмээх зөрчлийг тусгаж, хүлээлгэх хариуцлагыг тогтоосон билээ. Эдгээр хууль хэрэгжээд багагүй хугацаа өнгөрч байгаа тул гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд гарч буй ахиц дэвшил, тулгамдсан асуудлыг тодруулах шаардлага зүй ёсоор урган гарч байна.


Бид энэхүү судалгааны ажлын хүрээнд Эрүүгийн хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн буюу 2017 оноос хойш гэмт хэрэг, зөрчлийн тоо, мэдээнд дүн шинжилгээ хийлээ.

Монгол Улсын хэмжээнд 2017 оноос 2022 оны хооронд нийт 183.836 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас 7577 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.¹⁶

Бид энэхүү судалгааны ажлын хүрээнд Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн профайлин, нийгэм-сэтгэл зүйн онцлог тодорхойлох зорилгоор шүүхээс баривчлах шийтгэл оногдуулсан баривчлах шийтгэлээ эдэлж байгаа 100 гаруй холбогчийг судалгаанд хамруулсан.


Үндсэн хэсэг

График 1. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарын насны байдал



Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж баривчлах шийтгэл эдэлж байгаа холбогдогч нарыг насны байдлаар нь авч үзэхэд нас ахих тусам гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх магадлал өндөрсөж байгаа зураглал судалгааны үр дүнгээс харагдаж байна. Нийгэмд өөрийн байр сууриа эзэлсэн, тогтсон ажил, амьдрал, гэр бүлийн хувьд төлөвшсөн хүмүүс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэггүй гэсэн иргэд, олон нийтийн хандлага нийгэмд түгээмэл байгаа ч судалгааны ажлын үр дүн нь энэ хандлагын эсрэг байгаа нь анхаарал татаж байна.

График 2. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн боловсролын түвшин



нийт санал асуулгад оролцсон холбогч нарын 52 хувь нь бүрэн дунд, 19 хувь дээд, 16 хувь тусгай дунд, 9 хувь бүрэн бус дунд, 4 хувь бага боловсролыг тус тус эзэмшсэн байна. Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд боловсролын түвшин нэмэгдэх тусам гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх магадлал өсөж байгаа чиг хандлага ажиглагдаж байна.


¹⁶ ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн тайлан 2022 он

График 3. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн ажил эрхлэлтийн байдал



Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь авч үзэхэд 49 хувь нь эрхэлсэн ажилгүй, 23 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 12 хувь нь малчин, 9 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг, 5 хувь нь төрийн алба хаагч, 2 хувь нь төрийн бус байгууллагад тус тус хөдөлмөр эрхэлж байна.

График 4. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн ам бүлийн байдал



Хүчирхийлэлд шууд болон дам байдлаар хохирч байгаа гэр бүлийн гишүүд, хохирогч нарыг тодорхойлох зорилгоор судалгаанд хамрагдсан холбогдогч нарын ам бүлийн байдлыг тодорхойлоход холбогдогчийн гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн үйлдлийн улмаас хохирсон хохирогч нарын 67 хувь нь эхнэр, хүүхэдтэйгээ амьдардаг, 18 хувь нь хадам аав, ээж, эхнэр хүүхэдтэйгээ, 11 хувь нь эхнэр болон дагавар хүүхэдтэйгээ, 4 хувь нь өөрийн төрсөн аав, ээж ах, дүү нартайгаа амьдарч байна. Дээрх асуулгын үр дүнг нэгтгэн дүгнэхэд нийт холбогч нарын гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн үйлдлийн улмаас шууд болон дам байдлаар хохирсон хохирогч нарын 96 хувь нь хүүхэд, эмэгтэйчүүд өртөж хохирч байна.


Мөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж баривчлах шийтгэл эдэлж байгаа холбогдогч нарын 11 хувь нь эхнэр, дагавар хүүхдийн хамтраар амьдардаг талаараа хариулсан байдлаас дүгнэхэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг зөрчлийн улмаас дагавар болон үрчилж авсан хүүхэдтэй хохирсон байх боломжтой байна.

График 5. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн амьжиргааны түвшин




Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн амьжиргааны түвшинг түвшинг тодорхойлох асуулгад нийт судалгаанд оролцогчидын 52 хувь нь тийм ч хангалттай бус 39 хувь нь хангалттай, 9 хувь хангалтгүй гэж хариулсан.

График 6. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн урьд өмнө гэмт хэрэгт холбогдсон байдал




Баривчлах шийтгэл эдэлж байгаа холбогдогч нарын 6 хувь нь урьд өмнө ямар нэгэн байдлаар гэмт хэрэг зөрчилд холбогдож шалгадаж байсан бол 94 хувь нь гэмт хэрэг зөрчилд анх удаа холбогдож баривчлах шийтгэл эдэлж байгаа талаараа дурдсан байна.

График 7. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээд гэмт хэргийн улмаас урьд өмнө хохирч байсан байдал



Баривчлах шийтгэл эдэлж байгаа холбогдогч нарын 17 хувь нь урьд өмнө ямар нэгэн байдлаар гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирогч болж хохирч байсан бол 83 хувь нь гэмт хэрэг зөрчлийн улмаас хохирч байгаагүй талаараа хариулсан.

График 8. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн согтууруулах ундааны хэрэглээний талаар




Холбогч нарын согтууруулах ундааны хэрэглээний түвшин тодорхойлох зорилгоор асуусан асуултанд 6 хувь нь байнгын хэрэглээтэй, 19 хувь баяр ёслолоор хэрэглэдэг, 25 хувь сэтгэл гутарсан үедээ хэрэглэдэг, 50 хувь хааяа хэрэглэдэг гэж хариулсан бөгөөд согтууруулах ундааг хэрэглэдэггүй гэж хариулсан нэг ч тохиолдол алга байна.

График 9. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн сэтгэцэт нөлөөлөх эм бэлдмэл, мансууруулах бодисын хэрэглээний түвшин



Сэтгэцэт нөлөөлөх эм бэлдмэл, мансууруулах бодисын хэрэглээний түвшин тодорхойлох зорилгоор асуусан асуулга 6 хувь нь мансууруулах төрлийн бодис хэрэглэж үзсэн талаараа хариулсан бол 94 хувь нь хэрэглэж байгаагүй гэж хариулсан байна.

График 10. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдээс хүүхэдтэй ямар шалтгааны улмаас үл ойлголцолд хүрч байгаа талаар




Өөрийн болон үрчилж авсан хүүхэдтэйгээ ямар үед үл ойлголцолд хүрч байгаа талаар асуусан асуулгад нийт холбогдогч нарын 28 хувь нь учирлаж ярилцаад асуудлыг шийдвэрлэдэг, 19 хувь нь гадуур дэмий сэлгүүцсэн тохиолдолд үл ойлголцоход хүрч байна, 24 хувь нь хичээлийн даалгавараа хийж, гэр орны ажилд туслахгүй байна гэж, 11 хувь нь болж бүтэхгүй хүүхэдтэй нийлсэн гэж үл ойлголцолд хүрч байгаа талаараа хариулсан бол 18 хувь нь өөрийн болон дагавар үрчилж авсан хүүхэд байхгүй гэж хариулсан.

Хүүхэд хохирсон гэр бүлийн хүчирхийлэлийн шалтгаан нөхцөл хичээлийн дараах хараа хяналтгүй үл хайхрах байдлаас үүдэн найз нөхөдтэйгээ гадуур тэнэх, хичээлийн даалгавараа хийж, гэр орны ажилд туслахгүй байна гэж эцэг, эхтэйгээ үл ойлголцолд хүрч энэ үл ойлголцсон байдал нь цаашид хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлийн хохирогч болох нөхцлийг бүрдүүлж байна.

Мөн судалгаанд оролцсон холбогдогч нарын 18 хувь нь төрсөн болон үрчилж авсан хүүхэд байхгүй гэж хариулсан байдлаас дүгнэхэд эрүүл мэндийн шалтгаан эмэгтэйчүүд, эрчүүдийн дундах үргүйдэл нь гэр бүлийн хамтран амьдрагч эхнэр нөхрийн хооронд үл ойлголцол үүсгэж гэр бүлийн хүчирхийлэлийн хохирогч болох нэг хүчин зүйл болж байна гэж дүгнэж болохоор байна.

График 11. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн сэтгэл зүйн онцлог



Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч холбогдогч нараас хамтран амьдрагч эхнэр нөхөртэйгээ үл ойлголцолд хүрсэн үед стресс бухимдлаа хэрхэн тайлдаг талаарх асуулгад 5 хувь нь спортоор хичээлэлдэг, 8 хувь нь дотны найз нөхөдтэйгөө ярилцдаг, 17 хувь нь түр зуурын асуудал гээд буулт хийгээд өнгөрдөг, 25 хувь нь уур амьсгал намжтал дуугаа хураадаг, 18 хувь нь гадагш гарч танилын хүрээнд бага зэрэг пиво ууж суудаг, 11 хувь нь ажил дээрээ очиж ажлаа хийдэг, 1 хувь нь өөрийн болон хадам аав ээжтэйгээ ярилцдаг, 13 хувь нь болж бүтэхгүй байгаа зүйлийг нь хэлээд тайвширдаг гэж хариулсан бол мэргэжлийн сэтгэл зүйчид хандаж байсан талаар нэг ч хүн хариулаагүй байна.

холбогдогч нарын 87 хувь нь хамтран амьдрагч болон эхнэртэйгээ ярилцаж ойлголцолд хүрэхгүй тухай цаг үед асуудлыг шийдвэрлэхээс зайлсхийх, асуудлыг түр намжаах, бусдад сэтгэлээ нээж тайвширах, бага хэмжээтэй согтууруулах ундаа хэрэглэх зэргээр асуудлыг шийдвэрлэхгүй орхигдуулдаг сэтгэл зүйн онцлогтой байна.

График 12. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн сэтгэл санаа хямарсан үед стресс бухимдалаа хэрхэн тайлдаг талаар



Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн сэтгэл санаа хямарсан үед стресс бухимдалаа хэрхэн тайлдаг талаар асуулгын үр дүнгээс харахад нийт холбогдогч нарын 27 хувь нь Архи уумаар санагддаг, 21 хувь нь гэр бүл салах талаар боддог, 17 хувь нь дотны найз нөхөдтэйгээ ярилцдаг, 12 хувь нь ажил мэргэжлээ солих талаар бодох, 15 хувь нь эхнэр хамтран амьдрагчийн зан ааш болохгүй байгааг хэлдэг, 8 хувь нь өөрийн төрсөн ар гэрийнхэнтэйгээ ярилцдаг гэж хариулсан байна.

График 12. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн хамтран амьдрагч, эхнэрийн зан төлөвийг тодорхойлсон байдал



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч болсон хамтран амьдрагч болон эхнэрийн зан төлөвийг тодорхойлсон асуулгад холбогдогч нарын 26 хувь нь хамтран амьдрагч болон эхнэрээ огцом ууртай биеэ барих чадвар муу, 16 хувь нь нээлттэй олон найз нөхөдтэй, 5 хувь нь зожигдуу найз нөхөд цөөн, 13 хувь нь зан ааш тогтворгүй, 4 хувь нь зан ааш тогтвортой, 9 хувь нь бусадтай таарамж муу, 8 хувь нь бусадтай таарамж сайн, 10 хувь нь сэтгэлийн хөдөлгөөн ихтэй, 6 хувь нь сэтгэлийн хөдөлгөөн багатай, 3 хувь нь тайван дөлгөөн зан төлөвтэй гэж хариулсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас хохирогч болж байгаа эмэгтэйчүүдийн зан төлөвийн талаар судалгааны асуулгын үр дүнгээс хамгийн өндөр үзүүлэлтүүдийг авч дүгнэхэд зан төлөвийн хувьд нээлттэй, олон найз нөхөдтэй, огцом ууртай биеэ барих чадвар муу, сэтгэлийн хөдөлгөөн ихтэй, зан ааш тогтворгүй эмэгтэйчүүд хохирогч болох эрсдэл өндөр байгаа үр дүн харагдаж байна.

График 13. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг үл хайхрах хүчирхийлэлийн талаар

Үл хайхрах



Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нараас гэр бүлдээ зарцуулах цаг хугацаа хэр байдаг үл хайхрах хүчирхийлэлийн талаар асуусан асуулгад нийт судалгаанд оролцогч нарын 32 хувь нь ажил ихтэй болохоор гэр бүлдээ цаг гаргаж чаддаггүй, 26 хувь нь амралтын өдрүүдээр л цаг гаргаж чаддаг, 14 хувь нь хөдөө орон нутагт ростероор ажилладаг болохоор маш бага цаг зарцуулдаг, 28 хувь нь өдөр бүр цаг гаргадаг гэж хариулсан байна.

Дүгнэлт: Дээрх судалгааны үр дүнгээс оролцогч нарын 72 хувь нь гэр бүлийн өдөр тутамын амьдралд оролцож чадахгүй ажил эрхэлж цалин, орлого олж байгаа эерэг тал ажиглагдаж байгаа боловч энэ үйл хайхрах хүчирхийлэлийн төрөл нь гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх нэг шалтгаан нөхцөл болж байна.

ДҮГНЭЛТ

Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн профайлинг нийгмийн болон сэтгэл зүйн хүрээнд судалгааны үр дүнд үндэслэн тодорхойлсон болно.

Нийгмийн байдал: 35-50 хүртлэх насны, эрхэлсэн ажилгүй, эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлдэг, амьжиргааны түвшиний хувьд тийм ч хангалтай бус, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 10 хүн тутмын 2 нь урьд өмнө гэмт хэрэгт холбогдож, эсвэл гэмт хэргийн улмаас хохирч байсан, согтууруулах ундаа болон сэтгэцэт нөлөөлөх эм бэлдмэл, мансууруулах бодисын тогтмол хэрэглэдэг, хэрэглээтэй эрэгтэйчүүд байна.

Сэтгэл зүй байдал: Сэтгэл санааны хувьд асуудлыг хэрхэн даван туулах учраа олдоггүй, хамтран амьдрагч эхнэр нөхөртэйгээ үл ойлголцолд хүрсэн үедээ асуудлаас зугтаах, уур амьсгал намжтал дуугаа хураадаг, танилын хүрээнд согтууруулах ундааны хэрэглэж өөрт тулгарч байгаа асуудлаа мартахыг хичээдэг бусдаас өөрийн сайн сайхан чанарын талаар сонсож тайвширах хүсэлтэй эрчүүд байна.

Криминологийн социологийн онолын үүднээс судлагааны үр дүнгээс бий болсон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн профайлинг ашиглан гэмт хэрэгтэн бие хүн бий болсон шалтгаан нөхцлийг тайлбарлахад дараах үр дүн илэрч байна. Хүчирхийлэл үйлдэгч этгээдүүдийн насыг ашиглан өссөн орчин болон нийгмийн байдлыг тодорхойлов. Хүчирхийлэл үйлдэгч нар нь 35-50 хүртлэх насныхан байх тул 2023 оноос 35-50 гэсэн тоон үзүүлэлтийг хасаж үзэхэд 1973-1988 оны хооронд хүчирхийлэл үйлдэгч нар төрсөн үзүүлэлт гарч байна.

Тэд Социалист захиран тушаах, хяналтын тогтолцоонд өсөж, сурч, хүүхэд насаа өнгөрөөсөн бол тэднийг 5-17 настай байхад нь 1990 онд ардчилсан хувьсгалаар нийгмийн тогтолцоо бүхэлдээ өөрчлөгдөн Монгол Улсад ажилгүйдэл, архидалт, хүчирхийлэл,

өлсгөлөн, бараа бүтээгдэхүүний хомсдол, бусад улсын орны соёлын дайралт зэрэг нийгмийн хяналт бүхэлдээ алдагдсан үед хүчирхийлэлд дассан зохицож бага болон өсвөр насаа өнгөрүүлсэн бөгөөд тэднийг өссөн төлөвшсөн нийгмийн орчноос нь үүдэлтэй хүчирхийлэл үйлдэгч болсон байна гэж дүгнэж болохоор байна.

Санал. Гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, ажил арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд дараах ажлыг хийх шаардлагатай.

- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг эрт илрүүлэх талаарх арга хэмжээг нийгмийг хамарсан нийтлэг аргаар бус хот айл, баг, СӨХ, хорооны түвшинд зохион байгуулах

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн аюулын түвшинг бус төлөвшилийн түвшинг тогтоож дээрх түвшинээс хамраач төлөвшилийн түвшинд тохирсон арга хэмжээг хэрэгжүүлэх;

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн талаарх мэдээллийг бага насны болон сургуулийн хүүхэд ямар нэгэн байдлаар бусдад илэрхийлж байдаг тул цэцэрлэг сургуулийн багш ажилтан нар мэдсэн даруйд хамтарсан багт болон цагдаагийн байгууллагад мэдэгдэж байх тогтолцоог бүрдүүлэх,

- Континент анализын судалгааны үр дүнгээс харахад иргэд олон нийтийн зүгээс хүүхэд хохирсон гэр бүлийн хүчирхийлэл дээр маш ихээр хандаж сэтгэгдэл үлдээх үр дүн ажиглагдаж байгаа тул нийгмээс үзүүлж байгаа уг хандлагад нийцүүлэн хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг зохион байгуулах

- хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдүүдийн сүсэг бишрэлийг тодорхойлон тухайн урсгалын шашны байгууллагуудтай хамтарсан ажил, арга хэмжээ зохион байгуулах энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн гаралтыг саармагжуулах, бууруулахад чухал нөлөө үзүүлнэ.

Ашигласан материал

1. Монгол Улсын Эрүүгийн хууль
2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. www.legalinfo.mn
3. Цагдаагийн ерөнхий газар. www.police.gov.mn
4. Улсын ерөнхий прокурорын газар. <https://prokuror.mn/main>
5. ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн тайлан 2023 он
6. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн криминологи, виктимологийн судалгаа 2023 он

**МӨРДӨХ ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ АЛБАНЫ ДАРГЫН ЭРХ ХЭМЖЭЭ,
ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ**
POWERS OF THE HEAD OF THE INVESTIGATION DEPARTMENT, ITS LEGAL
REGULATION AND IMPLEMENTATION

Б.Одбаатар

*ДХИС-ийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын
багийн профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор,
цагдаагийн хурандаа*

Odbaatar.B

Professor, Professor's Team of Police Strategy Management, Executive Management
Academy, University of Internal Affairs, Mongolia, doctor of law (Ph.D),
Associate Professor, police colonel

Хураангуй. Энэхүү нийтлэлээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны даргын хуулиар олгогдсон эрх хэмжээ, түүний хууль зүйн үр дагавар, хэрэгжилтийн практик туршлага зэргийг судлан судлаачийн зүгээс үнэлэлт дүгнэлт өгөхийг зорилоо.

Abstract. In this article, the researcher aims to evaluate the legal powers of the head of the investigation department, its legal consequences, and the practical experience of its implementation.

Түлхүүр үгс: Мөрдөх шалгах ажиллагаа, мөрдөн шалгах алба, мөрдөн шалгах албаны дарга, мөрдөгчийн ур чадвар.

Key words: Investigation, investigation department, investigation department head, detective skills.

ОРШИЛ

Хууль сахиулах байгууллага тэр дундаа гэмт хэргийг илрүүлэх, нотлох, мөрдөн шалгах ажиллагаагаар хэргийн бодит байдлыг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлж байгаа мөрдөгчийн үйл ажиллагаанд хууль ёс, хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдал гарч, ард иргэдийн дунд ч тэдний үйл ажиллагааны шударга, ил тод байдалд итгэх итгэл төдийлөн сайнгүй, сэтгэл дундуур байгаа нь хуулийн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна. Иргэд, байгууллагаас 2022 онд ирүүлсэн цагдаа, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор гаргасан нийт гомдол, мэдээллийн 60-70 хувь нь цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаатай, түүний 50-60 хувь мөрдөгчийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан гомдол, мэдээлэл эзэлж байна. Тухайлбал, 2022 онд иргэд, байгууллагаас нийт 684 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасны 302 нь цагдаагийн алба хаагчдын, 158 нь мөрдөгчийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдол, мэдээлэл байна¹⁷.

Нөгөө талаар гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулж шалгаж тогтоох уламжлалт арга, тактик өнөөгийн шаардлагад нийцэхгүй цаашлаад хуучин арга барилаар тэмцэх боломжгүй болж, харин уг ажиллагаанд бусад өндөр хөгжилтэй орны

¹⁷ Цагдаагийн ерөнхий газар. Цагдаагийн байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайлан.

туршлагыг өөрийн орны онцлог нөхцөл байдалд тохируулан нэвтрүүлэх, шинжлэх ухаан, техникийн үсрэнгүй хөгжлийн ололт, амжилтыг ашиглах явдал зүй ёсоор шаардагдаж байна. Энэхүү үүссэн нөхцөл байдлын үндсэн дээр мөрдөгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах түүний үйл ажиллагаанд хууль ёс, хүний эрхийг хангах, зөрчил, дутагдал гаргахгүй байхад чиглэсэн бодитой ажлыг удирдлагын зүгээс хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Мөрдөгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагаанд бодит байдлаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажлыг орчин үеийн менежментийн удирдлагын онолтой хослуулан хэрэгжүүлж, улмаар эрх зүйн болон зохион байгуулалтын орчин нөхцлийг сайжруулан шинэ шатанд гаргаснаар дээрхи зөрчил, дутагдал гарахгүй байх нөхцөл боломжийг бүрдүүлнэ гэж дүгнэж байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Мөрдөн шалгах ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах гэдэг нь гэмт хэргийг нотлоход чиглэсэн мөрдөн шалгах ажиллагаа Монгол Улсын Үндсэн хууль¹⁸ болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль¹⁹-ийн заалт, шаардлагын дагуу явагдаж байгаа эсэхийг хэргийн явцад шалгаж илэрсэн зөрчлийг засуулах, уг ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах, хүний эрх, эрх чөлөө хууль ёс зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн үйлдлийг таслан зогсоох, мөрдөгчид дэмжлэг, туслалцаа үзүүлэх, цаашлаад мөрдөн шалгах ажиллагаа шуурхай, саадгүй явагдах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн мөрдөн шалгах албаны даргын зүгээс хэрэгжүүлж байгаа удирдлагын үйл ажиллагаа юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.3 дугаар зүйлд мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны даргын эрх хэмжээг хуульчилсан нь нэг талаас энэхүү субъектын бүрэн эрхийг хуулиар баталгаажуулсан сайн хэрэг боловч нөгөө талаас уг албан тушаалтан хэргийн мөрдөн шалгах ажиллагааны аль шатанд, түүнчлэн энэхүү ажиллагааны явцад үүссэн чухам ямар нөхцөл байдлын үед хуулиар олгогдсон эрх хэмжээгээ хэрэгжүүлэх нь тодорхой бус байна. Нэгэнт энэ талаар хуульд тодорхой тусгаж заагаагүй ч мөрдөх шалгах ажиллагаа явуулах албаны дарга нь гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтан болохынхоо хувьд мөрдөн шалгах ажиллагааны эцсийн зорилгыг хангахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүднээс өөрийн санаачлагаар мөрдөн шалгах ажиллагааны аль ч шатанд мөрдөгчид дэмжлэг, туслалцаа үзүүлэн хуулиар олгогдсон энэхүү эрх хэмжээгээ хэрэгжүүлэх ёстой. Мөрдөгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах эрх хэмжээ нь дараах зорилготойгоор хэрэгждэг. Үүнд:

- Мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгч алдаа, дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх;
- Мөрдөгчийн гаргасан алдаа, дутагдлыг илрүүлэх;
- Мөрдөн шалгах ажиллагааны үед гарсан алдаа, дутагдлыг залруулж түүнд мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

¹⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992 он. №1. Монгол Улсын Үндсэн хууль. 16 дугаар зүйл. 14 дүгээр хэсэг. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно.

¹⁹ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он. №23. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/. 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр баталсан. Цахим эх сурвалж, холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/12694>

➤ Мөрдөгчийг мэргэшүүлэн сургах, түүний дадлага, туршлага, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Мөрдөх албаны шат шатны даргын зүгээс мөрдөгчийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

1. Мөрдөн шалгах ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах замаар гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шуурхай зохицуулалт хийх;

2. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүргийг нэг, эсхүл хэд хэдэн мөрдөгчид даалгах;

3. Шаардлагатай гэж үзвэл тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорт мэдэгдэж хэргийг нэг мөрдөгчөөс нөгөө мөрдөгчид шилжүүлэх;

4. Хавтаст хэргийн материалтай биечлэн танилцах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, мөрдөгчид дэмжлэг үзүүлэх зорилгоор бичгээр зааварчилга өгч, биелэлтийг хангуулах;

5. Шаардлагатай тохиолдолд мөрдөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч хууль зөрчиж оролцогчид хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг хэлбэрээр явагдана.

Мэргэжлийн удирдлагаар хангах дээрхи эрх зүйн хэлбэр тус бүрийн онцлог, зорилго, чиглэлийн талаар дэлгэрэнгүй авч үзвэл:

1. Хавтаст хэргийн материалтай биечлэн танилцах. Мөрдөгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах хамгийн чухал хэлбэрийн нэг нь мөрдөн байцаах нэгж, тасаг, хэлтсийн дарга өөрийн удирдлагад байгаа мөрдөгчийн шалгаж байгаа эрүүгийн хэргийн материалтай биечлэн танилцаж түүнд мэргэжлийн заавар, зөвөлгөө өгөх явдал юм. Энэхүү ажиллагааны үед мөрдөн байцаах нэгж, тасаг, хэлтэс, газрын дарга нь мөрдөгчийн шалгаж байгаа хавтаст хэргийн материалтай биечлэн танилцаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

Мөрдөн шалгах ажиллагааны сүүлийн жилүүдийн практикаас дүгнэлт хийхэд албаны дарга хэргийн материалтай биечлэн танилцах ажиллагаа гол төлөв мөрдөгчийн гаргасан шийдвэрийг үндэстэй эсэхийг хянахад чиглэгдэж байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, гэмт хэргийн талаар ирүүлсэн гомдол, мэдээллийг шалгаад эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах эсвэл эрүүгийн хэрэг үүсгэх шийдвэр гаргах үед, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх шаардлагатай болсон үед түүнчлэн хэргийн мөрдөн шалгах ажиллагаа дуусч прокурорын хяналтад шилжих үед албаны дарга зайлшгүй хэргийн материалтай биечлэн танилцаж байна.

Гэхдээ зарим тохиолдолд энэхүү ажиллагаа нь чухал шаардлагатай цаг үедээ хэрэгжин мөрдөгчийг мэргэжлийн удирдлагаар хангаагүйн улмаас алдаа дутагдал гарсан жишээ баримтууд ч олноор байгаа нь одоогийн мөрдөн шалгах ажиллагаанд оршиж байгаа гол дутагдлын нэг юм²⁰.

Иймд мөрдөн байцаах нэгж, тасаг, хэлтсийн дарга өөрийн удирдлагад байгаа мөрдөгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, түүний шалгаж байгаа хэргийн материалтай биечлэн танилцаж мэргэжлийн заавар, зөвөлгөө өгөх хэлбэрийг байнга тасралтгүй явуулахаас гадна мөрдөгч нэг бүрт хүрч ажиллан түүнд байнгын

²⁰ Ж.Бямбадорж. Мөрдөн байцаалтын арга нь хэвээрээ байна. Эх сурвалж, холбоос: <http://mn-nhrc.org/index.php?newsid=5420>

туслалцаа үзүүлж, мөрдөн шалгах хэрэг бүрт хүрч анхаарал тавих нь чухал юм. Иймд мөрдөх албаны нэгж, тасаг, хэлтэс, газрын даргын эрүүгийн хэргийн материалтай биечлэн танилцах эрх хэмжээ нь мөрдөгчийн үйл ажиллагаанд гарч байгаа зөрчил, дутагдлыг илрүүлэх, цаашлаад түүнийг засаж, залруулан мөрдөн шалгах ажиллагааг хууль ёсны дагуу явуулахад шаардлагатай арга хэмжээг даргын зүгээс цаг алдалгүй авч хэрэгжүүлэх боломжийг олгож байгаа хамгийн үр өгөөжтэй хэлбэр гэж тодорхойлж болох юм.

Аль ч шатны мөрдөх албаны дарга өөрийн удирдлагад байгаа мөрдөгчийн шалгаж байгаа хэргийн материалтай биечлэн танилцах эрх хэмжээгээ хэрэгжүүлэхдээ дараах асуудалд гол анхаарлаа хандуулж мөрдөн шалгах ажиллагаа цаг тухайдаа, хууль ёсны дагуу, бүрэн хийгдэж байгаа эсэхийг тогтоож, түүнд үнэлэлт, дүгнэлт өгнө. Үүнд:

- Болсон үйл явдалд эрүүгийн хэрэг үүсгэх хангалттай үндэслэл байсан эсэх;
- Мөрдөн шалгах ажиллагаа (*хэргийн газрын үзлэг, нэгжлэг, хураан авах, оролцогчдын байцаах, мэдүүлэг авах, шинжээч томилох гэх мэт тодорхой төрлийн ажиллагаа*) цаг хугацаандаа хийгдсэн эсэх, түүний чанар, нотлох баримтыг цуглуулах ажиллагаа хуулийн заалт, шаардлагыг хангаж байгаа эсэх;
- Нотлох баримтын тал бүрийн байдал, мөрдөн байцаалтын ажиллагаа бүх талын, иж бүрэн байх нөхцөл бүрэн хангагдсан эсэх;
- Яллагдагчаар татах үндэслэл байсан эсэх, яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэл нь хуулийн заалт, шаардлагад нийцэж байгаа эсэх;
- Мөрдөн шалгах ажиллагаанд оролцогч бусад этгээдийн хуулиар олгогдсон эрх ашиг хангагдаж байгаа эсэх;
- Мөрдөн шалгах тодорхой ажиллагааг төлөвлөлтийн дагуу хийж гүйцэтгэхдээ цагдаагийн бусад нэгж, албадтай тухайлбал эрүүгийн албатай хамтран ажилласан байдал түүний үр дүн, чанар;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх бололцоог хангаж ажилласан байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (*нуугдмал хөрөнгө олж илрүүлэх, битүүмжлэх гэх мэт*);
- Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл байгаа эсэх зэрэг мөрдөн шалгах ажиллагааны тал бүрийн нөхцөл байдалтай биечлэн танилцаж мөрдөн шалгах ажиллагааны цаашдын чиг хандлагыг хуульд нийцүүлэн шуурхай явуулахад мөрдөгчид мэргэжлийн зөвлөгөөг өгнө.

Мөрдөх албаны дарга тодорхой график, хуваарийн дагуу аль ч хэргийн материалтай биечлэн танилцаж хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх бөгөөд харин мөрдөн шалгах ажиллагаа удаан хугацаагаар явагдаж байгаа эрүүгийн хэргүүд, түүнчлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдан удаан хугацаагаар хоригдож байгаа яллагдагчийн шалгагдаж байгаа хэрэг мөн нэмэлт ажиллагаа явуулахаар шүүх, прокуророос буцсан хэрэг, илрээгүй хүнд гэмт хэргүүд, насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн хэрэгт байнга анхаарал хандуулж эдгээр хэргийн явцтай тогтмол, цаг тухайд нь танилцаж мөрдөгчийг мэргэжлийн удирдлагаар хангах, заавар, зөвлөгөө өгөх ажиллагааг хэрэгжүүлж ажиллах ёстой.

2. Мөрдөн шалгах ажиллагаанд оролцох. Мөрдөх албаны нэгж, тасаг, хэлтэс, газрын даргын үйл ажиллагаанд оршиж байгаа гол дутагдлын нэг нь мөрдөгчийн шалгаж байгаа хавтаст хэрэгт явагдаж байгаа мөрдөн шалгах тодорхой ажиллагаанд цаг тухай бүр оролцохгүй байх, түүнчлэн мөрдөгчид мэргэжлийн заавар, зөвлөгөөг хэрэгцээ, шаардлагатай цаг үед нь өгөхгүй байгаа явдал юм. Үүнийг нөгөө талаас нь авч үзвэл мөрдөх албаны дарга нь мөрдөгч бүрийн ажиллагаанд өдөр бүр тогтмол оролцоод түүнд заавар, зөвлөгөө өгч ажиллах боломж тэр бүр байхгүй нь мэдээж. Гэхдээ мөрдөн шалгах

ажиллагааны олон жилийн практик үйл явцаас дүгнэхэд мөрдөх албаны болон бусад нэгж албадын дарга мөрдөн шалгах тодорхой чухал ажиллагаа тухалбал, хүний амь нас хохирсон болон бусад хүнд гэмт хэрэгт явуулах хэргийн газрын үзлэг, гэмт хэргийг илрүүлэхэд чиглэсэн бусад анхан шатны ажиллагаанд зайлшгүй оролцож мөрдөгчид мэргэжлийн туслалцаа, зөвлөмж өгч хамтран ажиллах нь туйлаас чухал байдаг.

Хэргийн газрын үзлэгт албаны дарга оролцоогүй, хэргийн газрын үзлэг чанаргүй хийгдсэн, мөрдөгчийн ур чадвар дутагдсан зэрэг олон нөхцөл байдлаас хэргийн илрүүлэлтийн хувь заяанд ч сөрөг нөлөө үзүүлж болно.

Өнөөдрийн мөрдөн шалгах ажиллагааны практик үйл явцаас харахад мөрдөх албаны нэгж, тасаг, хэлтэс, газрын дарга гол төлөв олны анхаарал татсан, түүнчлэн олон нийтийг цочроосон, нийгэмд түгшүүрт байдал бий болгосон хүнд хэрэг үйлдэгдсэн үед мөрдөн шалгах ажиллагаанд оролцож мөрдөгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах эрх хэмжээгээ хэрэгжүүлж байгаа нь ажиглагдаж байна.

Мөрдөх албаны болон бусад дэмжлэг үзүүлэх нэгж албаны дарга мөрдөгчийн ганцаараа хийж гүйцэтгэх боломжгүй бусдын дэмжлэг туслалцаа шаардлагатай бүх ажиллагаа эсвэл мэргэжлийн ур чадвар дутагдах тодорхой ажиллагаа бүрт биечлэн оролцож түүнд мэргэжлийн туслалцаа үзүүлж, удирдлага, зохион байгуулалтын шаардлагатай арга, ажиллагаагаар хангаж ажиллах ёстой.

Энэ нь мэдээж уг хэргийн мөрдөн шалгах ажиллагааны цаашдын хувь заяанд бодит байдлаар нөлөөлж гэмт хэргийг нотлох, үйлдсэн этгээдийг олж тогтооход чиглэсэн мөрдөн шалгах ажиллагаа тал бүрийн, бодитой байх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

3. Мөрдөгчид дэмжлэг үзүүлэх зорилгоор бичгээр зааварчилгаа өгч, биелэлтийг хангуулах. Мөрдөх албаны даргын зааварчилгаа нь зөвхөн бичгийн хэлбэрээр мөрдөгчид өгөгдөх ба түүнийг мөрдөгч заавал биелүүлэх үүрэгтэй, бие даасан баримт бичиг юм. Зааварчилгаа нь гэмт хэргийн талаархи нотлох баримтыг цуглуулах, шалгах, үнэлэхтэй холбоотой байхаас гадна эрүүгийн хэргийн талаар мөрдөгчийн гаргах шийдвэртэй холбоотойгоор өгөгдөж болно.

Мөрдөх албаны дарга гол төлөв дараах чухал шийдвэр гаргах чиглэлээр мөрдөгчид зааварчилгаа өгч байна. Үүнд:

- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг шалган уг үйл явдалд хавтаст хэрэг үүсгэн цаашид мөрдөн шалгах ажиллагаа явуулах үндэслэл байгаа эсэх;
- Яллагдагчаар татах хангалттай үндэслэл байгаа эсэх;
- Гэмт хэргийн зүйлчлэл оновчтой эсэх;
- Яллагдагчийн гэм буруугийн нотлогдох байдал;
- Яллагдагчид авах таслан сэргийлэх арга хэмжээний төрөл зэргийн талаар бичгээр мөрдөгчид зааварчилгаа өгнө.

Мөрдөн шалгах ажиллагааны сүүлийн жилүүдийн практик туршлага болон мөрдөх нэгжийн жилийн ажлын тайлан дүн мэдээний статистик тоо мэдээ баримтаас дүгнэлт хийхэд төв, орон нутгийн мөрдөн албаны дарга нар өөрийн удирдлагад байгаа мөрдөгчид бичгээр зааварчилгаа өгч биелэлтийг нь хангуулах ажиллагаа зохих түвшинд хэрэгжиж байгаа нь харагдаж байна. Энэ нь мөрдөх албаны даргын ажлыг үнэлэх, дүгнэх үзүүлэлтэд мөрдөгчид бичгээр зааварчилгаа өгч биелэлтийг нь хангуулж байх тухай үзүүлэлт орсон нь энэхүү эрх хэмжээг хуулиар тогтоосон бусад эрх хэмжээнээс илүүтэйгээр хэрэгжүүлсэн байгаа нь ажиглагдаж байна.

Гэхдээ мөрдөх албаны нэгж, тасаг, хэлтэс, газрын дарга өөрийн удирдлагад байгаа мөрдөгчийн шалгаж байгаа эзэн холбогдогч нь тогтоогдоогүй байгаа хэрэг, хүнд гэмт хэрэг, бусад олны анхаарал татсан ээдрээ, төвөгтэй хэрэг бүрийн явцтай биечлэн танилцаж улмаар цаашид хийх ажиллагаа, анхаарах асуудал, бусад шаардлагатай ажиллагааны талаар бичгээр зааварчилгаа өгч мэргэжлийн туслалцаа үзүүлж, удирдлагаар хангаж ажиллах нь түүний ажлын гол үзүүлэлтийн нэг юм. Мөн үүнээс гадна мөрдөгчид амаар зааварчилгаа өгч биелэлтийг нь хангуулж ажиллах боломж бий юу? гэсэн асуулт зүй ёсоор тавигдана. Хууль зүйн учир холбогдол талаас нь авч үзвэл хавтаст хэрэгт мөрдөгчид амаар зааварчилгаа өгөх, түүний биелэлтийг хангуулж ажиллах эрх хэмжээний талаар одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд огт тусгаагүй байна.

Гэтэл мөрдөн шалгах хойшлуулашгүй ажиллагаа, мөн цаг хугацаа давчуу, тулгамдсан нөхцөл байдлын үед хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг цаг алдалгүй хэрэгжүүлэх үүднээс мөрдөгчид амаар зааварчилгаа өгч гүйцэтгэлийг тухай бүр хангуулж түүний үр дүнд үндэслэн цаашид хийгдэх ажиллагааны чиглэлийг зөв, хурдан тодорхойлж авах нөхцөл байдал олонтаа тохиолддог.

Мөрдөх нэгж, албадын өдөр тутмын удирдлага, зохион байгуулалтыг хангах явцад ч мөн энэ байдал байнга тохиолдож байдаг. Энэ үед мэдээж мөрдөх албаны дарга заавал бичгээр мөрдөгчид зааварчилгаа өгч биелэлтийг хангуулна гэвэл учир дутагдалтай юм. Иймд мөрдөгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах эрх зүйн хэлбэрт мөрдөгчид амаар зааварчилгаа өгч биелэлтийг нь хангуулж байх талаар тодорхой журам, заавар боловсруулан гаргаж түүний эрх зүйн орчинг бүрдүүлэх нь чухал юм²¹.

4. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүргийг нэг, эсхүл хэд хэдэн мөрдөгчид даалгах²², шаардлагатай гэж үзвэл тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорт мэдэгдэж хэргийг нэг мөрдөгчөөс нөгөө мөрдөгчид шилжүүлэх²³.

Мөрдөн шалгах ажиллагаа бодитой, тал бүрийн байх, хууль ёсыг хангах, түүнд оролцогчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хангахад мөрдөх албаны нэгж, тасаг, хэлтэс газрын даргад хуулиар олгогдсон дээрхи эрх хэмжээ нь чухал үүрэг гүйцэтгэдэг.

Мөрдөгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах явцад нэг мөрдөгчийн шалгаж байгаа хэргийг нөгөө мөрдөгчид шилжүүлэх бөгөөд энэхүү эрх хэмжээ нь албаны даргын өөрийн бүрэн эрхийн хүрээнд хийгдэх ба мөн тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорын зөвшөөрлөөр хэрэгждэг.

Нэг мөрдөгчийн шалгаж байгаа хэргийг нөгөө мөрдөгчид шилжүүлэх нь дараах нөхцөл байдлын аль нэг хэлбэр бодитойгоор илэрсэн үед хэрэгждэг. Үүнд:

➤ Гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэх мөн мөрдөн шалгах ажиллагааг цаг тухайд нь явуулах эсвэл мөрдөх ажиллагааны тал бүрийн, бодит байдлыг хангуулах хэрэгцээ шаардлага бий болсон (*өөрөөр хэлбэл мөрдагчийн үйл ажиллагаанд алдаа, дутагдал гарсан*);

➤ Мөрдөгч бүрийн ажлын ачаалалыг тэнцвэржүүлэх, тэдний ажлаа саадгүй түргэн шуурхай явуулах боломж, нөхцлийг хангах бодит байдал бий болсон;

²¹ Б.Одбаатар. Полномочия начальника следственной службы по процессуальному контролю при расследовании уголовных дел: по законодательству Монголии. Докторын диссертацийн ажил. 2012. /орос хэл дээр/

²² Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он. №23. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 6.3 дугаар зүйл. 1.2. дах хэсэг.

²³ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он. №23. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 6.3 дугаар зүйл. 1.3. дах хэсэг.

- Мөрдөгчийн зүгээс уг хэрэгт цаашид мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжгүй байгаа тухай өөрөө хүсэлтээ гаргасан;
- Хэргийн оролцогчоос мөрдөгчийг солих тухай гаргасан гомдол, санал ирснийг шалгаж улмаар мөрдөгчийг солих үндэслэл байгаа гэж үзсэн;
- Уг хэрэгт хяналт тавьж байгаа прокурор мөрдөгчийг солих тухай бичгээр даалгавар ирсэн зэрэг нөхцөл байдлын аль нэг хэлбэр үүсч түүнийг сайтар шалгаж судалсаны үндсэн дээр нэг мөрдөгчийн шалгаж байгаа хэргийг нөгөө мөрдөгчид шилжүүлдэг. Мөн түүнчлэн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа мөрдөгч удаан хугацаагаар томилолтоор өөр газар оронд ажиллах болсон, биеийн эрүүл мэндийн улмаас урт хугацаагаар өвчилж цаашид мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэх боломжгүй болсон зэрэг нөхцөл байдал үүссэн үед хэргийг өөр мөрдөгчид шилжүүлэх шаардлага гардаг.

Мөн түүнчлэн ээдрээ төвөгтэй, ихээхэн хэмжээний ажиллагаа шаардсан хэргийн мөрдөн шалгах ажиллагааг мөрдөгчийн хэсэг явуулж болох ба энэ нөхцөлд мөрдөх албаны дарга мөрдөгчийн ажлын хэсэг байгуулсан тухай тогтоол гаргаж энэ тогтоолдоо уг хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах мөрдөгч нарын нэрс, түүний дотор хэсгийн ахлагч-мөрдөгчийн нэрийг тодорхой тусгана. Мөн хуулийн заалт, шаардлагын дагуу уг тогтоолыг ялладагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгчид танилцуулах ба тэдгээр нь аль ч мөрдөгчийг татгалзах хүсэлт гаргах эрхтэй.

Мөрдөн шалгах ажиллагааны олон жилийн практик туршлагаас харахад хэргийг нэг мөрдөгчөөс нөгөө мөрдөгчид шилжүүлэх эрх хэмжээг зарим нэг хэрэгт хэт хавтгайруулан хэрэглэсний улмаас хэрэг олон мөрдөгчийн гар дамжин шалгагдаж энэ нь эргээд хэргийн шийдвэрлэлтийн хувь заяанд сөргөөр нөлөөлөх, хэрэгт цугларсан нотлох баримтууд нь нотлох баримтын чанараа алдах, мөрдөн шалгах ажиллагаа хэт удааширч он удаан жилээр хэрэг шийдвэрлэгдэхгүй байх, цаашлаад хэргийн оролцогч нараас удаа дараа гомдол, санал гарах, эцэстээ хэрэг хүссэн үр дүнгээс өөр байдлаар шийдвэрлэгдэхэд хүрч байсан олон хэргийн жишээ баримт байдаг.

Иймд мэргэжлийн удирдлагаар хангах эрх хэмжээг хэрэгжүүлэх явцад анхлан хэргийг шалгасан мөрдөгчөөр хэргийг дуусгуулах, аль болох мөрдөгчийг солихгүй байхад онцгой анхаарч харин түүнд мэргэжлийн туслалцаа дэмжлэгийг тухай бүр байнга үзүүлж, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлж байх нь чухал юм²⁴.

5. Хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явц байдлын талаархи мөрдөгчийн танилцуулгыг удирдлагын бүрэлдхүүний хүрээнд сонсож мэргэжлийн зөвөлгөө өгөх.

Мөрдөгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах эрх хэмжээг хэрэгжүүлэх хамгийн оновчтой хэлбэрийн нэг нь хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явц байдлын талаар уг хэргийг шалгаж байгаа мөрдөгчийн танилцуулгыг удирдлагын бүрэлдэхүүний хүрээнд сонсож түүнд мэргэжлийн зөвөлгөө өгөх явдал юм.

Энэхүү мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажиллагаа нь хэдийгээр хууль эрх зүйн орчинд Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдаагүй ч мөрдөгчийн өөрийн санаачлагаар эсвэл мөрдөх албаны даргын буюу захиргааны санаачлагаар хэрэгжиж мөрдөгчид уг хэрэгт анхаарвал зохих асуудлын талаар мэргэжлийн зөвөлгөө, туслалцаа үзүүлж байгаагаараа мэргэжлийн туслалцаа үзүүлэх бусад эрх зүйн хэлбэрээс давуу талтай байж болох юм.

²⁴ Б.Энхбат. Мөрдөн шалгах ажиллагааны практик. – УБ. 2004.

Мөрдөн шалгах ажиллагааны эхний шатанд гэмт хэргийг илрүүлэх, нотлоход чиглэсэн хойшлуулшгүй ажиллагааг явуулсаны дараа хэрэг дээр цугларсан нотлох баримтын хүрээнд уг хэрэгт цаашид хийгдэх ажиллагааны талаар илтгэх хуудас бичиж удирдлагын бүрэлдэхүүнд танилцуулж улмаар шаардлагатай бол мэргэжлийн туслалцаа дэмжлэг авах хүсэлтээ танилцуулж шийдвэрлүүлэх ёстой. Мэдээж хэрэг дээр цаашид хийгдэх ажлын цар хүрээ, хэргийн шалгалтын онцлог, ээдрээ, төвөгтэй байдал зэрэг нь нэг мөрдөгч дангаараа шалгах боломжгүй нөхцөл байдал үүссэн үед мэргэжлийн удирдлагыг шуурхай хэрэгжүүлэх үүднээс хэрэгт мөрдөн шалгах ажлын хэсэг байгуулан ажиллах шийдвэрийг удирдлагаас шийдвэрлэж болох юм.

Илрээгүй ноцтой хэрэг болон олон үйлдэлтэй, цаашид мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл үүсч болохуйц хэргийн нөхцөл байдлын талаар мөрдөгч танилцуулж байгаа тохиолдолд мөрдөх албаны нэгж, тасаг, хэлтэс, газрын дарга болон бусад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий нэгж албаны дарга уг хэргийг онцгой анхааралдаа авч өдөр тутмын мэргэжлийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч ажиллах шаардлагатай болдог.

Энэ үед тухайн хэрэгт хийгдсэн ажиллагаа болон цаашид хийгдэх ажиллагааны төлөвлөлтийн талаархи мөрдөгчийн сонсголтой албаны дарга өдөр бүр танилцаж биечлэн заавар, зөвөлгөө өгч мэргэжлийн туслалцаа үзүүлэн, удирдлагаар хангаж ажиллах ёстой.

Мөрдөн шалгах ажиллагааны чанар, мөрдөгчийн ур чадварыг дээшлүүлэх, түүнчлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны даргын эрх хэмжээний бодит хэрэгжилтийг хангахад чиглэсэн дараах саналыг дэвшүүлж байна.

САНАЛ.

1. Мөрдөн шалгах ажиллагааны чанарт сөргөөр нөлөөлж болох хүчин зүйл, эрсдэлийг бодитоор тогтоох, түүнийг саармагжуулах чиглэлээр үр дүнтэй ажил, арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлэх.

2. Мөрдөгчийн тогтвор суурьшилтай ажиллах хүсэлт эрмэлзмэл багасч байгаад дүгнэлт хийж үр дүнтэй ажил зохион байгуулах.

3. Мөрдөх албаны нэгж, тасаг, хэлтсийн даргын албан тушаалд мэргэжлийн, дадлага, туршлагатай алба хаагчийг сонгон шалгаруулалтаар дэвшүүлэн томилох мерит зарчмыг тууштай баримтлан ажиллах.

4. Мөрдөгчийн эрх зүйн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд онцгой анхаарч, гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагаанд он удаан жил оршиж байгаа хоцрогдсон арга барилаас түргэн салж, түүний оронд орчин үеийн, шинжлэх ухаан техникийн дэвшлийн ололт, амжилтыг гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагаанд түргэн нэвтрүүлэх, түүнд мөрдөгч нарыг сургаж, дадлагажуулах.

5. Мөрдөгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг шинэ шатанд гаргаж орчин үеийн менежментийн удирдлагын арга барилтай хослуулан хөгжүүлэх.

6. Мөрдөгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах ажлын үндсийн нэг нь мөрдөгч нэг бүрийн ажиллах нөхцөл боломжийг хангахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх явдал бөгөөд үүнийг тодорхой хөрөнгө, төсөв гаргаж шуурхай шийдвэрлэх.

7. Мөрдөх албаны даргын удирдлага дор ажиллах мөрдөгчийн тооны дээд хязгаарыг тодорхой болгож, мөрдөгч бүрийг мэргэжлийн удирдлагаар бүрэн дүүрэн хангаж ажиллах бололцоо, нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ.

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992 он. №1.
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он. №23.
3. Б.Энхбат. Мөрдөн шалгах ажиллагааны практик. – УБ. 2004.
4. Ж.Бямбадорж. Мөрдөн байцаалтын арга нь хэвээрээ байна. Эх сурвалж, холбоос: <http://mn-nhrc.org/index.php?newsid=5420>
5. Цагдаагийн ерөнхий газар. Цагдаагийн байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайлан.
6. Б.Одбаатар. Полномочия начальника следственной службы по процессуальному контролю при расследовании уголовных дел: по законодательству Монголии. Докторын диссертацийн ажил. 2012. /орос хэл дээр/

АСУУДАЛД ТУЛГУУРЛАСАН ЦАГДААГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА
ТҮҮНИЙ ҮНДСЭН АГУУЛГА, ЭЛЕМЕНТ
PROBLEM-ORIENTED POLICING AND ITS MAIN
CONTENTS AND ELEMENTS

Б.Баянмөнх

Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн эрхлэгч,
доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
byanmunkh@uia.gov.mn

B. Bayanmunkh

Head of Police Law, University of Internal Affairs
Doctor of Law (Ph. D), Police Lieutenant Colonel
University of Internal Affairs
State Email: bayanmunkh@uia.gov.mn

Хураангуй. Сүүлийн жилүүдэд гадаадын олон орнууд гэмт хэрэгтэй тэмцэхдээ асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны аргыг ашиглаж, тодорхой үр дүнд хүрч байгаа талаар олон судалгааны материалд дурдсан байдаг.

Энэхүү өгүүлэлд асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны тухай ойлголт, үндсэн элемент, аргын үндсэн агуулгын талаар гадаадын эрдэмтэн, судлаачид хэрхэн үзэж байгаа талаар товч авч үзсэн болно.

Abstract. In recent years, many foreign countries have been using problem-based policing methods to fight crime and have achieved certain results in many research papers.

This article briefly discusses how foreign scholars and researchers view the concept, main elements, and main content of problem-based policing.

Түлхүүр үг. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа, үндсэн элемент, олон нийтийн цагдаа, асуудалд чиглэсэн цагдаа

Key word. Problem-based policing, core elements, community policing, and problem-oriented policing

Оршил. Висконсин-Мэдисоны Их Сургуулийн профессор Херман Голдштейний санаачилсан асуудалд чиглэсэн цагдаа (POP) нь үр дүнтэй хариу арга хэмжээ авах стратеги боловсруулахын тулд гэмт хэрэг, эмх замбараагүй байдлын тодорхой асуудлуудыг тодорхойлж, дүн шинжилгээ хийдэг цагдаагийн стратеги юм.

POP нь цагдаа нарыг гэмт хэрэг үйлдэхэд хүргэж болох үндсэн асуудлуудыг тодорхойлж, зорилтот бүлэгт чиглүүлэхийг шаарддаг. Голдштейн үүнийг реактив, хэрэг явдалд тулгуурласан "цагдаагийн үйл ажиллагааны стандарт загвар"-ын сайжруулалт гэж санал болгосон.²⁵

Голдштейний 1979 оны загварыг 1987 онд Жон Эж, Уильям Спелман нар асуудлыг шийдвэрлэхэд зориулсан Scanning, Analysis, Response, and Assessment (SARA) загвар болгон өргөжүүлсэн. Энэхүү стратеги нь судалгаа, шинжилгээ, түүнчлэн гэмт хэргээс

²⁵ Defining Displacement (2012, October 22). In Center for Problem-Oriented Policing. Retrieved December 2, 2012, from <http://www.popcenter.org/tools/displacement>

урьдчилан сэргийлэх, олон нийтийн тулгамдсан асуудлыг бууруулахад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг татан оролцуулахад илүү их анхаарал хандуулдаг.²⁶

Санамсаргүй 34 хяналтын туршилт, бараг туршилтын судалгаан дээр үндэслэн энэхүү загварыг системтэй хянаж үзэхэд асуудалд чиглэсэн цагдаа нь гэмт хэрэг, эмх замбараагүй байдлыг бууруулахад үр дүнтэй боловч цагдаагийн хууль ёсны байдал, гэмт хэргээс айх айдас зэрэгт хязгаарлагдмал нөлөө үзүүлдэг болохыг тогтоожээ. Мөн гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө алба хаагчид хөндлөнгөөс оролцох, авлига авах, эрх мэдлээ урвуулан ашиглах эрсдэлтэй.

Үндсэн хэсэг. Асуудалд тулгуурласан үйл ажиллагааны арга нь гэмт хэрэг гарч буй учир шалтгаануудыг тодруулж, улмаар түүнд тохирох хариу арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгыг агуулдаг байна. Өөрөөр хэлбэл, асуудалд чиглэсэн үйл ажиллагаа нь тодорхой нутагт дэвсгэрт гэмт хэрэг, хүчирхийллийн шалтгаан болж байгаа эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад чиглэдэг.²⁷

1979 онд Хермон Голдштейн тухайн үед цагдаагийн стандарт үйл ажиллагааны талаар хийсэн хэд хэдэн судалгаанаас үзэхэд хууль сахиулах байгууллагууд цагдаагийн зорилгынхоо төлөө бус арга хэрэгсэлд илүү анхаардаг бололтой. Тэрээр хууль сахиулах байгууллагууд цагдаагийн байгууллагын уламжлалт, стандарт загвараас татгалзаж, цагдаа нар гэмт хэрэг, эмх замбараагүй байдлын эсрэг арга барилдаа идэвхтэй биш харин илүү идэвхтэй байх ёстой гэж үзэж байна (Hinkle et al., 2020; Weisburd et al., 2010). Голдштейн ажил нь олон нийтэд хандсан цагдаа (COP) болон асуудалд хандсан цагдаа (POP) гэсэн хоёр шинэ цагдаагийн загварыг хөгжүүлэх үе шатыг тавьсан.²⁸

Хэдийгээр COP болон POP нь анхаарлын эрч хүч, хандлагын олон талт байдал зэрэг олон талаараа ялгаатай байдаг (National Research Council, 2004), тэдгээрийн хооронд хэд хэдэн чухал ижил төстэй талууд байдаг. Жишээлбэл, COP болон POP хоёулаа идэвхтэй цагдаагийн хэлбэрийг төлөөлдөг бөгөөд энэ нь гэмт хэрэг гарсаны дараа хариу үйлдэл үзүүлэхээс илүүтэйгээр гэмт хэрэг гарахаас өмнө урьдчилан сэргийлэхэд чиглэдэг гэсэн үг юм. Цаашилбал, COP болон POP аль аль нь олон агентлаг, түншүүд, түүний дотор олон нийтийн гишүүдийн хамтын ажиллагааг шаарддаг (National Research Council, 2018). Нэмж дурдахад POP болон COP нь асуудлыг тодорхойлох, хөндлөнгийн оролцоог тодорхойлоход олон нийтийг оролцуулдаг тул давхцдаг (Greene, 2000).

Хэдийгээр COP болон POP-д залуучуудын оролцоонд чиглэсэн судалгаа цөөхөн боловч залуучууд энэ хоёр стратегид чухал үүрэг гүйцэтгэж чадна. COP-д залуучууд ихэвчлэн цагдаа нартай хамтран тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэхийн тулд хамтран ажилладаг олон нийтийн нэг хэсэг байдаг.

Өсвөр үеийнхэн энэ үйл явцад албан ёсоор оролцох (өөрөөр хэлбэл орон нутгийн олон нийтийн уулзалтад оролцох) эсвэл цагдаа болон олон нийтийн гишүүдийн хоорондын харилцааг бэхжүүлэх хүчин чармайлтад албан бусаар оролцож болно. Жишээлбэл, явган эргүүлийн цагдаа нь COP арга барилын нэг хэсэг болгон энгийн яриагаар дамжуулан олон нийтийн дунд залуучуудтай харилцахаар шийдэж болно (Cowell and Kringen, 2016). Эсвэл цагдаа нар өсвөр насныхныг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, цагдаа, залуучуудын бие биедээ хандах хандлагыг сайжруулах зорилготой цагдаагийн спортын лиг зэрэг үйл ажиллагаанд оролцохыг цагдаа нар дэмжиж болно (Rabois and Haaga, 2002).

²⁶ Felson, M. (2006). *Crime and Nature* (pp. 79–109). New Delhi, India: Sage Publications India Pvt. Ltd.

²⁷ Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: нотлох баримтын тойм. Нээлттэй нийгэм форум. УБ. 2017. 67 дахь тал

²⁸ <https://ojjdp.ojp.gov/model-programs-guide/literature-reviews/community-oriented-problem-oriented-policing>

POP-ийг ашигласнаар хууль сахиулах байгууллагууд өсвөр насны хүүхдүүдтэй холбоотой гэмт хэрэг, эмх замбараагүй байдлын асуудалд онцгой анхаарал хандуулж болно. Жишээлбэл, АНУ-ын Бостон хотод хэрэгжиж буй гал зогсоох ажиллагаа нь тус хотын залуучуудын дундах аллагын хохирогчийг бууруулахад чиглэсэн POP стратеги юм (Braga and Pierce, 2005).

Доктор Д.Зүмбэрэлхам “Асуудалд тулгуурласан үйл ажиллагааны аргын гол агуулга нь нийгмийн илрэн гарсан тэр үзэгдэлтэй нь тэмцэх бус тухайн сөрөг үзэгдлийг төрүүлж байгаа далд учир шалтгааныг нь тогтоож тэрхүү тулгамдсан асуудлыг нь судалж шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэхэд оршиж байна”²⁹ гэж үзсэн байна.

Асуудлыг тодруулах, дүн шинжилгээ хийх, түүнд тохирох хариу үйлдлийг сонгох, үнэлэх болон дахин тохируулах энгийн арга нь гэмт хэрэг гарах нарийн механизмыг ойлгож, улмаар тухайн гэмт хэргийг таслан зогсооход шаардлагатай далд нөхцөл байдлыг тодруулахад маш чухал юм.³⁰

Асуудалд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны үндсэн элементүүд:

- Асуудал нь гэмт хэрэг, хэрэг, дуудлага, ослоос илүү цагдаагийн ажлын үндсэн нэгж юм.
- Асуудал гэдэг нь зөвхөн цагдаа гэлтгүй иргэдэд санаа зовдог, хохирол учруулдаг зүйл юм. Зөвхөн цагдаагийн ажилтнуудад хамаатай зүйлүүд чухал боловч энэ утгаараа асуудал биш юм.
- Асуудлыг шийдвэрлэх нь хурдан засахаас илүү чухал бөгөөд энэ нь асуудал үүсгэж буй нөхцөл байдлыг шийдвэрлэх гэсэн үг юм.
- Цагдаагийн алба хаагчид баривчлахаасаа өмнө гэмт хэргийг тогтмол, системтэйгээр шалгадаг шигээ асуудлыг шийдвэрлэх гэж оролдохын өмнө байнга, системтэй дүн шинжилгээ хийх ёстой. Бие даасан албан тушаалтнууд болон хэлтэс бүхэлдээ асуудалд дүн шинжилгээ хийх горим, системийг боловсруулах ёстой.
- Асуудлын дүн шинжилгээ нь нарийн төвөгтэй байх шаардлагагүй ч гэсэн нарийн байх ёстой. Энэ зарчим нь гэмт хэргийн мөрдөн байцаалттай адил асуудалд дүн шинжилгээ хийхэд үнэн юм.
- Асуудлыг нарийн, үнэн зөв тайлбарлаж, асуудлын тодорхой талуудад хуваах ёстой. Асуудал нь ихэвчлэн анх харагддаг шигээ байдаггүй.
- Асуудлыг янз бүрийн ашиг сонирхлын үүднээс ойлгох ёстой. Хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүс асуудалд янз бүрийн байдлаар өртөж, асуудлын талаар юу хийх ёстой талаар өөр өөр санаа бодолтой байдаг.
- Асуудлыг шийдвэрлэх арга замыг ойлгож, илүү сайн хариу өгөхийн тулд үр ашгийн хязгаарыг ил тод хүлээн зөвшөөрөх ёстой.
- Эхний үед үр дүнтэй байж болох хариу арга хэмжээг богиносгохгүйн тулд аливаа асуудалд үзүүлэх боломжтой бүх хариултыг авч үзэх хэрэгтэй. Санал болгож буй хариултууд нь дүн шинжилгээ хийх явцад олж мэдсэн зүйлийнхээ дагуу байх ёстой. Тэд баривчлах арга хэрэгслээр хязгаарлагдах ёсгүй бөгөөд үүнийг үгүйсгэх ёсгүй.
- Цагдаа нар асуудлын хор уршигтай үр дагаварт хариу үйлдэл үзүүлэхээс илүүтэйгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд идэвхтэй хичээх ёстой.

²⁹ Зүмбэрэлхам Д. Орчин үеийн цагдаагийн байгууллагын хөгжлийн чиг хандлага. Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүхэн замнал, шинэтгэл. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ. 2006. 60 дахь тал.

³⁰ Community-Oriented Policing: Effect and Impact (Greene, 2007. P196 in The encyclopedia of Police Science

- Цагдаагийн алба нь цагдаагийн алба хаагчдын чухал шийдвэр гаргах, оролцох эрх чөлөөг нэмэгдүүлэх ёстой. Үүний зэрэгцээ албан тушаалтнууд шийдвэр гаргахдаа хариуцлагатай байх ёстой.

- Шинэ хариу арга хэмжээний үр нөлөөг үнэлэх ёстой бөгөөд ингэснээр эдгээр үр дүнг бусад цагдаагийн ажилтнуудтай хуваалцаж, хэлтэс нь юу болж, юу нь болохгүй байгааг системтэйгээр мэдэж болно. (Майкл Скотт ба Херман Голдштейн 1988.)

Асуудалд чиглэсэн цагдаа гэдэг ойлголтыг жишээгээр тайлбарлаж болно. Цагдаа нар ойр орчмын цэцэрлэгт хүрээлэнд гэмт хэрэг, зөрчлийн тухай дуудлагад өдөрт хэд хэдэн удаа хариу өгч байна гэж бодъё. Офицерыг хэргийн газарт илгээж, гэмт хэрэгтнүүдийг удаа дараа баривчлах нийтлэг хандлага нь гэмт хэрэг, эмх замбараагүй байдлын урт хугацааны асуудлыг шийдвэрлэхэд бага ч болов дэм болно. Үүний оронд цагдаа нар асуудалд чиглэсэн цагдаагийн арга барилыг арга барилдаа тусгах юм бол асуудлын суурь нөхцөлийг судлах болно.

Үүнд нэмэлт мэдээлэл цуглуулах, магадгүй ойр орчмын оршин суугчид болон цэцэрлэгт хүрээлэнгийн хэрэглэгчдээс судалгаа авч, осол гарсан өдрийн цагт дүн шинжилгээ хийх, гэмт хэрэг үйлдэгчид хэн бэ, яагаад тэд цэцэрлэгт хүрээлэнг илүүд үздэгийг тодорхойлох, цэцэрлэгт хүрээлэнгийн хамгийн таатай хэсгүүдийг судлах зэрэг орно. Үйл ажиллагаа, тэдгээрийн байгаль орчны дизайны шинж чанарыг үнэлэх нь чухал юм.

Судалгааны үр дүн нь асуудлын зан үйлийн хариу арга хэмжээний үндэс суурь болж чадна. Хууль сахиулах нь хариу арга хэмжээний нэг бүрэлдэхүүн хэсэг байж болох ч энэ нь цорын ганц шийдэл байх магадлал багатай. Учир нь энэ тохиолдолд дүн шинжилгээ хийх нь хөрш зэргэлдээ оршин суугчид, цэцэрлэгт хүрээлэн, амралт зугаалгын газрын ажилтнууд болон бусад хүмүүсийг татан оролцуулах шаардлагатайг харуулж байна.³¹

Асуудалд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь шат шатны офицеруудын асуудлыг тодорхойлоход тулгуурладаг. Бүх хэлтэс асуудлыг ижил аргаар тодорхойлдоггүй, гэхдээ ердийн тодорхойлолт нь: а)Давтагдсан тохиолдлууд; b)Нийгэмд тохиолддог; v)Холбогдох шинж чанаруудтай (жишээлбэл, зан байдал, байршил, хүмүүс, цаг хугацаа).

Энэ нь олон нийт, цагдаа нарын аль алинд нь хамаатай. Гол ойлголтууд нь Херман Голдштейн асуудлын шалтгааныг арилгах ёстой гэж үзсэн. Эк, Спелман нар асуудалд чиглэсэн цагдаагийн байгууллага юу хийх ёстойг харуулсан арван хоёр алхамт загварыг боловсруулсан. Үүнд:

1. Олон нийтийн санаа зовоосон асуудалд анхаарлаа хандуул.
2. Хамгийн чухал асуудал бол үр ашгийг тэглэх.
3. Идэвхтэй бай.
4. Бодит асуудлыг шийдвэрлэх эхний алхам болох системчилсэн судалгааг тууштай явуул.
5. Асуулга явуулахдаа хатуу арга хэрэглэхийг дэмж.
6. Цагдаагийн хавтаст мэдээлэл болон цагдаагийн ажилтнуудын туршлагыг бүрэн ашиглах.
7. Нийтлэг асуудал болгон шийдвэрлэхийн тулд ижил төстэй тохиолдлуудыг хамтад нь бүлэглээрэй.
8. Осол гэмтлүүдийг бүлэглэхдээ хэт өргөн шошго ашиглахаас зайлсхий, ингэснээр тусдаа асуудлуудыг тодорхойлох боломжтой.

³¹ <https://popcenter.asu.edu>. //Татаж үзсэн: 26.12.2023.

9. Шийдэл хайх өргөн, саадгүй эрэл хайгуулыг дэмж.

10. Асуудлын хариу арга хэмжээ болох эрүүгийн эрх зүйн тогтолцооны хязгаарыг хүлээн зөвшөөрөх.

11. Аливаа асуудалд олон сонирхлыг тодорхойлж, өөр өөр хариултуудын үнэ цэнийг шинжлэхдээ тэдгээрийг жинлээрэй.

12. Асуудалд хариу өгөхдөө зарим эрсдэлд орохыг хичээ.³²

Асуудалд тулгуурласан үйл ажиллагаа нь дөрвөн үе шаттай. Эдгээр үе шатыг АНУ-ын Цагдаагийн гүйцэтгэх судалгааны форум болон Ньюпорт Ньюс хотын цагдаагийн хэлтсийн алба хаагчид хамтран боловсруулсан юм байна. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны загварыг “SARA model” гэдэг. Энэ нь Англиар: “Scanning”, “Analysis”, “Response”, “Assessment” гэдэг үгнүүдийн товчлол юм.³³

Үг бүрийн агуулгыг авч үзвэл Scanning /Задаргаа хийх/ нь асуудлыг задалж, тодорхой бэрхшээл бий болгож байгаа эсэхийг тодруулах, Analysis /Шинжилгээ хийх/ нь тухайн асуудлын талаар мэдээлэл цуглуулж, түүний үндсэн шинж чанар, хамрах хүрээ болон учир шалтгаануудыг тодорхойлох, Response /Хариу үйлдэл боловсруулах/ нь шинжилгээнээс гаргаж авсан мэдээллийг ашиглан тухайн асуудалд тохирсон хариу арга хэмжээг боловсруулах, Assessment /Үнэлгээ хийх/ нь асуудлыг шийдвэрлэхэд зориулсан хариу арга хэмжээ үр дүнтэй байсан эсэхийг үнэлэх, үр дүнг ашиглан асуудлыг дахин авч үзэж, хариу үйлдлийг улам сайжруулах гэж тайлбарлагддаг байна. Ийм бодлого баримталж байгаа улс орнуудад голдуу босоо удирдлагатай цагдаагийн байгууллага байдаг байна.³⁴

Дэлхийн зарим улс оронд хэрэглэдэг хөшүүргийг татах арга нь асуудалд тулгуурласан үйл ажиллагааны аргыг баримталдаг боловч, асуудалд тулгуурласан үйл ажиллагааны хөтөлбөрүүдээс илүү өргөн хүрээнд олон зорилтуудыг агуулдаг байна.

Асуудлыг шийдвэрлэх боломжтой арга замыг өнөөдрийг хүртэл дэлхийн эрдэмтэн судлаачид болон эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчид судалсаар л байна. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааг энгийн үгээр тайлбарлавал:

- Асуудлыг илрүүлсний дараа цагдаагийн алба хаагчид иргэдтэй нягт хамтран ажиллаж, баривчлахаас өөр олон хувилбарыг багтаасан шийдлийг боловсруулах болно.

- Асуудалд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь хууль сахиулах байгууллагад олон нийтийн санаа зовоосон бусад асуудлыг бий болгож, үүссэн нөхцөл байдлыг шийдвэрлэх арга замыг зааж өгдөг.

- Иргэдийн санал хүсэлтийг хууль сахиулах байгууллагууд анхаарч, шийдвэрлэж байгаа эсэхийг олон нийт баталгаажуулах ёстой.

- Асуудалд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь олон нийтийн оролцоонд тулгуурладаг бөгөөд хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийг гарахаас урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь чухал юм.

Нэгдүгээрт, Сканнердах, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах, үнэлэх (SARA) -д “Сканнердах” нь эхний алхам бөгөөд цагдаа нар өөрсдийн харьяалалд гарч болзошгүй асуудлуудыг тодорхойлж, эрэмбэлэхийг шаарддаг.

³² Harocopos, A., & Hough, M. (2007). Problem-Specific Guides Series . In Community Oriented Policing Services U.S Department of Justice. Retrieved October 21, 2012, from http://blackboard.csus.edu/bbcswebdav/courses/128cjs47001/open_air_drug_markets_GUIDEBOOK.pdf

³³ Цагдаагийн шинжлэх ухааны зарим нэр томъёоны гарын авлага, УБ. 2019. 8 дахь тал.

³⁴ Баянмөнх. Б. Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт. -УБ., 2021. 22 дахь тал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл.

Хоёрдугаарт, “А” нь дүн шинжилгээ хийх, тухайлбал, осол гарсан өдрийн цагийг шинжлэх, гэмт хэрэг үйлдэгчид хэн бэ, яагаад тэд цэцэрлэгт хүрээлэнг илүүд үзэхийг тодорхойлох, үйл ажиллагаанд хамгийн тохиромжтой паркийн тодорхой хэсгийг судлах гэсэн үг юм. Үүнээс гадна, тэдгээрийн байгаль орчны дизайны шинж чанарыг үнэлэх. Шинжилгээнд мөн мэдээллийн эх сурвалжийг ашиглахын тулд цагдаа нар оролцдог тул зохих хариу үйлдэл үзүүлэх боломжтой.

Гуравдугаарт, энэ алхам болох хариу арга хэмжээ нь цагдаа нар асуудлыг засч залруулах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх явдал юм.

Дөрөвдүгээрт, хариу арга хэмжээний үр нөлөөг үнэлэх, ямар сайн үр дүнд хүрсэнийг үнэлэх явдал юм.³⁵

Уламжлалт тогтолцооны дагуу эргүүлийн ажилтан тодорхой асуудалтай газар эсвэл "халуун цэг" рүү удаа дараа ирсэн дуудлагад хариулж, зөвхөн тохиолдол бүрийг шийдвэрлэх боломжтой бол тухайн офицерыг РОР-ийн дагуу асуудлын үндсэн шалтгааныг олж тогтоохыг дэмждэг. шийдвэрлэх арга замууд. Зорилго нь зөвхөн шинж тэмдгийг эмчлэхийн оронд өвчнийг эмчлэх аргыг олох явдал юм.

Зарим нь [хэн бэ?] олон нийтэд хандсан цагдааг асуудалд хандсан цагдаатай андуурч болох ч олон нийтэд хандсан цагдаагийн үйл ажиллагааны гол чиглэл нь хууль сахиулах байгууллага болон иргэдийн хоорондын харилцааг сайжруулахад оршдог бол асуудалд хандсан цагдаагийн ажиллагаа нь иргэдийн мэдээлэлд тулгуурладаг. иргэд, олон нийттэй сайн харилцаатай.

Эдгээр нь гэмт хэрэгтэн, олон нийт, хүрээлэн буй орчин, гадны байгууллагууд эсвэл ямар нэгэн зуучлалын хэрэгцээнд анхаарлаа хандуулж болно. Нөхцөл байдал нь цагдаа, иргэдээс асуудалд тохирсон хариу арга хэмжээ авахыг шаарддаг тул бүтээлч сэтгэлгээ, үзэмжийг дээд зэргээр чухалчилдаг.

АНУ-ын Хууль зүйн яамнаас 1995 онд 327 сая долларын холбооны буцалтгүй тусламжийг Аризона мужид РОР хөтөлбөр хэрэгжүүлдэг цагдаагийн хэлтсүүдэд хуваажээ. Холбооны буцалтгүй тусламжийн мөнгө байгаа нь цагдаагийн байгууллагуудад РОР ашиглах бодит хөшүүрэг болжээ. Холбооны агентлагууд болон үндэсний цагдаагийн бүлгүүд, асуудалд чиглэсэн үр дүнтэй цагдаагийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үндэсний шагналуудыг бий болгох, дэлхий даяар хэрэгжүүлэх ажлыг эхлүүлжээ. АНУ-ын холбооны агентлаг, Олон нийтэд чиглэсэн цагдаагийн алба (COPS) нь РОР-ын үндсэн стратеги болон санхүүжилтийг баталсан.³⁶

Асуудалд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь ихэвчлэн хэд хэдэн үр дагавартай бөгөөд тэдгээрээс урган гарч ирдэг зарим санаанд оромгүй үр дагаваруудыг бий болгодог. Тухайлбал, Олон улсын РОР бага хуралд жил бүр Херман Голдштейний нэрэмжит Асуудлыг шийдвэрлэх шагналын хөтөлбөрт ирүүлсэн олон зуун РОР төслүүд юм. Энэхүү төслүүд нь дэлхий даяарх цагдаагийн хэлтсүүд автомашины хулгай, сургуулийн дээрэлхэхээс эхлээд хүн амины хэрэг, бүлэглэлийн асуудал зэрэг өргөн хүрээний асуудалд РОР арга хэмжээг хэрэгжүүлж байгааг харуулж байна. Төслүүд нь энэ аргыг томоохон бэрхшээлийг бууруулах арга зам болгон өргөнөөр хүлээн зөвшөөрөх нөхцлийг бүрдүүлдэг байна. Эдгээр амжилтын өөр нэг жишээ бол олон арван жилийн амжилтыг баримтжуулсан олон хэвлэл юм. Жишээ нь:

³⁵ www.popcenter.org. //Татаж үзсэн: 28.12.2023.

³⁶ www.popcenter.org. //Татаж үзсэн: 28.12.2023.

- Кеннет Пик, Рональд Гленсор нарын "Олон нийтийн цагдаа ба асуудал шийдвэрлэх: стратеги ба практик" (Прентис Холл, 1996)
- Корина Соле Брито, Трейси Аллан нарын "Асуудал баримжаатай цагдаа:
- Гэмт хэргийн шинжтэй асуудлууд, чухал асуудлууд, "Макум 2"³⁷

РОР-ын дагуу олон нийт цагдаагийн байгууллагын зорилгыг тодорхойлох, цагдаагийн байгууллага ямар асуудалд анхаарлаа хандуулахад чухал нөлөө үзүүлнэ. Энэ нь нэг талаараа дээрэм, дээрэм, хүчирхийллийн гэмт хэрэг гэх мэт цагдаад хамгийн их ач холбогдол өгдөг зүйл болон олон нийтийн гишүүдэд нэн тэргүүнд тавигддаг зүйлсийн хооронд зөрчил үүсгэж болох юм. Энэ мэт тэргүүлэх чиглэлийн зөрүүтэй байдал нь цагдаа, олон нийтийн харилцаанд саад учруулж болзошгүй юм. Нөгөөтэйгүүр, РОР-ын бодит туршлагаас харахад РОР төслүүд нь цагдаа нарт чухал ач холбогдолтой гэмт хэргийн асуудалд хэрхэн анхаарч байгааг харуулж байна. Үүний нэг жишээ бол Антони Брагга, Дэвид Кеннеди, Энн Пиел, Элин Уоринг нарын мэдээлсэн гэмт бүлэглэл, бууны гэмт хэргийг бууруулах төсөл нь "Бостоны буу төслийн үйл ажиллагаа гал зогсоох ажиллагаа - Гал зогсоох ажиллагааны үр нөлөөг хэмжих"³⁸ гэсэн үнэлгээний судалгаа юм. .

Олон нийтэд чиглэсэн цагдаа (СОР) нь олон нийтийн цагдаа гэж нэрлэгддэг бөгөөд Холбооны Олон нийтийн чиг баримжаатай цагдаагийн албаны албанаас "Түншлэл, асуудлыг шийдвэрлэх арга техникийг системтэйгээр ашиглахыг дэмжсэн байгууллагын стратегийг сурталчлах философи" гэж тодорхойлсон байдаг. гэмт хэрэг, нийгмийн эмх замбараагүй байдал, гэмт хэргээс айх айдас зэрэг олон нийтийн аюулгүй байдлын асуудлуудыг үүсгэдэг нөхцөл байдал. (Office of Community-Oriented Policing Services, 2012:3).

Асуудалд чиглэсэн цагдаа (РОР) нь нийгэмд гэмт хэрэг, эмх замбараагүй байдалд хүргэж буй үндсэн нөхцөл байдлыг олж тогтоох, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах, дараа нь шаардлагатай бол хариу арга хэмжээг үнэлж, тохируулах давталтын арга барилыг хууль сахиулах байгууллагуудад олгодог тогтолцоо юм (Braga et al., 2001; Hinkle et al., 2020; National Research Council, 2004).

РОР арга нь цагдаа нарыг ослоос илүү асуудалд анхаарлаа хандуулахыг шаарддаг (Cordner and Biebel, 2005). Асуудал нь энэ загварт "архаг нөхцөл байдал, үйл явдлын бөөгнөрөл буюу бөөгнөрөл нь цагдаагийн байгууллагад мэдэгдсэний улмаас, эсвэл цагдаагийн идэвхтэй мөрдөн байцаалтын явцад илэрсэн, эсвэл асуудал үүссэний улмаас цагдаагийн байгууллага хариуцах болсон" гэж тодорхойлсон. Цагдаагийн баримтыг шалгах явцад олдсон" (National Research Council, 2004:92).

РОР стратеги нь гэмт хэрэг үйлдлээс үүдэлтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга барилаас ялгаатай бөгөөд цагдаа нар гэмт хэрэг үйлдэгдсэн хувь хүн дээр анхаарлаа төвлөрүүлдэг. Үүний оронд РОР нь цагдаа нарт гэмт хэрэг, эмх замбараагүй байдал үүсэхэд нөлөөлж буй хүндрэлтэй хүчин зүйлсийг судалж, тэдгээр хүчин зүйлсийг арилгахын тулд тусгайлсан арга хэмжээнүүдийг боловсруулахад дасан зохицох боломжтой аргыг өгдөг. (National Research Council, 2018).

Өмнө дурьдсанчлан, РОР арга барилын цаад санаа нь хэдэн арван жилийн өмнө (Goldstein, 1979) хууль сахиулах байгууллагууд цагдаагийн үйл ажиллагааны зорилго буюу "хэрэгслийн хэтийн синдром" гэхээсээ илүү арга хэрэгсэлд илүү анхаардаг мэт ажиглалтаас үүдэлтэй (Goldstein, 1979) (Goldstein, 1979; Eck, 2006; MacDonald, 2002). 1990 онд энэ

³⁷ Police Executive Research Forum, 1999

³⁸ National Institute of Justice, 2001

ажлыг өргөжүүлж, цагдаагийн үйл ажиллагаанд ХОБ-ын хандлагыг ашиглах нь юу гэсэн үг болохыг системтэйгээр тодорхойлж, тайлбарласан. 1990-ээд оны үед АНУ болон бусад орнуудын (Австрали, Канад, Их Британи зэрэг) хууль сахиулах байгууллагууд POP стратегийг хэрэгжүүлж эхэлсэн (Scott, 2000).³⁹

Өсвөр үеийнхтэй холбоотой асуудлууд, тухайлбал залуучуудын үйлдсэн гэмт хэрэг (бууны хүчирхийлэл, сүйтгэх, граффити болон гэрээсээ зугтах, насанд хүрээгүй архи уусан гэх мэт өсвөр үеийнхний бусад зан үйлийг) шийдвэрлэхийн тулд POP аргыг хууль сахиулах байгууллагууд ашиглаж болно. Жишээлбэл, 2019-20 оны хичээлийн жилд улсын сургуулиудын гуравны нэг орчим нь эвдэн сүйтгэсэн (Wang et al., 2022). Хэрэв цагдаагийн байгууллага ихэвчлэн өсвөр үеийнхэнд үйлдэгддэг сургуулийн эвдрэл гэмтлийн асуудлыг шийдвэрлэхийг хүсвэл асуудлын цар хүрээг тодорхойлох, зохих хариу арга хэмжээг боловсруулах, хүчин чармайлтын ерөнхий үнэлгээг хийхийн тулд SARA загварыг ашиглаж болно.

Аризона мужийн Их Сургуулийн Асуудалд чиглэсэн цагдаагийн төвөөс гаргасан асуудалд чиглэсэн гарын авлагад хууль сахиулах байгууллагууд SARA загварыг ашиглах, сургуулиудад тусгайлан үйлдэгдэж буй эвдэн сүйтгэгчдийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хийж болох алхмуудыг тодорхойлсон (Жонсон, 2005). Тиймээс, SARA загварыг сканнердах үе шатанд цагдаагийн байгууллага болон сургуулийн дүүргээс цуглуулсан мэдээлэл зэрэг олон мэдээллийн эх сурвалжийг судалж, сургуулийн эвдрэл гэмтлийн тодорхой асуудалд анхаарлаа хандуулах болно.

Шинжилгээний үе шатанд цагдаа нар 1) хэдэн, аль сургууль эвдрэл гэмтлийн талаар цагдаад мэдээлсэн, 2) аль сургууль эвдэрсэн, 3) ямар онцлог шинж чанартай (жишээ нь: нас, хүйс, сургуулийн ирц) гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон залуучууд, 4) гэмт хэрэг хэдэн өдөр, хэдэн цагт гарсан. Шинжилгээний үе шат нь янз бүрийн мэдээллийн эх сурвалжаас авсан мэдээллийг багтаасан байх ёстой, тухайлбал сургуульд эвдэн сүйтгэх гэмт хэргийн талаар цагдаад өгсөн албан ёсны тайлан, ХБХ-той хийсэн ярилцлага, сургуулийн сурагчдын мэдээлэл (Жонсон, 2005).⁴⁰

Дүгнэлт. Дэлхийн улс орнуудад нэвтэрсэн асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаанд олон нийтэд хандсан цагдаа (COP) болон асуудалд хандсан цагдаа (POP) гэсэн 2 үндсэн чиглэлийн үйл ажиллагааны арга ашигладаг байна.

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны үндсэн баримтлах зарчим нь гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, үйлдсэн этгээдийг саатуулах, баривчлах нь гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг тодорхой хэмжээнд бууруулах боловч гэмт хэрэг, зөрчил гаргах боломжийг бүрдүүлж байгаа үндсэн суурь шалтгаан нөхцлийг арилгах, нөлөөлж буй хүчин зүйлийг алга болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах явдал юм байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Дотоод эх сурвалж:

1. Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: нотлох баримтын тойм. Нээлттэй нийгэм форум. УБ. 2017.
2. Зүмбэрэлхам Д. Орчин үеийн цагдаагийн байгууллагын хөгжлийн чиг хандлага. Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүхэн замнал, шинэтгэл. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ. 2006.

³⁹ <https://ojjdp.ojp.gov>. //Татаж үзсэн: 28.12.2023.

⁴⁰ <https://ojjdp.ojp.gov>. //Татаж үзсэн: 25.12.2023

3. Цагдаагийн шинжлэх ухааны зарим нэр томъёоны гарын авлага, УБ. 2019.
4. Баянмөнх. Б. Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт. -УБ., 2021. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл.

Гадаад эх сурвалж:

5. Defining Displacement (2012, October 22). In Center for Problem-Oriented Policing. Retrieved December 2, 2012, from <http://www.popcenter.org/tools/displacement>
6. Felson, M. (2006). Crime and Nature (pp. 79–109). New Delhi, India: Sage Publications India Pvt. Ltd.
7. Community-Oriented Policing: Effect and Impact (Greene, 2007. P196 in The encyclopedia of Police Science
8. Harocopos, A., & Hough, M. (2007). Problem-Specific Guides Series . In Community Oriented Policing Services U.S Department of Justice. Retrieved October 21, 2012,
- 9.

Цахим эх сурвалж:

10. <https://ojjdp.ojp.gov>
11. <https://popcenter.asu.edu>
12. <http://blackboard.csusb.edu>
13. <https://ojjdp.ojp.gov>.
14. www.popcenter.org.

**ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ЯВЦАД
ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ
POLICE DUTIES PERFORMANCE PROCEDURES CHALLENGES**

Б.Батбаяр
Дотоод хэргийн их сургуулийн ЭЗНУС-ийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,
цагдаагийн ахлах дэслэгч
B.Batbayar
Teacher of the Public Law Department of the
Law School of the University of the Interior,
senior Police lieutenant

Товч агуулга. Энэхүү өгүүллээр цагдаагийн байгууллагад ажиллаж буй ахлагч бүрэлдэхүүний ажиллах нөхцөл, хүндрэл бэрхшээл, ажил үүргээ биелүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэхэд оршино.

Abstract. These problems show that the need to improve the ethics, communication and attitudes of police officers is an urgent problem. In this article, the purpose of this article is to discover the working conditions, difficulties, and problems faced by the supervisors working in the police organization while performing their duties.

Түлхүүр үг. Ажил үүрэг, харилцаа, хандлага, асуудал, иргэд, олон нийт

Key word. Tasks, relations, attitudes, problem, citizens and communities

Үндсэн хэсэг. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2011 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 598 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм⁴¹д заахдаа “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй нь өргөсөн тангарагтаа үнэнч байх, хууль тогтоомжийг дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн тэгш байдлыг хангах, албан үүргээ амжилттай гүйцэтгэх үндсэн нөхцөлийн нэг тул цагдаагийн бүх шатны байгууллага нь алба хаагч бүрээс ёс зүйн хэм хэмжээг заавал сахин биелүүлэхийг шаардана”⁴² гэж заасан.

Энэ дүрмийн түүхийн байдлыг судлан үзвээс 1978 онд НАХЯ-аас Цагдан сэргийлэх байгууллагын ажилтнуудаас ард иргэдийг хүндэтгэн, соёлч боловсон, эелдэг зөөлөн харьцаж байх тухай⁴³ 10 зүйл заалт бүхий сайдын тушаал гарч түүнийг хэрэгжүүлэх ажил сэргийлэхийн бие бүрэлдэхүүний дотор хүчтэй өрнөж цагдан сэргийлэхийн ажилтан хууль нь ёс зөрчих, албан тушаалаа урвуулан хэтрүүлэх, иргэдийн эрхийг боогдуулах, хууль бусаар албадан саатуулах, баривчлах зэрэг жигшүүртэй ажиллагаа хэрхэвч гаргаж болохгүй гэдгийг хатуу анхааруулсугай гээд сэргийлэхийн ажилтан нь иргэдийг гүнээ хүндэтгэн соёлч боловсон харьцаж, үнэнч шударгаар туслах, үйл ажиллагаандаа шинэ их амжилт гаргаж цагдан сэргийлэх байгууллагын нэр хүндийг улам дээшлүүлэхийг нийт бүрэлдэхүүнд үүрэг болгосон шинэ агуулга бүхий тушаалыг тухайн үед алба хааж байсан сэргийлэхийн алба хаагч нар журмын дагуу хүлээн авч, үүргээ зохих ёсоор биелүүлж, ардчилал шинэчлэлийн үеийн Цагдаагийн байгууллагатай залгуулж өгсөн түүхтэй юм.

⁴¹ Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм. УБ., 2011.

⁴² Мөн тэнд

⁴³ Цагдан сэргийлэх байгууллагын ажилтнуудаас ард иргэдийг хүндэтгэн, соёлч боловсон, эелдэг зөөлөн харьцаж байх тухай тушаал. –УБ., 1978.

“Цагдаагийн алба хаагч нь Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, ажил үйлчилгээний стандарт, цагдаагийн алба хаагчийн тангараг, ёс зүйн хэм хэмжээг чанд сахин биелүүлэхийг “Цагдаагийн алба хаагчийн сахилга”⁴⁴ гэж тодорхойлсон бөгөөд цагдаагийн алба хаагч нь шударгаар ажиллаж амьдрах, хууль биелүүлэх, хуулинд захирагдах аливаа хэрэг зөрчлийг шалган шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлан танил тал харах, хуурч мэхлэх, хувийн байдлаар хандах зэрэг шударга бус зүйлийг гаргахгүй байх гэсэн утгатай юм.

Цагдаагийн алба хаагчдын соёлд, нийгмийн шаардлагыг дагасан өөрчлөлт хийх бодит нөхцөл бүрдээд удаж байгаа боловч харамсалтай нь нийгмийн харилцаанд гарсан өөрчлөлт шинэчлэлийн шаардлагыг, цагдаагийн албан хаагчийн харилцааны соёл тэр бүр хангаж чадахгүй байна.

Цагдаагийн алба нь харилцаж буй субъектүүдийнхээ хувьд ихээхэн онцлогтой бөгөөд амаргүй алба юм. Албан хаагчдын ихэнх нь өдөр тутамдаа асуудал, бэрхшээлтэй холбогдсон, сөрөг хандлага, сөрөг бодол тээсэн, уурласан, бухимдсан, өш хонзон санасан, хямарсан, хохирсон хүмүүстэй харилцах шаардлага үргэлж тулгарч байдаг. Мөн гэмт хэрэг үйлдсэн, хохирсон, айж балмагдсан, тусламж хүссэн иргэдтэй алба хаагч харилцахдаа ганцхан арга барилаар ханддаг нь нийтлэг алдаа дутагдал юм.

Тиймээс Цагдаагийн алба нь алба хаагчдаас харилцааны чадвар болон сэтгэл зүйн бэлэн байдлыг үргэлж шаарддаг, алба хаагч аливаа асуудалд хүлээцтэй хандаж, иргэдийн эрх чөлөө, нэр хүндийг ямагт дээдлэн, уурласан, хэрэлдсэн хүний өмнөөс сөрөхийн оронд товч тодорхой албаны цөөн үгээр шаардлагаа тайван илэрхийлж байхыг анхааруулдаг.


Цагдаагийн албан хаагчид ихэвчлэн зөрчил дутагдал гаргасан, хууль дүрэм зөрчсөн хүнтэй харьцахдаа зөрчил гаргагчийн зөрчлийг залруулах, бурууг өөрөөр нь хүлээлгэхийг эрхэм болгохоос урьдаж загнах, зандрах, шууд торгох, хариуцлагын арга хэмжээ авахыг зорилгоо болгодог нь тэдний дайчин шуурхай ажиллагаа мэт боловч цаашдаа цагдаагийн байгууллагын нэр хүндэд муугаа нөлөөлдөг, бодит дүр төрх юм.

Иргэн хүний аюулгүй хийгээд амар тайван амьдралын баталгаа Цагдаа хүн өөрөө юм гэдгийг ойлгох нь маш чухал юм. Цагдаагийн алба хаагч бол өөрийн амь нас, сэтгэл зүрх, оюун бодлоо бусдын төлөө зориулж байгаагаараа үнэ цэнтэй бөгөөд бахархмаар ажил гэдгийг цагдаа өөрөө болон өрөөл бусад хүмүүс ч ойлгох ёстой.

Энэхүү сэдвийн хүрээнд дараах байдлаар судалгаа авав. Судалгаанд иргэд олон нийт болон цагдаагийн албан хаагчид оролцов.

⁴⁴ Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм. ЦЕГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/201 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт.


График 1. Иргэд олон нийтийн судалгааны үр дүн



Дээрх графикаас харахад Цагдаагийн алба хаагчдын зан байдал, харьцаа хандлагын талаар цахим орчинд 80 иргэнээс судалгаа авахад судалгаанд хамрагдагсдын 85% нь ямар нэгэн байдлаар цагдаагийн байгууллага, алба хаагч дээр очсон, уулзсан, 48% нь цагдаагийн алба хаагчдын зан ёс зүй, харилцаа хандлагыг шударга бус дээрэнгүй шинжтэй гэж дүгнэсэн бол 39% нь цагдаагийн алба хаагчдыг бусдыг үл ойшоосон, төвөгшөөсөн, асуудал шийдвэрлэхээс зайлсхийсэн байдалтай хандсан гэсэн судалгааны үр дүн гарчээ.

Мөн судалгаанд оролцогчдын 57% нь цагдаагийн байгууллага алба хаагчийн үйл ажиллагааг буруутгасан, үгүйсгэсэн төлөв шинжийг сонгосон байна.

График 2. Цагдаагийн албан хаагчдын судалгааны үр дүн



Дээрх графикаас харахад судалгаанд оролцсон нийт 60 алба хаагчаас ЦАХ-ийн хандлага, зан үйлд муугаар нөлөөлж буй хүчин зүйлс юу байна вэ? гэсэн судалгаа авахад судалгаанд хамрагсдын 91% нь ажлын стрессээс үүдэлтэй бухимдал, 84% нь алба хаагчдад

өөрийгөө хөгжүүлэх цаг зав хомс байдал, 62% нь ажлын ачаалал их, төлөвлөгдөөгүй гэнэтийн ажилд дайчлагддаг байдал, 57% нь цагдаагийн албанд орж буй иргэдийг сонгон шалгаруулах журам, шалгуур сул, 54% нь цалин бага, амьдралд хүрэлцээ муутай байдал, 52% нь алба хаагчдын суурь хүмүүжлийн доголдол, 51% нь цагдаагийн нэр хүнд унасан ирээдүйд итгэх эргэлзээ бий болсон, 48% нь алба хаагчдын мэдлэг ур чадвар дутмаг байдал, 44% нь албаны сургалт, соён гэгээрүүлэх ажил хангалтгүй байгаа байдал, 42% нь орон тооны дутмаг байдал, 37% нь алба хаагчдын нийгмийн асуудал хүнд байна, 29% нь ажил хийх хүсэл эрмэлзэл, сонирхолгүй болсон, 13% нь удирдах албан тушаалтны зүй бус харьцаа зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна гэжээ.

Судалгааны үр дүнг нэгтгэн үзвэл ёс зүйн зөрчил, харилцааны асуудлын анхдагч шалтгаан бол бухимдал (стресс), түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүд нь ажлын ачаалал их, цалин бага, хэрэгжүүлж буй хууль тогтоомжоос үүдэлтэй үл ойлголцол, иргэд цагдааг буруугаар ойлгодог байдал, ажлын ачаалал их, төлөвлөгдөөгүй гэнэтийн ажилд дайчлагддаг, цагдаагийн албанд орж буй иргэдийг сонгон шалгаруулах журам, шалгуур сул, цалин бага, амьдралд хүрэлцээ муутай, алба хаагчдын суурь хүмүүжлийн доголдол, цагдаагийн нэр хүнд унасан ирээдүйд итгэх эргэлзээ бий болсон, алба хаагчдын мэдлэг ур чадвар дутмаг байдал, албаны сургалт,соён гэгээрүүлэх ажил хангалтгүй байгаа байдал, орон тооны дутмаг байдал, дарга нарын зүй бус харилцаа, шударга бус, ил тод биш байдал, тодорхой зорилгогүй, өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх цаг зав хомс, тайлагнах, нөхцөл байдлыг зөв үнэлж дүгнэх чадвар сул, буулт хийх чадваргүй зэргээс шалтгаалж ёс зүйн зөрчил, харилцаа, хандлагатай холбоотой бэрхшээлтэй асуудлууд үүсдэг байна.

Үүний зэрэгцээ олон нийтийн цахим сүлжээнд цагдаагийн алба хаагч сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргасан болон гэмт хэрэг, зөрчил үйлдсэн тухай мэдээ мэдээллүүд түгээмэл тархаж цагдаагийн алба хаагч цаашлаад цагдаагийн албаны нэр хүндэд ихээхэн сөргөөр нөлөөлж байна.

Дүгнэлт, санал. Өнөөгийн нийгмийн байдал, хууль тогтоомжийн шинэчлэл, техник технологийн хөгжил, мэдээ мэдээллийн хувьсал, алба хаагчийн хандлага гээд чухамдаа бүгд холбоо хамааралтай байх нь дамжиггүй. Энэ асуудалд дүн шинжилгээ хийж цагдаагийн алба хаагчдаас иргэдтэй байнга харилцдаг, цагдаагийн албан хаагчид иргэдтэй харилцах харилцаанд учирч буй саад бэрхшээлийг энэхүү сэдвийн хүрээнд бага ч болов таньж мэдэн тэрхүү асуудлыг хөндөхийг зорилоо.

Цагдаагийн байгууллагын үе үеийн удирдлага, хамт олон алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн байдалд санаа зовниж, тооцоо судалгаа хийж, гэмт хэрэг, зөрчлийг гаргуулахгүй байх, бууруулах талаар бодлогын түвшинд тодорхой ажлуудыг хийсээр иржээ. Түүний илрэл нь “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”⁴⁵, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”⁴⁶, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”⁴⁷ зэрэг бодлогын бичиг баримтууд, “Цагдаагийн албаны тухай хууль”⁴⁸, түүнийг дагаж мөрдөх журмын тухай хууль зэргийг нэрлэж болно.

⁴⁵ Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт. УБ.,

⁴⁶ Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм. ЦЕГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/201 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт.

⁴⁷ Мөн тушаалын хоёрдугаар хавсралт.

⁴⁸ Цагдаагийн албаны тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №8.

Цагдаагийн албаны тухай хуульд Дотоод хяналт, аюулгүй байдлын нэгж Цагдаагийн албаны тухай хуулийн 13.2⁴⁹-т заасан чиг, үүргийн хүрээнд ажиллах талаар тусгагдсан. Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн зөрчил, гэмт хэрэгт холбогдох явдал сүүлийн жилүүдэд тоон үзүүлэлтээр буурсан байдаг боловч, таслан зогсоогдохгүй байна.

Цагдаагийн алба хаагчийн ёс зүйг сахиж сургах нь хэн нэгэн хүний тушаалаар бус тухайн алба хаагчийн хүлээсэн үүрэгтэй холбоотойгоор өөрийн санаачилгаар биелүүлж хэвших ёстой зүйл юм. Ёс зүйгээ сахих нь алба хаагч миний үүрэг, хариуцлага, надад олгогдсон хөрөнгө, оруулалт боломж гэдгийг ойлгуулах ажил хамгаас чухал. Алба хаагч бүр хэний ч оролцоогүйгээр ёс зүйгээ сахих байх таатай боломжийг бүрдүүлж чадахаар болохуйц сургалт, соён гэгээрүүлэх ажлыг хүн нэг бүрт чанартай ухамсарлуулах нь туйлаас чухал юм.

Ажлын байранд үүсдэг “стресс”-ийг бууруулах, арилгах, стресс тайлах чадвар, сэтгэлээ ариусгах дасгалууд, уураа барих, тэвчээртэй байх, сэтгэцийн хэв шинжийн хувьд ялгаатай хүмүүстэй хэрхэн харилцах тухай болон бусдыг сонсох ур чадвар, тааламжтай ба тааламжгүй харилцаа, харилцааны биеийн хэл практик сургалтыг үр дүнтэй зохион байгуулах нь зүйтэй юм.

Ашигласан материал.

Монгол Улсын хууль тогтоомж:

1. Цагдаагийн албаны тухай хууль

Дүрэм, журам

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (2022)
2. Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт
3. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм (2011), (2022)
4. Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм (2022)

Ном, сурах бичиг, гарын авлага

1. Монгол Улсын Цагдаагийн байгууллагаас иргэдэд хүргэдэг үйлчилгээний мониторинг тайлан (2021)
2. ЦЕГ-ын статистик (Цагаан ном) мэдээллүүд (2021), (2022)
3. Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн, Цагдаагийн шинжлэх ухааны зарим нэр томъёоны гарын авлага. -УБ., 2017.
4. www.police.gov.mn

⁴⁹ Мөн тэнд

**УНАДАГ БОЛОН ЦАХИЛГААН УНАДАГ ДУГУЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ
ЗОХИЦУУЛАЛТЫН ХӨГЖИЛТӨД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ,
ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖУУД**
**CHALLENGES AND OPPORTUNITIES FOR THE DEVELOPMENT
OF REGULATORY FRAMEWORKS FOR BICYCLES AND E-BIKES**

Д.Нямдорж

ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн
Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний ажилтан,
хууль зүйн доктор, цагдаагийн дэд хурандаа

Nyamdorj D.

Ph.D of Law, Police Lieutenant Colonel, Researcher,
Institute of Criminology and Police research,
University of Internal Affairs, Mongolia
e-mail: nyamdorj_mvд@yahoo.com

Хураангуй: Замын хөдөлгөөнд унадаг дугуйгаар болон цахилгаан унадаг дугуйгаар оролцох эрх зүйн орчны асуудал, мөн түүний хэрэглээ, жолоочийн сургалт, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн талаар мөн хийж хэрэгжүүлэх эрх зүйн орчны өөрчлөлт бусад арга хэмжээний талаар өгүүлнэ.

Abstract: The issue of the legal framework for participation in road traffic by bicycle and electric bicycle, as well as its use, driver training, and traffic management equipment, as well as changes in the legal framework and other measures will be discussed.

Түлхүүр үгс: Замын хөдөлгөөний аюулгүй байдал, унадаг дугуй, цахилгаан унадаг дугуй, эрх зүйн орчны асуудал, хэрэглээ, жолоочийн сургалт, замны хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, тэмдэг, гэрлэн дохио.

Key words: traffic safety, bicycles, electric bicycles, legal environment issues, applications, driver training, traffic control equipment, signs, traffic lights.

Оршил: Тээврийн хэрэгслүүдийг механикжсан болон механикжаагүй гэсэн хоёр төрөлд хувааж үзэж болох юм. Механикжаагүй тээврийн хэрэгслийн хамгийн том төлөөлөл бол унадаг дугуй юм.

Замын хөдөлгөөнд оролцогч тээврийн хэрэгслүүдтэй харьцуулахад харьцангуй бага зай эзэлж, маневрлах, бусад хөнгөн чанар үзүүлэлтээр хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг хангадаг учраас хэрэглээ нь өргөнөөр нэвтэрсэн байна.

Унадаг дугуй бол хүний булчин шөрмөсний үйл ажиллагаагаар хөдөлдөг, хөл гишгүүр буюу дөрөөг жийж явдаг, арын болон урд хэсэгтээ их биед нь хавсаргасан хоёр



ширхэг

дугуйтай, нэг мөртэй хуурай замын тээврийн хэрэгсэл юм. Хүүхдийн тоглоом, фитнес, цэрэг, цагдаагийн даалгавар гүйцэтгэх, шуудангийн үйлчилгээ, онцгой байдал, түргэн тусламжийн болон хүн тээврийн хэрэгсэл болгон ашигладаг бөгөөд уралдаан, спорт, аялал гээд маш олон салбарт төрөл чиглэл хийц, үүргээсээ хамааран ашиглагддаг.


Түүхэн хөгжлөөс товчхон: Унадаг дугуй XIX зуунд нийтийн хүртээл болсон бөгөөд одоо дэлхийн хэмжээнд нэг тэрбум орчим дугуй байгаа нь автомашинаас даруй хоёр дахин их байна. Хэдэн онд үүссэн юм бол? Ойролцоогоор МЭӨ 1300 жилээс үүссэн гэж үздэг.⁵⁰

Гэхдээ унадаг дугуйн үүссэн албан ёсны цаг тооллыг 1817 онд Германы Барон Карл Дрезийн зохион бүтээсэн “Laufmaschine” (Германаар "гүйдэг машин) 1818 онд анхны унадаг дугуйд тооцон патент олгогдсон хугацаагаар тооцдог.



Унадаг дугуй (хуучин Франц *vélocipède*, Латин *vēlōx* "хурдан" ба *pes* "хөл" гэсэн үг) нь хүний булчингийн хүчээр хөлийн дөрөө эсвэл гар хөшүүргээр (маш ховор) жолооддог дугуйтай тээврийн хэрэгсэл (мөн спортын хэрэгсэл) юм.

Хотын нийтийн тээвэр, тэр дундаа автобус, троллейбус, трамвай өргөн дэлгэрч эхлэхээс ч өмнө унадаг дугуйг тээврийн хэрэгсэл болгон ашиглаж эхэлсэн байдаг.



Унадаг дугуйн түүхийн томоохон төлөөлөл бол “OPEL” компани бөгөөд дугуй үйлдвэрлэгчийн анхдагчийн тоонд зүй ёсоор тоологддог⁵¹.

Монгол улсад орж ирсэн анхны дугуйнууд нь тухайн үедээ Хүрээний баячуудын чамирхал, гангараа байснаа аажимхнаар хэрэглээ рүү шилжсэн байдаг. Бидэнд ирсэн баттай баримтаар 1936 онд хийгдсэн Монголын анхны уран сайхны “Монгол хүү” кинонд унадаг дугуйг аль цагийн хэрэглэж байсан дүр зураг гардаг.



⁵⁰<https://mn.wikipedia.org>.

⁵¹ Бабкин.С “Герман дахь унадаг дугуйнууд” Москва хот 2017 он

Унадаг дугуйн албан ёсны патенттай түүхэн загвар, хийцүүд



52

Унадаг дугуй нь ихэнхдээ хоёр дугуйтай загварууд байх боловч гурав ба түүнээс дээш дугуйтай загварууд ч бас байдаг. Цагийн эрхээр техникийн хөгжил, инженерийн дэвшилтэт санаанаас шинэ шинэ санаа гарч олон төрлийн загвар, хийцүүд гарч байсан ч аюулгүй төгс загвар хүртлээ багагүй хугацааг туулсан юм.



Өнөөгийн хэрэглээ:

Хүн ам ихээр төвлөрсөн дулаан уур амьсгалтай улс орнуудад хүн тээвэр болон ачааны зориулалттайгаар унадаг дугуй загвараа сайжруулан бүтээгдэж байсан юм.



Сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд унадаг дугуйн ашиглалтын талбайг нэмэгдүүлэхийн тулд GPS төхөөрөмжийг өргөнөөр ашигладаг болжээ.

Унадаг дугуйг жилийн 2 улиралтай буюу халуун, дулааны цаг агаар, уур амьсгалтай улс орнуудад өргөнөөр ашигладаг.

Монгол улсын хувьд жилийн дөрвөн улиралтай орон ч гэсэн аль ҮШ Богд Жавзандамба хутагтын үеэс унадаг дугуйг хэрэглэж эхэлсэн байдаг.

Унадаг дугуйг улирлын чанартай тээврийн хэрэгсэл гэдэг утгаараа мөн зам, эрх зүйн орчин багатай болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр хэрэглээ багатай мэт байгаа ч энэ төрлийн зам тээврийн осол гэмт хэрэг төдийлөн буурсан үзүүлэлт харагддаггүй.

Унадаг дугуйн төрлийн талаар товчхон:

Модон дугуй-Хамгийн анхны унадаг дугуй бол модон унадаг дугуй байсан юм. Сүүлд модон материалыг металл болон хуванцар болгон өөрчилсөн байна. Гэхдээ эртний түүх давтагдаж Японы зохион бүтээгч Йожио Ошима модон унадаг дугуйг бүтээжээ⁵³.

⁵² www.bussgeldkatalog.org/stvo

Чоппер унадаг дугуй- Чоппер дугуй сүүлийн үед нэлээд моодонд ороод байгаа. Custom Max унадаг дугуй өргөн дугуйтай бөгөөд та нэг жийхэд л хангалттай юм байна. Ретро загварын унадаг дугуй Сукно нэрт энэхүү унадаг дугуй нь цахилгаан хөдөлгүүртэй аж.

Хамгийн хямд, хамгийн хөнгөн унадаг дугуй - Израилын дизайнер Ицгар Гафни энгийн картоноор дугуй хийсэн байна. Хэрвээ картоныг давирхайгаар хучаад, усны хамгаалалттай, галын хамгаалалттай будгаар будвал унахад тохиромжтой гэнэ. 20 долларын үнээр зарагдах боломжтой аж.

Ачаанд зориулсан унадаг дугуй-Унадаг дугуйг ачаа тээвэрт ашиглах нь элбэг байдаг. Гэхдээ том ачаа зөөхөд хэцүүхэн байдаг учир Donkey хэмээх дугуйг бүтээсэн байна. Хоёр ачаатай учир ачааны жинг нэгэн жигд хуваарилахад тохиромжтой.

Үүргэвчтэй унадаг дугуй-Аялалд дуртай идэвхтэй аялагчдад зориулан германы Бергмёнх компанийнхан эвхэгддэг үүргэвчтэй унадаг дугуйг бүтээсэн байна.

Зэвэрдэггүй төмрөөр хийсэн унадаг дугуй-Уралдааны мотоцикл мэт загвартай энэхүү унадаг дугуйг инженер Индрек Наруск бүтээжээ.

Хулгайлагдах боломжгүй дугуй-Унадаг дугуйг хулгайлах тохиолдол нэлээд байдаг учир Британийн дизайнер Кевин Скотт нэгэн гайхалтай аргыг сэдсэн байна. Дугуйгаа шонд ороож түгжихэд л хангалттай гэнэ.

Ауди-гаас гаргасан спортын дугуй-AUDI Worthersee нь хурдаа 5 төрлөөр тохируулах боломжтой юм байна. Хамгийн ихдээ 80 км/цаг хурдлах чадвартай. Заавал педалыг нь жийх хэрэггүй гэнэ.

Нарны эрчим хүчээр ажилладаг-Ele дугуй нь нарны эрчим хүчээр мотороо цэнэглэдэг байна. Нарны тусгалд тааруулан 30 градус хүртэл эргүүлж болох бөгөөд наргүй үед энгийн тохиргоог сонгож шууд жийгээд явж болох юм байна.⁵⁴

Өрөв тас-Дугуй нь хамгийн анхны тээврийн хэрэгсэл байжээ. Ялангуяа Оросын тосгонд дугуй унасан хүүхдүүд бусдын анхаарлыг нэлээд татдаг байсан байна

Сурагч-Ахлах ангийнханд зориулсан унадаг дугуй. Үүний ачаар хүүхдүүд дугуйгаа хийлж, нөхөж сурсан байна.

Урал-Ган хүрээ, бат бөх дугуй, хөл тоормостой энэхүү дугуй олон арван жилийн туршид ашиглагдах тээврийн сайн хэрэгсэл болсон байна.

Жуулчин-Дээр үеийн хамгийн шилдэг, хамгийн хурдан унадаг дугуйны нэг байжээ.

Аварга-Уралдахад нэн тохиромжтой эртний дугуй.

Мото-унадаг дугуй-Оросын хамгийн анхны мопед ч гэж болно. 1960 оноос хойш үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд дугуй сонирхогчдын мөрөөдөл болж байсан байна⁵⁵.

⁵³ Велотранспортный Союз[Электронный ресурс]:О совещании в комитете Государственной Думы по транспорту.

⁵⁴<https://mn.wikipedia.org>

⁵⁵www.velotransunion.ru

Тулгамдаж байгаа асуудал: Замын хөдөлгөөнд унадаг дугуйгаар хөдөлгөөнд оролцох талаар шинжлэх ухааны үндэслэлтэй багагүй арга хэмжээнүүд зохион байгуулагдаж байгаа билээ.

Унадаг дугуй импортоор оруулж худалдан борлуулдаг, бизнесийн байгууллагууд, хувь хүмүүстэй хамтран энэ салбар, чиглэлийн хурал, хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж боловсруулан төрийн эрх мэдлийн байгууллагуудад хүргүүлэх байдлаар ажил хийддэг.

Тухайлбал, ДХИС-ийн ЭШХ- гээс 2023 оны нэгдүгээр сард Монголын дугуйн холбооны нарийн бичгийн дарга Зундуйн Наран болон бусад удирдлагуудтай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж, энэ орчинд тулгамдаж байгаа асуудлуудын талаар хэлэлцэж, зохих хэмжээнд ач холбогдлоо өгсөн юм.

Унадаг дугуйн жолоочид тавигдах шаардлагыг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд тодорхой болгох талаар иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтарсан судалгаа хийх шаардлага гарч байгаа юм.

Хүн анхлан хөлд орсноос эхлэн явганаар замын хөдөлгөөнд оролцож сурах нь аюулгүй байдлыг хангах урьтал нөхцөл бүрдэж байна гэсэн үг.

Дэлхийн улс орнуудад хүний энэхүү хөгжлийн үе шатад шинжлэх ухаанчаар хандан, замын хөдөлгөөнд оролцогчийн сургалтыг цэцэрлэг, яслийн насны хүүхдийн сэтгэхүйн онцлогт тохируулан хийх шаардлагын талаар болон ба явганаас дугуйтай, дугуйнаас мопедоор, мопедоос мотоциклоор хөдөлгөөнд оролцуулах сургалтуудыг хийж ирсэн байдаг.

Манай улсад Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого ч энэ хадлагатай зохицож, явганаар хөдөлгөөнд оролцуулж сургаад дараа нь дугуйн болон мотоциклын жолооч болгох сургалтуудыг ухаалгаар зохицуулах нь үр дүнтэй гэж харагдаж байна.

Унадаг дугуйг үйлдвэрлэж эхэлсэн цагаас л цэрэг, дайны, төрийн тусгай болон үйлчилгээний олон ажлуудыг гүйцэтгэж байсан ба тухайлбал, Европын өндөр хөгжилтэй орнуудад , цэрэг арми, цагдаа бусад тусгай албанд түүнчлэн онцгой байдлын, түргэн тусламжийн үйлчилгээнд өргөнөөр ашиглаж байна⁵⁶.

Техникийн хөгжил дэвшлийг хязгаарлах боломжгүй бөгөөд хүн төрөлхтөн одоо хөдөлж байгаа хурднаасаа илүү их хурд руу тэмүүлж байгаа билээ.

Унадаг дугуйгаар хөдөлгөөнд оролцогч зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчилд өртсөн статистик мэдээнээс харахад өнгөрсөн 2021-2022 оны байдлаар өсөх хандлагатай байна. Мэдээжээр зам тээврийн ослын тоог тэглэх бололцоогүй боловч тэг рүү тэмүүлэх боломжийг мэргэжлийн албад, судлаачид хариуцсан салбар бүрдээ тогтоох гэсэн оролдлогуудыг хийж иржээ.

Нэн түрүүнд зам тээврийн осол, гэмт хэргийн бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд жилээс жилд өсөх хадлагатай ба гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дэлхий нийтэд үр дүнтэй бодлого боловсруулан хэрэгжүүлж байгаа туршлагыг судалж үзэх нь нэн чухал юм. Дээрх судалгааны үр дүнг Монгол хүний сэтгэл зүй, ёс уламжлал, цаг уур, газар нутгийн байрлал зэрэг бусад хүчин зүйлсийг харгалзан үзэж өөрийн орны арга тактикийг боловсруулах шаардлагатай.

⁵⁶ www.velotransunion.ru/proekt_fz

Монгол хүний сэтгэл зүйн онцлог ерөнхий шинжийг маш тайван, дөлгөөн аливаад хүлээцтэй ханддаг байсан талаар аль хэдийнээ тодорхойлсон байдаг.

Сүүлийн 100 жилийн түүхээс харахад Монголчууд нүүдлийн соёл иргэншлээс суурьшмал хэв шинжид аажмаар шилжихдээ, мал ахуйгаасаа холдон дугуй болон моторт унааг хэрэглэн нийгмийн харилцаанд сэтгэл зүйн шинэ хандлагыг бий болгосон байдаг⁵⁷.

Амьгүй зүйлийг амилуулах мэт хөдөлгөөн жолоодож тодорхой хурдны өөрчлөлтийг мэдэрч үзэх хүсэл хүн бүрд төрдөг.

Монголчуудын хувьд амьтай, ердийн хөсөгт тээврийн хэрэгслээ амьгүй механикжсан, моторт унаагаар сольж түүнийгээ амьтай мэт болгон илүү их хурдыг мэдэрч давхих зэрэг нь сэтгэл зүйн болон бусад хэв маягийн нэлээд өөрчлөлтийг дагуулсан⁵⁸.

Ердийн хөсгийн уламжлалт сургалтын арга зүй нь тээврийн хэрэгсэл болон техникийг ашиглан замын хөдөлгөөнд оролцох дадлага сургалтаас эрс өөр юм.



Хамгийн аюул эрсдэл ихтэй тээврийн хэрэгсэлд унадаг дугуйг тооцдог байсан бол цахилгаан дугуйн үйлдвэрлэл эрчимжсэнээс хойш хүүхэд залуус цахилгаан дугуйг өргөнөөр хэрэглэх болж, мөн энэ төрлийн гэмт хэргийн тоо, нас барсан, гэмтсэн хүний тоо нэмэгдсээр байна.

Зөвхөн Монгол улсын хэмжээнд төдийгүй дэлхийн олон улс орнууд тухайлбал, Америк, Канад, ОХУ болон Европын холбооны өндөр хөгжилтэй улсуудын хувьд ч асуудал дагуулж байгаа билээ⁵⁹.

Энэ байдлыг гадаадын дээрх улсуудад эрдэм шинжилгээний багуудыг тусгайлан байгуулан хэрэгцээт судалгааны ажил хийж, шалтгаан нөхцөлийг нь тодруулан хийж хэрэгжүүлэх арга хэмжээг томьёолон хууль, журам боловсруулан хэрэгжүүлснээр тодорхой амжилтад хүрсэн мэдээлэл байна.

Тухайлбал, АНУ, Канад зэрэг орнуудад цахилгаан дугуйн аюулгүй байдалд тавигдах шаардлага, үйлдвэрлэлийн стандарт, норм дүрэм журам байдаг⁶⁰. Дэлхийн олон улс оронд цахилгаан унадаг дугуйн хэрэглээ, замын хөдөлгөөнд хэрхэн оролцох талаар, түүний тохиромжтой хурдны үзүүлэлтийн талаар болон бусад аюулгүй байдлын шаардлага, эрх зүйн харилцааг зохицуулсан хуулийг батлан хэрэглэж байна. Европын Холбоонд нэгдсэн улсууд зэрэг бусад улсууд ашиглалт, аюулгүй байдлын талаар өргөн хүрээтэй хууль тогтоомжийг батлахаар тохиролцсон байна.⁶¹

Гэхдээ улс орнуудын хууль тогтоомж, нэр томьёонууд хоорондоо өөр өөр байдаг. Зарим улс орнууд үндэсний хэв шинжийг хадгалсан зохицуулалттай байдаг ч зам ашиглах талаар гаргадаг норм дүрэм журмыг тухайн орон нутаг, мужуудын мэдэлд үлдээдэг. Энэхүү

⁵⁷ Д.Нямдорж “Тээврийн хэрэгслийн түүхийн лекц”

Улаанбаатар хот 2012 он

⁵⁸ <https://bank.nauchniestati.ru/primery/diplomnaya-rabota-na-temu-osobennosti-pravovogo-regulirovaniya-dvizheniya-velosipednogo-transporta-imwp/>

⁵⁹ <http://veloclub.su/novosti/novosti-drugoe/item/473-2015-03-03-16-07-25>

⁶⁰ Конвенция о дорожном движении Вена хот 1968 он

⁶¹ https://wiki5.ru/wiki/Electric_bicycle_laws

өөр өөрийн гэсэн суурин газрын доторх замын хөдөлгөөний дүрэм, журам, хууль тогтоомж, хязгаарлалтууд нь нэг талдаа нэмэлт төвөгтэй байдлыг нэмэгдүүлдэг. Энэ нь хөдөлгөөнд оролцогч нарт өөр өөр эргэлзээ, өөртөө үл итгэх байдлыг үүсгэдэг.

Ангилал, системүүдийн нэршлүүд ч бас өөр хоорондоо ялгаатай байх нь төвөгтэй байдлыг бий болгодог. Шүүн таслах ажиллагаа болон хууль зүйн практикт "цахилгаан дамжуулгат унадаг дугуй" (Канадад), "цахилгаан дамжуулгат унадаг дугуй" (Европын холбоо болон Их Британид) эсвэл зүгээр л "цахилгаан унадаг дугуй" гэж гэсэн нэршлүүдийг хэрэглэж байна⁶². Зарим улс орнуудад цахилгаан эрчим хүч хэрэглэдэг унадаг дугуйнууд нь энгийн унадаг дугуйнуудаас эрс ялгаатай гэж тусад нь ангилж үздэг байна.

Дүгнэлт: Монгол улсын хувьд дээрх орнуудад хэрэглэгдэж байгаа эрх зүйн харилцаа цаг хугацааны хувьд урган гарч ирж байгаа бөгөөд энэ төрлийн суурь болон хавсарга судалгааг хийж шинэ төрлийн эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай тулгамдаж байгаа асуудлуудын нэг болжээ. Унадаг дугуйн болон зам тээврийн осол хэргийн талаарх судалгаа маш бага хийгдэж байна. Энэ талын судалгаа бага байгааг жил бүхэн Зам тээврийн осол, хэргийн цагаан номноос харахад боломжгүй. Тухайлбал, гэм буруугийн үйлдлийн шалтгаан нь:

- Унадаг жолоочоос уу?;
- Унадаг дугуйн болон цахилгаан унадаг дугуй нь техникийн хувьд тавигдах шаардлагыг хангасан эсэх;
- Мэргэжлийн түвшинд баригдаж бүтээгдсэн, унадаг дугуйн замын судалгаа;
- Замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, түүний тоноглол, эрх зүйн орчны байдал;
- Бусад хүчин зүйлээр судлан гаргахгүй байгаад оршиж байна гэж үзэж байна.

Санал: Унадаг дугуйн болон цахилгаан унадаг дугуйн хууль эрх эх зүйн орчныг сайжруулах чиглэлээр дараах саналыг боловсруулж байна. Үүнд:

✓ Унадаг дугуйн сургалтыг сайжруулах чиглэлээр одоогийн хэрэглэгдэж байгаа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд, унадаг дугуйн жолооч нэршлийг тодотголтойгоор оруулах;

✓ Замын хөдөлгөөний дүрмийн хорин тавдугаар бүлгийн⁶³. “Унадаг дугуй, мопедоор хөдөлгөөнд оролцоход тавих нэмэлт шаардлага”-ын 25.3 дахь хэсэгт унадаг дугуйн жолоочийн сургалтыг хэрхэн хийх талаар нэмэлтээр тусгах; /жишээ нь: 10 хүртэлх насны хүүхдийн унадаг дугуйн сургалтын хөтөлбөр, түүнд төрөөс хэрхэн хяналт тогтоох талаар гэх мэт.../

✓ “Унадаг дугуй, мопедоор хөдөлгөөнд оролцоход тавих нэмэлт шаардлага”-ын 25.10 дахь хэсгийг шинээр үүсгэн унадаг дугуйн жолоочийн сургалтын хөтөлбөрийг хангасан иргэдэд шалгуурыг хэрхэн тогтоох, ямар мэдлэгтэй байх, ямар чадвар суусан байх талаар тусгах;/Жишээ нь: ЗХД-ийн 25.10 “Унадаг сургалтад хамрагдсан 14 хүртэлх насны иргэн нь энэ дүрмийг тусгай хөтөлбөрийн дагуу ерөнхий боловсролын сургуульд үзэж судлан, тодорхой шалгуурыг хангах/

✓ Цахилгаан унадаг дугуйн замын хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмыг боловсруулах;

✓ Гаалиар импортоор орж ирж буй цахилгаан дугуйнд татвар ногдуулах болон хяналт тогтоох, тээврийн хэрэгсэлд тавигдах нэмэлт шаардлагуудыг болон хөдөлгөөний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг хангах журам боловсруулан хэрэгжүүлэх;

✓ Дээрх журам хяналт тогтоох бодлого, системийг бүрдүүлэх;

⁶² <https://bank.nauchniestati.ru/primery/diplomnaya-rabota-na-temu-osobennosti-pravovogo-regulirovaniya-dvizheniya-velosipednogo-transporta-imwp/>

⁶³ Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм 25 дугаар бүлэг УБ. 2018.

✓ Замын хөдөлгөөний дүрмийн Арван хоёрдугаар бүлэг. “Тээврийн хэрэгслийн хурд”-ын 12.5-ын Дараах тохиолдолд тээврийн хэрэгслийн хурдыг дор дурдсанаас хэтрүүлэхгүйгээр сонгож явна гэсэнд:

е/ цахилгаан унадаг дугуй суурин газрын гадна цагт 40 км, тууш замд цагт 60 км; байхаар нэмэлтээр оруулах;

✓ Замын хөдөлгөөний дүрмийн 3.4-ийн “Жолооч дараах үүргийг хүлээнэ гэсний:

в/ мотоцикл, мопед жолоодохдоо хамгаалах малгайг зааврын дагуу өмсөх, хамгаалах малгай өмсөөгүй зорчигч тээвэрлэхгүй байх⁶⁴; гэсэн хэсэгт өөрчлөлт хийж, **в/ мотоцикл, мопед, цахилгаан унадаг дугуй жолоодохдоо хамгаалах малгайг зааврын дагуу өмсөх, хамгаалах малгай өмсөөгүй зорчигч тээвэрлэхгүй байх**; хэмээн өөрчлөх;

✓ Мөн Замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, тэмдэг тэмдэглэгээ зэргийг унадаг дугуй болон цахилгаан унадаг дугуйнд зориулан хийж хэрэгжүүлэх гэсэн саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материал

1. Замын хөдөлгөөний дүрэм. Монгол улсын засгийн 2018 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 239 дүгээр тогтоолын хавсралт Улаанбаатар хот 2018 он.

Цахим эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208663&showType=1>

2. Конвенция о дорожном движении от 08.11.1968// Сборнике действующих договоров, соглашений и конвенций, заключенных с иностранными государствами, М.- 1979.- №- XXXIII.-с. 385 2.Конвенция о дорожных знаках и сигналах: 08.11.1968

Цахим эх сурвалж: <https://bank.nauchniestati.ru/primery/diplomnaya-rabota-na-temu-osobennosti-pravovogo-regulirovaniya-dvizheniya-velosipednogo-transporta-imwp/>

3. Бабкин С. Велосипеды в Германии Москва 2017.

Цахим эх сурвалж: <https://www.tupa-germania.ru/transport/velosipedy.html>

4. Bussgeldkatalog 2017: Straßenverkehrsordnung (StVO) — Dasgilt auf deutschen Straßen.

Цахим эх сурвалж: <https://www.bussgeldkatalog.org/stvo/>

5. Велотранспортный Союз[Электронный ресурс]:О совещании в комитете Государственной Думы по транспорту.

Цахим эх сурвалж: <http://www.velotransunion.ru/node/946>

6. Велотранспортный Союз[Электронный ресурс]: Проект Федерального Закона «О велосипедном транспорте в РФ».

Цахим эх сурвалж:

7. Velolive: Светофоры для велосипедистов.

8. Veloclub: Законопроект о велосипедных дорожках и велосипедных парковках.

Цахим эх сурвалж:

9. <http://veloclub.su>

10. <https://bank.nauchniestati.ru>

11. <https://mn.wikipedia.org>

12. http://www.velotransunion.ru/proekt_fz

13. <https://velolive.com>

⁶⁴ Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм. УБ. 2018.

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ
ЗӨРЧЛИЙН ОЙЛГОЛТ, ШИНЖ
VIOLATIONS AGAINST ROAD SAFETY DESCRIPTION
AND CHARACTERISTICS

*Д.Энх-Амар
Дотоод хэргийн их сургуулийн ЭЗНУС-ийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахмад*

*D.Enkh-Amar
Teacher of the Public Law Department of the Law School of
the University of the Interior, Police Captain*

Товч агуулга. Зам тээврийн ослоос гадна замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил ихээр гарч байгаад дүн шинжилгээ хийж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох, энэ асуудлыг шийдвэрлэх арга замыг боловсруулахтай холбоотой олон судалгааны ажлууд дэлхийн улс орнуудад хийгдсээр байна. Энэхүү өгүүлэлд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийн ойлголт, шинжийн талаар дэлгэрүүлэн судлав.

Abstract. In addition to road traffic accidents, many research activities related to the analysis of traffic safety violations, identification of the factors affecting them, and development of solutions to this problem are being carried out in countries around the world. In this article, the concepts and characteristics of violations against road traffic safety are studied in detail.

Түлхүүр үг. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил, захиргааны зөрчил, хүн, тээврийн хэрэгсэл

Key word. Violations against traffic safety, administrative violations, persons and vehicles

Удиртгал. Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан “Амьд явах эрхтэй; 2-т эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 2.1-т замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль, захиргааны хэм хэмжээний актаас бүрдэнэ гэж заасан. Эдгээр заалт нь иргэдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчил, ослоос ангид байж эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн гол эрх зүйн зохицуулалт юм. Уг хууль нь замын хөдөлгөөний зохион байгуулалт, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх ашгийг хамгаалахад чиглэгдэж, 2015 онд шинэчлэн батлагдсан.

Өнөөгийн нийгэмд хамгийн их эрсдэл учруулж байгаа зүйл бол авто машины осол, аваар бөгөөд зөрчил гарахад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хамгаалалтын бүс, малгай, аюулгүйн бүс хэрэглэхгүй байх, хурд хэтрүүлэх, гар утсаар ярих, нүүрээ будах /эмэгтэйчүүд/, тамхи асаах, хүүхэдтэйгээ зууралдах зэргээр анхаарал сарнихад жолоочийн хөдөлгөөн удаашрах, гэрэл дохио анхаарахгүй, эгнээ байр эзлэхдээ бусдыг анзаарахгүй байх, хажуу хоорондын зайг

тохируулахгүй байх нь жолоочийн ур чадварт шууд нөлөөлж, зам тээврийн осол гардаг. Мөн зам тээврийн ослын шалтгаан нь замын нөхцөл байдал, тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл, жолоочийн буруугаас, орчны нөлөөлөл гэсэн зүйлүүдээс хамааралтай.

Монгол Улсад зам тээврийн ослын шинжтэй 101233 дуудлага хүлээн авснаас 24121 зам тээврийн ослыг шалгаж шийдвэрлэсэн байна. Үүнээс 21098 буюу 87.5 хувь нь эд материалын хохиролтой осол, 3023 буюу 12.5 хувь хүн гэмтсэн (хүний амт нас, эрүүл мэнд) зам тээврийн осол байна.⁶⁵

Зам тээврийн ослоос гадна замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил ихээр гарч байгаад дүн шинжилгээ хийж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох, энэ асуудлыг шийдвэрлэх арга замыг боловсруулахтай холбоотой олон судалгааны ажлууд дэлхийн улс орнуудад хийгдсээр байна.

Зам тээврийн осол, зөрчил гарахад зам, тээврийн дэд бүтцийн чанар, тээврийн хэрэгслийн чанар, хүний хүчин зүйл зэрэг нь нөлөөлдөг хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Өнгөрсөн жилийн зам тээврийн осол, зөрчлийн судалгаагаар жолоочийн буруутай үйлдэж буй зөрчлийн эзлэх хувь дунджаар 95% гэж тооцоолсон байна. Жолоочийн буруутай үйлдэж буй зам тээврийн осол, зөрчил нь хүний болон зан үйлийн хүчин зүйлүүд нөлөөлж байгаа талаар судалсан байдаг.

Хүн тээврийн хэрэгсэл жолоодох нь танин мэдэхүйн болон шийдвэр гаргах үйл ажиллагааг нэгэн зэрэг гүйцэтгэх бөгөөд жолоодлогын хурдыг шаарддаг нарийн төвөгтэй үйл ажиллагаа юм. Жолоочийн танин мэдэхүй нь жолоодлогын үеийн нөхцөл байдлыг танин мэдэж, ойлгож, түүн дээр үндэслэн шийдвэр гаргах бөгөөд энэ нь үр дүнтэй эсхүл буруу шийдвэрүүд байж болно. Жолооч нар жолоодлогын үед түрэмгий, ууртай, стресстэй жолоодох зэрэг сэтгэл зүйн хувьд олон янзын нөхцөл байдлыг мэдэрдэг.

Зам тээврийн осол, зөрчил гарахад жолоочийн буруутай үйлдлүүдийн гол шалтгааны нэг нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг зөрчих, захирагдахгүй байх явдал байдаг. Тухайлбал, замд улаан гэрлээр зорчих, хурд хэтрүүлэх, тээврийн хэрэгслийн бүсээ зүүхгүй байх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зэрэг зөрчлүүдийг үйлдсээр байна. Тиймээс замын хөдөлгөөний дүрэм, журмыг дагаж мөрдөх асуудалд анхаарал хандуулах нь иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн чухал арга замуудын нэг юм.

Үндсэн хэсэг. Зөрчлийн тухай хуулиар замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг тодорхойлон заасан бөгөөд жолооч зөрчил уг хуулийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан торгох, баривчлах, эрх хасах шийтгэлийг ногдуулахаар заасан. Зөрчлийн тухай хуульд “хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил гэнэ”⁶⁶ тодорхойлсон. Зөрчил гэх нэр томьёоны хувьд урьд нь “захиргааны зөрчил” гэх нэршлээр хэрэглэгдэж байсан бөгөөд захиргааны эрх зүйн эрдэмтэн судлаачид уг нэр томьёогоор ном бүтээлдээ дурдсан нь бий.

Зөрчлийн тухай хууль батлагдахаас өмнө “захиргааны зөрчил”-ийг Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар тодорхойлж, томьёолж, шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байв. Уг хуулийн 3 дугаар зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр

⁶⁵ Баасансүрэн .Т Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хүлээлгэх хариуцлага, түүнд хийсэн шинжилгээ. Магистрын ажил. УБ., 2023 он. 6 дах тал

⁶⁶ Зөрчлийн тухай хууль. Төрийн мэдээлэл. 2017он. №24.

буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журам санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчил”⁶⁷ гэж тодорхойлсон.

Захиргааны хариуцлагын тухай хуулиас гадна Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нийт 230 гаруй хуульд зааснаар захиргааны зөрчилд хариуцлага хүлээлгэж байв. Тиймээс Зөрчлийн тухай хуулиар захиргааны зөрчлийг цэгцэлж, нэгдсэн бодлогоор тодорхойлж, нэг стандартаар төрөлжүүлэн нэгтгэсэн. Зөрчлийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг харьцуулан авч үзье.

Хүснэгт 1. Зөрчлийн тухай болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн харьцуулалт⁶⁸

№	Захиргааны хариуцлагын тухай хууль	Зөрчлийн тухай хууль
	25 дугаар зүйл. Хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих	14.7 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих
1	1.Согтууруулах ундааны зүйл уусан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож явсан, эсхүл согтууруулах ундааны зүйл уусан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол	3.Жолооч: 3.1.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон; 3.2.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол 4.Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн бол
2	2.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон бол	1.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол 2.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл эрх нь дуусгавар болсон хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн бол
3	3.Ашиглахыг хориглосон, гэмтэлтэй буюу зохих зөвшөөрөлгүйгээр өөрчлөн тоноглосон тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон, эсхүл дээрхи тээврийн хэрэгслийг замд гаргах зөвшөөрөл олгосон, түүнчлэн тогтоосон журмын дагуу бүртгүүлээгүй, техникийн улсын үзлэгт хүндэтгэх шалтгаангүйгээр оруулаагүй, зам тээврийн осолд орсон тээврийн хэрэгслийг зохих байгууллагад мэдэгдэлгүйгээр засварт оруулсан бол	10.Хуульд заасан журмын дагуу: 10.1.улсын бүртгэлд бүртгүүлээгүй; 10.2.техникийн хяналтын үзлэгт оруулаагүй; 10.3.техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцсон бол 16.Хуулиар хориглосон тусгай дуут болон гэрлэн дохио суурилуулсан тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон бол
4	4.Явган болон унадаг дугуй, ердийн хөсгөөр зорчигч этгээд хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн бол	52.Хүн, хуулийн этгээд: 52.1.замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлэх; 52.2.зам дээр, түүний ойр орчимд ажил, үйлчилгээ хийхдээ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаагүй; 52.3.оршин байгаа газартаа хамаарах замын бохирдол, цас, мөсийг цэвэрлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн

⁶⁷ Захиргааны хариуцлагын тухай хууль. УБ., Хүчингүй болсон. 1992он.

⁶⁸ Баасансүрэн .Т Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хүлээлгэх хариуцлага, түүнд хийсэн шинжилгээ. Магистрын ажил. УБ., 2023 он. 8 дах тал

		этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 53.Явган зорчигч, эсхүл тээврийн хэрэгслээр зорчигч замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн бол хүнийг арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5	5.Жолооч болон тээврийн байгууллагын ажилтан хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	56.Жолоочийн: 56.1.хөдөлмөр, амралтын горимыг зөрчсөн, эсхүл холбогдох хуульд нийцүүлээгүй; 56.2.жолоочийн ажил үүргийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн зохион байгуулаагүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6	6.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд	5.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол
7	7.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	14.Ажлын тоормосын систем, жолооны механизм ажиллахгүй, чиргүүлийн холбоос /чиргүүлтэй үед/ эвдэрсэн, эсхүл харанхуй, үзэгдэх орчин хязгаарлагдмал үед гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл нь бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 15.Энэ зүйлийн 14 дэх хэсэгт зааснаас бусад ашиглахыг хориглосон бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Дээрх хүснэгтээс харахад Захиргааны хариуцлагын тухай хуульд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 7, Зөрчлийн тухай хуульд 57 зөрчилд хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг “эрх зүйн зөрчил” гэсэн ерөнхий нэр томьёо, дээрх захиргааны зөрчил гэсэн нэр томьёоны агуулгад тулгуурлан дараах байдлаар тодорхойлон авч үзлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил гэдэг нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм зөрчсөн, нийгэмд хор уршиг бүхий хууль зүйн сөрөг үр дагавар үүсгэж, хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй, субъектын гэм буруутай үйлдэл, эс үйлдэл юм⁶⁹.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил нь дараах үндсэн шинжүүдтэй. Үүнд:

1) Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг чиглэсэн байх /хууль зүйн үүргээ үл биелүүлэх/. Энэ нь а/ эрх зүйн зөрчил нь *үйлдэл* ба *эс үйлдэхүйгээр* илэрнэ. Харин хүний хүсэл зоригоос үл шалтгаалах үйл явдал (казус-тохиолдол гэсэн латин гаралтай үг) болон хүний бодол санаа, мөрөөдөл эрх зүйн зөрчил болохгүй. б/ эрх зүйн хэм хэмжээний эсрэг чиглэсэн, эсхүл зөрчсөн байна. Эрх зүйн зарим зөрчил нь бэлтгэлт, завдалтын үедээ, зарим нь тодорхой бодит хор уршиг учруулснаар төгс үйлдэгдсэнд тооцогдоно. Бэлтгэлт завдалтаар төгс үйлдэгдсэнд тооцогдох зөрчлийг эрх зүйн хэлбэрийн бүрэлдэхүүнтэй,

⁶⁹ Нямсүрэн. Ч, Эрх зүйн ерөнхий онол. Уб., 2014он.

бодит хор уршиг бий болсноор төгс үйлдэгдсэнд тооцогдох эрх зүйн зөрчлийг эрх зүйн бодит бүрэлдэхүүнтэй зөрчил гэнэ⁷⁰.

2) Хүн, нийгэм, төр, аж ахуйн нэгж байгууллагад /хуулийн этгээдэд/ хор аюултай байх /гэм хор учруулах, бусад аюултай байдал үүсэх/. Энэ шинж нь эрх зүйн зөрчлийн хамгийн үндсэн шинж болдог. Нийгэм, бие хүний ашиг сонирхол эрх зүйн харилцаанд хор хүргэсэн, өөрөөр хэлбэл, эрх зүйн харилцаанд хор хүргэж болох байснаар нийгэмд аюултай байдаг.

3) Замын хөдөлгөөнд оролцогчдын гэм буруутай зан үйл байх /гэм буруугийн санаатай болон болгоомжгүй хэлбэртэй байна/.

4) Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, журмыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй байх /хүний хүсэл зоригоос үл хамаарах үйл явдал ба санаа бодол үл хамаарна/. Эрх зүйн хэм хэмжээний актад тусгагдсанаар эрх зүйг зөрчсөн, түүний эсрэг чиглэсэн зан үйл нь хоёр хувилбартай байж болно. Нэгдүгээрт хориглосон хэм хэмжээг зөрчсөн, хоёрдугаарт хууль зүйн үүргээ биелүүлээгүй байдлаар илэрдэг.

5) Хариуцлага хүлээлгэхээр хуульчлагдсан байх /эрх зүйн зохих санкц хэрэглэх үндэслэлтэй байна/.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийн бүрэлдэхүүн нь тухайн үйлдэл, эс үйлдэхүйг эрх зүйн зөрчил мөн болохыг тодорхойлж, эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй гэдгийг илэрхийлдэг объектив ба субъектив шинжүүдийн нийлбэр бүрдэл бөгөөд дараах хэсгүүдээс бүрдэнэ⁷¹.

- Объект /өртөгдөхүүн/
- Объектив тал /гадаад шинж/
- Субъект /эзэн этгээд/
- Субъектив тал /дотоод шинж/


Зөрчлийн объект гэдэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрт болон тодорхой нутаг дэвсгэрт дагаж мөрдөхөөр тогтоосон захиргааны журмаар хамгаалагдаж байгаа нийгмийн харилцаа юм. Эрх зүйн зөрчил гаргагчийн үйлдэл, эс үйлдэхүйд өртөгдөн зөрчигдсөн бөгөөд эрх зүйгээр хамгаалагдсан хүн, төр, нийгмийн эрх, ашиг сонирхол юм. Жишээлбэл, хүний амьд явах, өмчлөх, сурч боловсрох, чөлөөтэй зорчих, хөдөлмөрлөх эрх, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, Монгол Улсын тусгаар тогтнол Үндэсний аюулгүй байдал, хилийн халдашгүй дархан байдал, байгаль орчин гэх мэт.

Зөрчлийн хувьд захиргааны хэм хэмжээгээр нийтээр буюу тодорхой нутаг дэвсгэрт дагаж мөрдөхөөр урьдаас журамлан тогтоогоогүй бол уг үйлдэл, эс үйлдэхүй нь нийгэмд хор уршиг учруулсан ч зөрчлийн хариуцлага хүлээлгэхгүй. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийн гол объект нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмээр хамгаалагдсан нийгмийн харилцаа. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцэж гарсан эрх зүйн зохицуулалт нь хууль зөрчиж буй этгээд, хүмүүсийн хууль бус зан үйлээс хамгаалж байдаг.

⁷⁰ Нямсүрэн. Ч, Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2020 он. 358 дахь тал.

⁷¹ Эрдэнээ Х, Даваажав Б. Цагдагийн байгууллагаас захиргааны зөрчилтэй хэрэг, хянан шийдвэрлэх ажиллагаа. УБ., 2015 он. 20 дахь тал.

Зураг 1. ЗХАБ-ын эсрэг зөрчлийн объект нь төрөл



Зөрчлийн объектив тал гэдэг нь эрх зүйн зөрчлийн гадаад илрэх байдал бөгөөд эрх зүйн зөрчил гаргагч этгээдийн хууль бус зан үйл, түүнтэй холбоотой бусад шинжээс бүрдэнэ. Эрх зүйн зөрчил нь объектив талын хувьд субъектын хууль бус зан үйл болох үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрнэ. Үүнийг эрх зүйн зөрчлийн объектив талын үндсэн шинж гэнэ. Харин объектив талын нэмэгдэл шинжид хор уршиг, шалтгаант холбоо, эрх зүйн зөрчил гарсан цаг хугацаа, газар, нөхцөл байдал, арга зэвсэг хэрэгсэл гэсэн элементүүд хамаарна.

Зөрчлийн субъект гэдэг нь ЗХАБ-ын эсрэг зөрчлийн субъект нь эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн буюу ЗХАБ-ын тухай хууль, дүрэм зөрчсөн байх бөгөөд хуулиар эрх эдэлж, үүрэг хүлээж, өөрийн гэмт зан үйлийнхээ үр дагаврыг хариуцах чадамжтай “эрх зүйн харилцаанд оролцогч тал” байна. Өөрөөр хэлбэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг эрх зүйн зөрчил гаргагч эзэн этгээд юм.

Зөрчлийн тухай хуульд зааснаар зөрчлийн субъектэд хүн, хуулийн этгээдийг хамааруулж үзнэ. Хувь хүн эрх зүйн зөрчлийн субъект болох шинжийг авч үзвэл:

- Хэрэг хариуцах чадвартай байх;
- Хуулиар тогтоосон насанд хүрсэн байх;
- Гаргасан эрх зүйн зөрчилдөө гэм буруутай байх ёстой.

Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлд шийтгэл хүлээх хүн, хуулийн этгээдийн талаар заасан. Үүнд:

- 1) Арван зургаан насанд хүрсэн хүн;
- 2) Хуулийн этгээдэд шийтгэл оногдуулна.

Гэхдээ зарим төрлийн зөрчилд зөрчил үйлдсэн арван дөрвөөс арван найман насны хүний хувийн байдал, зөрчлийн шинж, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдлыг харгалзан шийтгэлээс чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

Мөн 14-16 нас хүртэлх насны хүн ЗтХ-ийн тусгай ангийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан зөрчил үйлдсэн бол түүнд шийтгэл хүлээлгэнэ.

ЗХАБ-ын эсрэг зөрчлийн хувьд 14.7-ийн 5 дахь хэсэгт “тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна” гэж заасан. Энэ зөрчилд 14-16 насны хүнд захиргааны шийтгэл ногдуулахаар заасан байна.

Шийтгэлээс чөлөөлөх үндэслэл нь:

1. Тулгарсан аюулыг өөр арга хэрэгслээр арилгах боломжгүй нөхцөлд учирч болох аюулын хэр хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр үйлдсэн энэ хуульд заасан зөрчлийн шинжтэй үйлдэлд шийтгэл оногдуулахгүй.

2. Сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюулыг ухамсарлах, өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй хүнийг хэрэг хариуцах чадваргүйд тооцно.

3. Зөрчил үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүнд шийтгэл оногдуулахгүйгээр хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

4. Төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуульд заасан зөрчлийн шинжтэй бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Төрийн албан хаагчийн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоогүй зөрчилд энэ хуульд заасан нийтлэг журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Зөрчлийн субъектив тал эрх зүйн зөрчлийн дотоод агуулгын шинж бөгөөд ЗХАБ-ын эсрэг зөрчил гаргагчийн гэм буруу, сэдэлт, зорилго, сэтгэл санааны байдал гэсэн элементээс бүрддэг. Дараах хүснэгтээс элементийн уялдаа холбоог харж болно.

Хүснэгт 2. Субъектив тал⁷²

Зөрчлийн субъектив тал	Санаатай гэм буруу		Болгоомжгүй гэм буруу	
	Шууд санаа	Шууд бус санаа	Хөнгөмсгөөр найдах	Хайхрамжгүй хандах
Хор уршгийг урьдчилан харсан	+	+	-	-
Хор уршигт хүргэхийг хүссэн	+	+ - Үйлдэлдээ санаатай, үр дагавартай, болгоомжгүй	-	-
Хор уршигт хүргэсэн	+	+	+	+

Хүснэгтээс харахад гэм буруу гэж субьектээс өөрийн үйлдэл, эс үйлдэхүй түүний улмаас бий болох хор уршигт хандсан сэтгэхүйн харьцааг хэлдэг бөгөөд гэм буруу нь санаатай ба болгоомжгүй гэсэн 2 хэлбэртэй байна.

Гэм буруугийн санаатай хэлбэр нь субьект өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг ухамсарлан ойлгосон бөгөөд өөрийн үйлдэл эс үйлдэхүйн улмаас учрах хор уршгийг мэдсээр атал хүсэж буюу эсхүл тэр хор уршигт зориудаар хүргэсэн байхыг хэлнэ.

Санаатай хэлбэр нь шууд ба шууд бус санаа гэж 2 ангилагдана. Шууд санаа гэдэг нь хүсэж үйлдсэн, шууд бус гэж хүсээгүй боловч хор уршигт зориуд хүргэсэн байхыг хэлнэ.

Болгоомжгүй хэлбэр гэдэг нь субьект өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг ухамсарлан ойлгосон боловч хор уршиг гаргахгүй байж чадна гэж хөнгөмсгөөр найдсан эсхүл эрх зүйн

⁷² Нямсүрэн. Ч, Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2020 он. 366 дахь тал.

хэм хэмжээ зөрчинө, хор уршиг учрана гэдгийг урьдаас мэдэх ёстой, мэдэх бололцоотой байсан атал мэдээгүй үйлдсэн байхыг хэлнэ.

Болгоомжгүй хэлбэр нь хөнгөмсгөөр найдсан, хайхрамжгүй хандсан гэж 2 ангилагдана. Хөнгөмсгөөр найдсан гэдэг нь эрх зүйг зөрчихгүй байж чадна гэж баттай итгэсэн боловч хор уршиг учруулсан явдал юм.

Хайхрамжгүй хандсан гэж гэмт үйлдлийнхээ нийгмийн хор аюулыг ухамсарлаагүй, мөн ухамсарлах, урьдчилан харах ёстой байтал урьдаас харж чадаагүй зэрэг байдлаар илэрнэ.

Зөрчлийн тухай хуульд заасан тодорхойлолтод захиргааны хэм хэмжээ гэж “хуулиар эрх олгосон хүрээнд төрийн эрх бүхий байгууллага Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу боловсруулж, баталсан нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам”⁷³-ыг хамааруулан авч үзнэ. Түүнчлэн хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцно.

Зөрчил нь хүн, хуулийн этгээдийн идэвхтэй үйлдэл буюу эс үйлдэл зан үйлээр дамжин илэрдэг. Үйлдэл хийх гэдэг нь хүн, хуулийн этгээдийн идэвхтэй байдал, үйл хөдлөлөөр илэрхийлэгдэнэ.

Дүгнэлт. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль шинэчлэн батлагдсанаар өмнөх хуульд урьд зохицуулагдаж байгаагүй нэлээдгүй харилцааг зохицуулсан нь их чухал ач холбогдолтой болжээ. Тухайлбал, УИХ, ЗГ, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх, үүрэг, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаар заасан нь төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн. Мөн иргэдийн эрх, үүргийг тодотгож, жолоочийн оноо, жолоочийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд анхаарч, жолоодох эрхийн үнэмлэхийг хугацаатай байх зэргээр заажээ. Гэсэн хэдий ч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой бусад хэм хэмжээний актуудыг хууль тогтоомжид нийцүүлэх, хоорондыг уялдаа холбоог хангах шаардлага байна.

Ашигласан материал.

Монгол Улсын хууль тогтоомж:

2. Монгол Улсын Үндсэн Хууль
3. Зөрчлийн тухай хууль.
4. Захиргааны хариуцлагын тухай хууль.
5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

Ном, бүтээл, гарын авлага:

6. Нямсүрэн. Ч, Эрх зүйн ерөнхий онол. Уб., 2014 он.
7. Нямсүрэн. Ч, Эрх зүйн ерөнхий онол. Уб., 2020 он.
8. Эрдэнээ Х, Даваажав Б. Цагдагийн байгууллагаас захиргааны зөрчилтэй хэрэг, хянан шийдвэрлэх ажиллагаа. Уб., 2015 он.
9. Баасансүрэн .Т Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хүлээлгэх хариуцлага, түүнд хийсэн шинжилгээ. Магистрын ажил. Уб., 2023 он.

⁷³ Зөрчлийн тухай хууль. Төрийн мэдээлэл. 2017 он. №24.

**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ,
АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ
LEGAL STATUS OF ROAD TRAFFIC PARTICIPANTS,
SOME ISSUES TO CONSIDER**

Х.Уянга

ДХИС-ийн Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч,
хууль зүйн магистр

Kh.Uyanga

University of Internal Affairs School of Law and Social Sciences
Lecturer at the Department of Public Law,
Lieutenant of Police, Master of Laws

Товч агуулга: Энэхүү Эрдэм шинжилгээний өгүүллийн хүрээнд зам хөдөлгөөний зөрчлийн төлөв байдлыг судлах, зөрчилд жолоодох эрхээ хасуулсан этгээдийн нас, хүйс нөлөөлж буй эсэх /Жолоодох эрх хасуулсан этгээдийн жишээн дээр/ хамаарлыг судалгааны үндсэн дээр тодорхойлох цаашид залруулах буюу өөрчлөх ёстой асуудлыг тоймлон судаллаа.

Abstract: Within the scope of this research article, we have reviewed the issues that should be corrected or changed to determine the relationship between the age and gender of the person who has been deprived of the right to drive on the basis of the research.

Түлхүүр үг: Замын хөдөлгөөний аюулгүй байдал, нас, хүйс, жолоодох эрх, тээрийн хэрэгсэл

Key words: Road safety, age, gender, driving license, vehicle

Удиртгал. Зам тээврийн осол, хэрэг гэх өргөн хүрээг хамарсан судлагдахууныг гүйцэтгэх цаг хугацаа, боломж, хөрөнгө зэрэг асуудлыг харгалзан үзэж, замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил, шийдвэрлэлтийн нэг төрөл /жолоодох эрхээ хасуулсан этгээд/-ийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг залуучууд илүү гаргаад байна уу, эсвэл нас тогтсон хүмүүс гаргаж байна уу?, хүйсийн хувьд эмэгтэй хүмүүс их зөрчил гаргадаг гэх асуудлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээс нэг биш удаа сонсож байсан. Мөн эрэгтэй хүмүүсийн хувьд жолоо барьж байгаа эмэгтэй жолооч нараас замын түгжрэл үүсдэг, осол ихээхэн хамаарч байна гэх яриа байсаар байдаг. Тэгвэл зам тээврийн ослын гол шалтгаан нөхцөл юу вэ? гэсэн асуудал ар араасаа хөвөрсөөр байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай⁷⁴ хуулийн шинэчилсэн найруулга батлагдан 2015 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг тодорхой тусгасан гэж үзэхээр байна.

Жолоодох эрх хасуулах захиргааны арга хэмжээ авагдсан этгээдийн хувьд согтууруулах ундаа, мансууруулах эм сэтгэгцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6-2 жил хүртэл хугацаагаар хасах, эсрэг урсгал сөрсөн (Замын

⁷⁴ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль //Төрийн мэдээлэл.1992 он. №01


хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. 2015) 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хасах, хурд хэтрүүлэх (Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. 2015) 6 сарын хугацаагаар хасах буюу уг зөрчлүүдэд жолоодох эрхийг хасах захиргааны арга хэмжээ авах эрх зүйн үндсийг тодорхойлсон байна гэж үзэхээр байна.

Замын цагдаагийн газраас эмхэтгэн хэвлүүлсэн статистик үзүүлэлтээс авч үзвэл жолоодох эрхтэй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 2020 онд 8761, эрхээ хасуулсан үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 1286, эрхгүй этгээд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 428, 2021 онд 14485, эрхээ хасуулсан үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 2592, эрхгүй этгээд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 933, 2022 онд 27421, эрхээ хасуулсан үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 2043, эрхгүй этгээд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 859 жолооч жолоодох эрхээ хасуулсан байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар жолоодох эрхээ хасуулах арга хэмжээ авагдсан жолооч нарын зөрчил гаргасан хэлбэрийг авч үзвэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон (ЦЕГ-ын Лицензийн төв⁷⁵. жолоочийн мэдээллийн сан. 2020, 2021, 2022) онуудад тус тус хамарч байна.

Иймд судалгааны ажлаараа жолоодох эрхээ хасуулсан этгээдүүдийн зөрчлийн хэлбэр түүнд оролцогч буюу жолоочийн нас, хүйс, боловсролын байдал нөлөөлж буй эсэхийг хамаарлыг тодорхойлох зорилгоор "Замын хөдөлгөөний зөрчилд оролцогч"-ийн /Жолоодох эрх хасуулсан этгээдийн жишээн дээр/ сэдвээр судалгаа хийж, хэдийгээр жолоодох эрхээ хасуулсан этгээдийн тоо 3 жилтэй харьцуулахад нийслэл хотын хэмжээнд жолоодох эрхээ хасуулсан этгээдийн тоо 94 хувьтай байгаа нь судлах хэрэгцээ шаардлагатай сэдвүүдийн нэг гэж үзээд графикаар оруулав.

График 1. Согтуугаар илрүүлсэн зөрчлийн тоо мэдээ



⁷⁵ Цагдаагийн ерөнхий газрын лицензийн төв (2016, 2017). Үйл ажиллагааны тайлан.

График 2. Жолоодох эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил





График 3. Сogтуугаар илрүүлсэн зөрчлийн тоо мэдээ



Мөн тээврийн хэрэгслүүд үйлдвэрээс гарч замын хөдөлгөөнд орох, эдэлгээнд орохдоо байнгын элэгдэлд орж байдаг⁷⁶. Тээврийн хэрэгслийн элэгдэл гүйлт, насжилт хамааруулан тооцох аргачлал байдаг. Дэлхийд дунджаар нэг тээврийн хэрэгсэл, автомашиныг ашиглах хугацаа 15 жил байна. Энэхүү ашиглалтын хугацааг 3 хувааж үздэг. Үүнд:

1. Автомашины үйлдвэрийн баталгаат хугацаан дахь үе буюу 5 хүртэлх насжилт ийм насжилттай автомашин техникийн бүхий л стандартыг хангах бөгөөд дахь хорт хий байх ёстой хэмжээ, нормоо барьдаг ба эвдрэл гэмтэл ч бага гардаг.
2. Автомашины хоёрдох мөчлөгийн үе буюу 6-10 жилийн насжилттай автомашинууд ихэвчлэн гүйлт нормоо дуусган, хэрэглээнээс гарч аюул эрсдэл дагуулах хэрэгсэл байдаг.
3. Гурав дахь үе буюу арваас дээш жилийн насжилттай автомашинууд бөгөөд ойр ойрхон эвдэрч, хорт утааны хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ сэлбэг хэрэгсэл нь олдохоо больж Энэ үед улс гэлтгүй хэрэглэж буй этгээд нь ямар нэг аргаар салахыг хичээнэ. 2 талын ашиг

⁷⁶ Цагдаа судлал онол арга Зүйн улирал тутмын сэтгүүл 2023 №2 (35)

сонирхол нэгдмэгц 10-с дээш жилийн насжилттай автомашиныг задалж дахин боловсруулна эсвэл буурай орон руу маш хямдхан экспортолдог.

Автомашин үйлдвэрлэгч улсуудын дээрх бодлогын дүнд шинэ автомашинууд тус улсдаа үлдэж эдийн засгийн зөв бөгөөд ашигтай эргэтэл үлдэн харин 7-с дээш жилийн насжилттай хэт хөгшин, автомашинууд буурай орнуудын автопаркийг бүрдүүлдэг. Агаар бохирдол бий болгож байгаа эх үүсвэрүүдийн тодорхой хувийг тээврийн хэрэгсэл эзэлдэг.

Үндсэн хэсэг

Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журам санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг тээврийн хэрэгсэл жолоодох эрх гэж үзнэ гэж заасан байна. Жолоодох эрхгүй этгээдэд торгох, тусгайлан олгосон эрх хасах, хууль бусаар олсон орлого эд зүйлийг хураах, баривчлах 4 төрлийн шийтгэл ногдуулахаар Захиргааны хариуцлагын тухай хууль */хүчингүй болсон/-*д тодорхойлсон байдаг. Уг хуульд торгох, баривчлах шийтгэлийг үндсэн, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэлийг үндсэн болон нэмэгдэл, хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хураах шийтгэлийг нэмэгдэл шийтгэлийн хэлбэрээр хэрэглэнэ. Шийтгэл ноогдуулах шийдвэр нь торгуулийн хуудас, шийтгэвэр гэсэн хэлбэртэй байна хэмээн заажээ.

Хөдөлгөөний аюулгүй байдлын журам⁷⁷ зөрчсөн асуудлыг Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар иргэнийг торгох шийтгэл нь иргэнийг 500-50000, албан тушаалтныг 1000-60000, байгууллага аж ахуйн нэгжийг торгох шийтгэл 50000-250000 төгрөгийн хэмжээтэй байх бөгөөд 500-5000 төгрөг хүртэлх шийтгэлийг торгуулсан тасалбараар, 5000-аас дээш төгрөгийн шийтгэлийг шийтгэврээр ногдуулна, баривчлах шийтгэл 7-30 хоног, тусгайлан эрх хасах шийтгэл 6 сараас 2 жил хүртэл хугацаатай байхаар заасан байжээ.

Харин өнөөдөр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодвол шинэчлэн батлагдсан Зөрчлийн тухай хуульд зааснаар 400 мянган төгрөгөөр торгож, жолоо барих эрхийг нь нэг жил хүртэл хугацаагаар хасч буй. Жилд 33 мянга гаруй иргэнд дээрх арга хэмжээг авдаг байна. Гэвч сүүлийн жилүүдэд тээврийн хэрэгсэл жолоодож яваад бусдын амь насыг хохироосон ноцтой гэмт хэргүүд олноор гарах болсон тул хуулийг чангаруулах арга хэмжээг авахаар болсон⁷⁸. Мөн 2023 оны байдлаар 37 хүүхэд зам тээврийн осолд амиа алдсан.

Иргэдийн амь нас замын хөдөлгөөнд хэрхэн яаж оролцож байгаагаас хамаарч байна. Ийм учраас бодлогын хүрээнд өөрчлөх ёстой гэж үзэн, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулахаар бэлтгэж байна. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодвол Эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Одоо бол Зөрчлийн хуулиар шийтгэл ногдуулсан байна.

Зөрчил үйлдэх үед 16 насанд хүрсэн Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт жолоодох эрхээ хасуулсан гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд захиргааны хариуцлага хүлээлгэнэ хэмээн зохицуулж байсан байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зөрчлийг түүний нийгэмд учруулж буй хор аюулын зэргээр нь гэмт хэрэг гэж ангилна. Ихэнх тохиолдолд хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, захиргааны хариуцлага бүрэлдэхүүний гадаад шинж төсөөтэй байдаг.

⁷⁷ Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм УБ.,2004

⁷⁸ <https://news.mn/r/2675335/>

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль батлагдсан /2015 оны 07 дүгээр сарын 08-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн/ хүртэл Захиргааны хариуцлагын тухай хуульд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хамгаалахтай холбогдсон 3 удаагийн өөрчлөлт орсон байна. Үүнд: 1994 онд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд торгуулийн шийтгэл оногдуулахгүйгээр зөвхөн тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулж байх шийдвэрийг Нийслэлийн Засаг дарга гаргаж байв.

Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуульд 1995 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох буюу 25 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт орж, 25 дугаар зүйлийн 1 дэх заалтын санкыг 10000-50000 төгрөгөөр торгох, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хасах, 2 дахь заалтын санкыг 5000-50000 төгрөгөөр торгох, 3 дахь заалтын санкыг 5000- 25000 төгрөгөөр торгох, 4 дэх заалтын санкыг 100-8000 төгрөгөөр торгох, 5 дахь заалтын санкыг 1000-10000 төгрөгөөр торгох болж өөрчилсөн бол 1998 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар согтууруулах ундааны зүйл уусан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож явсан, согтууруулах ундаа уусан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн зөрчилд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хасах, эрхгүй хүн тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд 25000-50000 төгрөгөөр торгохоор тус тус өөрчлөлт оруулсан байна.

Жолоодох эрхгүй этгээд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд 7-30 хоног баривчлах, иргэн аж ахуйн нэгж байгууллага хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээхээргүй бол иргэнийг 5000-30000, аж ахуйн нэгж байгууллагыг 50000-200000 төгрөгөөр торгох шийтгэлийг тус тус ногдуулахаар 2003 онд нэмэлт оруулсан. Ингэж нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө механикжсан тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээдэд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.⁷⁹

Мөн хөдөлгөөний аюулгүй байдалд аюул саад бий болгож, зам болон түүний элемент, байгууламжийг эвдэж гэмтээсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс байхгүй байв. Урьд өмнө нь зөвхөн замын хөдөлгөөнд оролцогч хариуцлага хүлээж байсан бол хуульд дээрх нэмэлт орсноор хөдөлгөөнд аюултай байдал бий болох нөхцөлийг бүрдүүлсэн, аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлээгүй хувь хүн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэлд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах, зөрчлийн бүртгэлийн оноо тооцох болжээ.

Өнөөгийн байдлаар замын хөдөлгөөнд оролцохтой холбогдсон харилцааг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмээр зохицуулдаг. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон дүрэм, журам нь зөвхөн замын хөдөлгөөний хүрээн дэх асуудлыг шийдвэрлэх бөгөөд бусад төрлийн хөдөлгөөн /агаарын, усан болон төмөр зам/ дэх харилцааг зохицуулдаггүй.

Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль нь 2015 оны 7 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан. Уг хуулиар Монгол улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнд холбогдох

⁷⁹ Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

харилцааг зохицуулах зорилтыг хэрэгжүүлэхээр хууль тогтоогчоос шинэчилсэн найруулсан байна.

Зөрчлийн тухай хууль 2015 оны 12 дугаар 04-ний өдөр Улсын Их Хурлаас батлагдсан бөгөөд 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээр хуульчлагдсан. Уг хуулийн зорилго нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх зорилготой. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Захиргааны хариуцлагын тухай хуулийн зохицуулж буй харилцааг зохицуулахаар хууль тогтоогчоос шинэчлэгдэн найруулж баталсан байна.

Уг хуулийн гол үзэл баримтлал бол салбар эрх зүй бүрд тодорхойлсон зөрчлийг нэгдсэн нэг эрх зүйн зохицуулалтад оруулах, хариуцлагаас зайлсхийх нөхцөлөөс урьдчилан сэргийлнэ гэж үзсэн байна.

Монгол Улсын Эрүүгийн хууль нь 2002 оны 01 сарын 03-ны өдөр батлагдан мөн оны 09 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, түүний үндэслэл, эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээ, ял оногдуулах журам, нөхцөл, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэглэх үндэслэл, журам, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх зэрэг асуудлыг хуульчилсан байдаг.

Дүгнэлт

Энэхүү сэдвийн хүрээнд “Замын хөдөлгөөний зөрчлийн төлөв байдлыг судлах, зөрчилд жолоодох эрхээ хасуулсан этгээдийн нас, хүйс нөлөөлж буй хамаарлыг судалгааны үндсэн дээр тодорхойлохыг зорьсон бөгөөд насны хувьд 21-30 насны эрэгтэй, 31-40 насны эмэгтэйчүүд, хүйсийн хувьд эрэгтэй, дээд боловсролтой жолооч нар жолоодох эрхээ хасуулах гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Учир нь 2010, 2013 онд хийгдсэн Монголын мянганы сорилтын сангийн эрүүл мэндийн төсөл, гарын авлага, ном товхимлын хувьд 2007 оноос хойш хэвлэгдээгүй.

Энэ салбарт ажилладаг төрийн байгууллагын хувьд ЗЦГ-аас эмхэтгэн хэвлүүлдэг статистик үзүүлэлт, хууль сахиулах, техникийн ухааны чиглэлээр суралцаж буй оюутан, судлаач нарын хувьд нэг сэдэвт дипломын ажил, илтгэл, өгүүлэл хэлэлцүүлсэн байх боловч эдгээрийг нэгтгэн цогц мэдлэг, мэдээлэл авах гарын авлага, ном, товхимол, бүтээлийн тойм дутуу дулимаг байна гэж үзэж болохоор байна.

Мөн энэ салбарт судалгаа хийх судлаачдын хувьд хууль эрх зүйн болон, техникийн чиглэлийн мэдээллийг авах, ашиглах, мэдээлэл боловсруулах, судлахад сонирхолтой сэдвүүдийг сонгох өргөн боломж байна гэж судлаачийн хувьд харлаа.

Ашигласан материал

Хууль тогтоомж

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль 2015 он
2. Зөрчлийн тухай хууль 2017 он
3. Эрүүгийн хууль 2022 он

Ном, сурах бичиг, гарын авлага

4. Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм УБ., 2004 он
5. Автомашины бүрэн бус байдал зам тээврийн осолд нөлөөлснийг авто техникийн шинжилгээгээр тогтоох онол, арга зүйн асуудал УБ., 2018 Г.Цэндсүрэн
6. Замын цагдаагийн албаны зохицуулагч цагдаагийн эрх зүйн байдлын зарим асуудлууд УБ., Д.Батсайхан
7. Замын цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал УБ., 2015 он Л.Эрдэнэбулган

Цахим эх сурвалж

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном УБ., 2019 он
2. <https://journal.num.edu.mn/MJP/article/view/3579>
3. <https://news.mn/r/2675335/>

ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА
CURRENT STATE AND FUTURE TRENDS OF HUMAN
RESOURCES IN INTERNAL TROOPS

В.Номинчулуун

Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын эрдэм шинжилгээний ажилтан-багш, цагдаагийн хошууч

Nominchuluun V. *Researcher-teacher of Criminology, Police and Internal Troops Studies Center, police major*

Э.Хандармаа

Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын эрдэм шинжилгээний ажилтан-багш, цагдаагийн дэслэгч

Khandarmaa E. *Researcher-teacher of Criminology, Police and Internal Troops Studies Center, police lieutenant*

Хураангуй: Аливаа байгууллагын хүний нөөцийн асуудал нь тухайн байгууллагын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохоос гадна, тогтолцоо орших эс орших асуудлыг шийдвэрлэх ач холбогдолтой. Иймээс хүний нөөцийн асуудлыг нарийн төлөвлөгөө, судалгааны үндсэн дээр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Төрийн тусгай албаны хүний нөөцийн асуудал нь өөрийн гэсэн онцлог шинжийг агуулсан байдаг тул тухайн онцлог шинжийг тодорхойлж, судалсны үндсэн дээр уг байгууллагын чиг үүргээ хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Энэхүү өгүүлэлд Дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар тодорхойлж, санал дэвшүүлэв.

Abstract: The problem of human resources of any organization is important to determine the direction of the development of the organization, as well as to solve the problem of the existence or not of the system. Therefore, it is necessary to develop and implement human resource issues based on careful planning and research.

The human resource problem of the special government service has its own characteristics, so it will be possible to implement the functions of the organization based on the identification and study of these characteristics.

In this article, the current situation and future trends of the human resources of the Internal Military Organization are defined and suggestions are made.

Түлхүүр үг: Цэрэг, цагдаа, дотоодын цэрэг, хүний нөөц, төрийн тусгай алба хаагч.

Keywords: Military, Police, Home Army, Human Resources, Special Government Service.

Үндсэн хэсэг.

Манай улсын хувьд түүхийн явцдаа олон сорил, тэмцлийн үндсэн дээр өнөөгийн эрх зүйн болоод улс төр, нийгэм, эдийн засгийн тогтолцоог бий болгожээ.

Монгол Улс 1911 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, 1921 оны ардын хувьсгалын дараагаас төвийг сахисан улс байгуулах, өөрийн тусгаар тогтнолыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх, эдийн засаг, худалдааны харилцаа тогтоох чиглэлээр идэвхтэй ажиллахын зэрэгцээ улс орны дотоод аюулгүй байдлыг хангах, бослого, үймээн самууныг таслан зогсоож намжаах

чиглэлээр тодорхой ажлуудыг үе шаттай авч хэрэгжүүлж байжээ. Улмаар 1922 онд Жанжин Д.Сүхбаатарын санаачилгаар Бүх цэргийн зөвлөлийн дэргэд улсын чухал албан газруудыг манаж хамгаалах, гэмт хэрэгтнүүдийг баривчлах, хоригдол ялтныг хуяглан хүргэх, цагдан харгалзах, үймээн самууныг дарахад оролцох чиг үүрэгтэйгээр “Тусгай тасаг”-ийг анх байгуулсан нь өнөөгийн Дотоодын цэргийн үндэс суурь тавигдав.

Дотоодын цэрэг нь түүхэн хөгжлийнхөө хугацаанд 1994 он хүртэл Дотоодыг хамгаалах газар, Нийгмийн аюулаас хамгаалах яамны Хилийн ба Дотоодын цэргийн удирдах газар, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяанд, 1995 оноос Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд Цагдаагийн төв байгууллагын даргын удирдлагад штаб, мэргэжлийн анги, тусгай салбар, салааны бүтэц, зохион байгуулалттайгаар алба-ажиллагаагаа явуулж ирсэн 101 жилийн түүхтэй, тайван цагт мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй төрийн цэргийн байгууллага болж хөгжжээ.

Дотоодын цэргийн байгууллага нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Дотоодын цэргийн тухай, Цагдаагийн албаны тухай, Цэргийн албаны тухай хууль болон Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 30 гаруй хууль тогтоомжийг мөрдөж, Засгийн газрын тогтоолоор баталсан “Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм”, “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт”-ын дагуу үндсэн үйл ажиллагаагаа зохион байгуулдаг.

Монгол Улсын Их Хурлаас “Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр баталж, алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний ажилдаа хандах хандлага, итгэл үнэмшил, хариуцлагыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмж, үр дүнг сайжруулах, хуульд заасан баталгаагаар тэгш хангах орчин нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн Дотоодын цэргийн байгууллага нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” болон Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Цагдаагийн ерөнхий газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-нд тусгагдсан урт болон дунд хугацааны бодлого, төлөвлөлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг онцлогтой байгууллага юм.

Хүний нөөцийн өнөөгийн байдал

Дотоодын цэргийн байгууллага нь Төрийн албаны тухай хууль, Цэргийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичигт заасны дагуу ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүний нөөцийг нээлттэй сонгон шалгаруулж, чадварлаг мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэн ажиллаж, хуульд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд штаб, мэргэжлийн 3 анги, 11 тусгай салбарын бүтэц зохион байгуулалттайгаар алба-ажиллагааг зохион байгуулж байна.

2023 оны 05 дугаар сарын байдлаар Дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн нөхөн хангалт 91.3 хувьтай байгаа ба албан тушаалаар нь авч үзвэл, 21.0 хувийг офицер, 75.0 хувийг ахлагч, 4.0 хувийг энгийн ажилтан тус тус эзэлж, нийт бие бүрэлдэхүүний 94.4 хувь нь эрэгтэй, 5.6 хувь нь эмэгтэй алба хаагч, ажилчид бөгөөд тэдний 60.7 хувь нь нийслэлд, 39.3 хувь нь орон нутагт ажиллаж байна.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар Дотоодын цэргийн байгууллагын эрхэм зорилго, хөгжлийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох, хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, алба хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр эрх зүйн баримт бичиг, дүрэм журам боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага гарсан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, байгууллагын өөрчлөлт, шинэтгэл, хөгжлийн бодлого, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, өнөөгийн бодит байдалд үндэслэж хүний нөөцийн бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөлтийг хийх, хэрэгжилтийг хангах ажлыг үе шаттай зохион байгуулж байгаа ч тодорхой хүсэн хүлээсэн үр дүнд хараахан хүрээгүй байна.

Хуульд заасан чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадавхтай хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилгоор гадаадын улс орнуудын ижил төстэй чиг үүрэг бүхий хууль сахиулах цэргийн статустай байгууллагуудтай харилцан туршлага солилцож, хүний нөөцийг бэлтгэдэг их, дээд сургуульд урт болон богино хугацааны сургалтад хамруулж, мэргэшсэн алба хаагчдыг бэлтгэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

Дотоодын цэргийн гүйцэтгэх чиг үүрэг нэмэгдэж, бүтэц, зохион байгуулалт өргөжихийн хэрээр удирдах бүрэлдэхүүний боловсролын түвшнийг дээшлүүлэх, оператив-тактик, стратегийн түвшинд сургах, нөөцөд бүртгэх, бэлтгэх зэргээр удирдлагын тогтолцоог ханган ажиллахад хүний нөөцөд тулгамдаж буй асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.


Аливаа байгууллагын ажлын бүтээмж нь тухайн байгууллагын удирдлагаас явуулж байгаа хүний нөөцийн зөв оновчтой, уян хатан бодлоготой холбоотой байдаг билээ. Өөрөөр хэлбэл, тухайн ажилтан алба хаагчдын мэргэжлийн бэлтгэл, ур чадварыг зөв үнэлэн тохирсон албан тушаалд нь томилон ажиллуулахаас ихээхэн шалтгаалдаг. Тийм учраас аливаа байгууллагын хамгийн чухал нөөц, чадамж нь “хүн” гэдэг нь ойлгомжтой.

Байгууллага хамт олны ажил бүтэмжтэй, өөдрөг байх нь удирдах албан тушаалтныг хэрхэн сургаж, бэлтгэснээс ихээхэн хамаарах учраас байгууллагын “**Хүний нөөц**”-ийн асуудал чухал болох нь дарга захирагч нарын анхаарал татсан ажил болох нь ойлгомжтой билээ⁸⁰. Энэ нь Дотоодын цэргийн офицер бүрэлдэхүүнийг сурган бэлтгэж буй байгууллагын сургалтын үйл ажиллагаатай мөн холбогдох юм.

Алба хаагчдын боловсролын байдлыг авч үзвэл

№	Төрийн албан тушаалын ангилал	Алба хаагчдын дотор эзлэх хувь
1	Доктор	0
2	Магистр	4.4
3	Дээд	31.0
4	Тусгай дунд	12.9
5	Бүрэн дунд	49.8
6	Бүрэн бус дунд	1.6

График 1. Алба хаагчдын боловсролын байдал



Алба хаагчдын туршлага /ажилласан жил/-аар нь авч үзвэл

⁸⁰ Дотоодын цэргийн боловсон хүчин, сургалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

№	Ажилласан жил	Хувь
1.	0-5 жил	41.5
2.	5-7 жил	10.6
3.	8-10 жил	12.5
4.	11-15 жил	20.9
5.	16-20 жил	11.8
6.	21-25 жил	1.8
7.	26-аас дээш	0.5

Дээрх судалгаанаас харахад, нийт алба хаагчдын 41,5 хувь нь 0-5 жил ажиллаж байгаа тул алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр бодлого барьж, энэ чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байгаа гэсэн бидний урьдач дүгнэлтийг баталгаажуулж байна.

Төрийн тусгай ангилал бүхий албан тушаалд ажиллаж байгаа алба хаагчдын насны байдал

№	Нас	Хувь
1.	18-20	4.4
2.	21-25	21.2
3.	26-30	26.6
4.	31-35	20.6
5.	36-40	13.4
6.	41-45	8.4
7.	46-50	3.2
8.	51-55	0.9
9.	56-60	0.2
10.	61-ээс дээш	0

Нийт алба хаагчдын 72.9 хувь нь 18-35 насны залуучууд байгаа тул манлайлагч, суралцагч байгууллага болох бүрэн боломжтой юм.

Судалгаанаас үзэхэд, Дотоод цэргийн нийт бүрэлдэхүүний дийлэнх хувь нь залуу, бүрэн дунд боловсролтой алба хаагчид байна. Мөн уг байгууллагын хүний нөөцийн тогтвор суурьшилтай ажилладаггүй зэрэг байдал нь тулгамдаж буй үндсэн асуудал болж байна. Үүнийг хүний нөөцийн сурган бэлтгэх үйл ажиллагаанаас эхлээд тэдний эрх зүйн байдлын зохицуулалтуудыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Шинэ залуу алба хаагчдыг албандаа дасан зохицож ажиллах, ажлын таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр дээрх хүний нөөцийн сөрөг үзүүлэлтүүдийг бууруулж болох юм.

Дүгнэлт

Дотоодын цэргийн хүний нөөцийн өнөөгийн байдалд, цаашдын чиг хандлагын байдал офицер, ахлагчийн нөхөн хангалт, тэдний боловсрол, мэргэжлийн ангилал ажлын туршлага, албан тушаалын ангилал, насны байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд, өнөөгийн ажиллаж байгаа бие бүрэлдэхүүн 52.2 хувь нь 30 хүртэлх насны залуучууд, 54.6 хувь нь 10 хүртэл жил ажилласан ажлын туршлагатай, нийт бие бүрэлдэхүүний 67.3 хувь нь Улаанбаатар хот буюу Нийслэлд, 38.7 хувь нь хөдөө орон нутагт ажиллаж байна.

Одоо ажиллаж алба хаагч, ажилтнуудын 14.7 хувь нь Дотоодын цэргийн байгууллагын албан тушаалд тавигдах үндсэн мэргэжлийн шаардлагыг хангасан алба хаагчид байна. Энэ нь байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн түвшний хувьд боломж

хараахан өнөөгийн шаардлагад хүрэхгүй байна.

Ажлын орчин, нийгэм, эдийн засгийн баталгаа зэрэг Дотоодын цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгааг судалгааны дүн харуулж байна.

Дотоод цэргийн байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлын асуудал боловсронгуй болоогүй өдий хүрсэн нь уг байгууллагын чиг үүргийг танин мэдээгүй, энэ чиглэлээр дагнасан судалгаа хийгдэхгүй байгаатай холбон тайлбарлаж болох юм.

Энэ нь дан ганц Дотоод цэргийн байгууллагын хууль тогтоомжийг шинэчлэн баталснаар шийдвэрлэгдэхгүй байгаа болох нь тодорхой бөгөөд гүйцэтгэх байгууллагын хандлага чухал ач холбогдолтой юм.

Санал

Алба хаагчдын албандаа хандах хандлага, итгэх итгэл үнэмшилтэй болгоход чиглэгдсэн ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр тодорхой бодлого дэвшүүлэх. Ингэхдээ гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад болон нийгэмд Дотоодын цэргийн байгууллагын чиг үүргийн ач холбогдлыг таниулах чиглэлээр ажил арга хэмжээ хэрэгжүүлэх. Энэ нь уг байгууллагын алба хаагчдын албаны үнэт зүйлсийг бий болгож, улмаар алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах эрмэлзлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Дотоодын цэргийн хүний нөөцийг бэлтгэн гаргадаг сургалтын байгууллагуудын материаллаг баазыг сайжруулж, эрсдэлт нөхцөлийг арилгахад чиглэсэн олон улсын туршлагад нийцсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх.

Дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын албаны үнэт зүйл, нэр хүндийг нэмэгдүүлэхэд чиглэсэн уялдаа холбоо бүхий соён гэгээрүүлэх ажлыг тогтмолжуулах зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

1. Дотоодын цэргийн тухай хууль. УБ. 2017.
2. <https://www.uia.gov.mn/>
3. <https://www.internal-troops.police.gov.mn/>
4. <https://police.gov.mn/>
5. Дотоодын цэргийн боловсон хүчин, сургалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

**УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН ХАМГААЛАЛТЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД АНХААРВАЛ ЗОХИХ ЗАРИМ АСУУДАЛ
FOR THE PROTECTION OF OBJECTS OF NATIONAL EXCEPTIONAL
IMPORTANCE SOME PROBLEMS TO CONSIDER IN ACTION**

Дотоод хэргийн их сургуулийн
Цагдаагийн сургуулийн Дотоодын
цэргийн албаны тэнхимийн багш
Ахлах дэслэгч Б.Ариунтөгс
ariuntogs_0304@yahoo.com

Department of Internal Troops
Service of the Police School, University of Internal
Affairs Mongolia Lecturer, senior Letinant Ariuntogs.B

Хураангуй: Манай улс дотоод аюулгүй байдлаа хангах төрийн бодлогыг Монгол Улсын Үндсэн хууль⁸¹, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа⁸² тусган хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнийг хангах нөхцлийг бүрдүүлэх нэг хэсэг нь улс орны нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий үйлдвэр, албан газар, байгууллага, барилга байгууламж /улсын онц чухал объект/-ийг хамгаалах нь чухал ач холбогдолтой бөгөөд энэ үүргийг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрөл мэргэжлийн цэрэг болох Дотоодын цэрэгт даалгасан байдаг.

Өнөөдөр дэлхийн хөгжлийн чиг хандлагыг даган хувиран өөрчлөгдөж байгаа аюул занал, гамшиг, осол сүйрэл, элдэв халдварт өвчний тархалт болон дотоодын үймээн, эмх замбараагүй байдал үүсэх зэргээс улс орны дотоод аюулгүй байдлыг хангах, иргэд, олон нийтийг хамгаалах, тэдний аюулгүй байдлыг хангах нь манай улсын хувьд тулгамдсан асуудлын нэг болж байна.

Энэхүү өгүүлэлд улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал болон цаашид анхаарвал зохих зарим асуудлын талаар товч авч үзсэн болно.

Absract. Our country is implementing the state policy of ensuring internal security in the Constitution of Mongolia and National Security Concept. The protection of /nationally important objects/ is important, and this duty is assigned to the Home Army, a specialized military with special functions to ensure national security.

It is our country's responsibility to ensure the internal security of the country, to protect citizens and communities, and to ensure their safety from threats, disasters, accidents, the spread of infectious diseases, domestic disturbances and chaos, which are changing according to the trends of global development today. is becoming one of the pressing problems.

In this article, the current state of the legal regulation of the state's protection of extremely important objects and some issues that should be paid attention to in the future are briefly discussed.

⁸¹ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль.

⁸² <http://www.legalinfo.mn>. //Татаж үзсэн: 28.12.2023. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

Түлхүүр үг: Үндэсний аюулгүй байдал, Улсын онц чухал объект, объектын хамгаалалт, эрх зүйн зохицуулалт, харуулчин ахлагч, эрх, үүрэг

Key words: National security, in extremely important object of the state, protection of objects, legal regulation, guard chief, rights and duties

Үндсэн хэсэг: Терроризм дэлхийн улс орнуудад эрчимтэй тархаж, хор аюул нь улам нэмэгдэх чиг хандлагатай байгаа нь улсын онц чухал объектын харуул хамгаалалтын үйл ажиллагааг сайжруулах, хамгаалалтын арга, хэлбэр, үйл ажиллагааны орчинг улам боловсронгуй болгох шаардлага, хэрэгцээ урган гарч байна.

Иймд онц чухал объектын харуул хамгаалалтын нөхцөл байдлыг шинжлэх ухааны судалгаа, шинжилгээнд тулгуурлан хөгжүүлэх, хамгаалалтын арга, тактик ажиллагаанд бусад өндөр хөгжилтэй орны туршлагыг өөрийн орны онцлог, нөхцөл байдалд тохируулан нэвтрүүлэх, шинжлэх ухаан, техникийн хөгжлийн ололт, амжилтыг ашиглах явдал зүй ёсоор шаардагдаж байгаа юм.

Аюул, гамшиг, эрсдэлүүдийг биеэрээ туулах, түүний үүсэх нөхцөл байдлыг танин мэдэж урьдчилан сэргийлэх дархлаа тогтоогүй байдал нь сургамж болон үлддэг. Дэлхийн улс орнуудын хууль сахиулах байгууллагууд хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд ноцтой аюул учруулж байгаа терроризмын аюул болон гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тал дээр ихээхэн анхаарал хандуулдаг хэдий ч тэр болгон таслан зогсоож, урьдчилан сэргийлж чадахгүй байна.

Дотоодын цэргийн хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг болох онц чухал объектын харуул хамгаалалтын үйл ажиллагааны арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалт, хамгаалалтын инженер техникийн хэрэгсэл, түүний хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг тодорхойлох, удирдлага, зохион байгуулалтын оновчтой арга зүйг сонгох, хамгаалалтын үйл ажиллагаанд тулгардаг хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, хамгаалалтын үр нөлөөг дээшлүүлэх зүй ёсны шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд “**Үндэсний аюулгүй байдал**” гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ⁸³ гэж заасан бол Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна”, “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн”⁸⁴ гэж тус тус хуульчилж өгсөн байна.

“Дотоодын цэргийн тухай хууль”-иар “Улсын онц чухал объектыг хамгаалах, шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх” зэрэг үүргийг өдөр тутам бие даан гүйцэтгэхээр, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход болон гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох, хуулиар тогтоосон бусад чиг үүргүүдийг гүйцэтгэхэд шаардлагатай үед өөрийн цэргийн Командлагчийн шийдвэрээр оролцож тухайн байгууллагын чиг үүрэгт нь дэмжлэг үзүүлэх⁸⁵-ээр заажээ

⁸³ Төрийн мэдээлэл. 2002. №3. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль

⁸⁴ <https://mfa.gov.mn>. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

⁸⁵ Төрийн мэдээлэл. 2017. №12. Дотоодын цэргийн тухай хууль

Одоогоор Монгол Улсын Засгийн газраас Дотоодын цэргийн хамгаалалтад байхаар тогтоож өгсөн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан хотууд, Ховд, Өмнөговь, Баян-Өлгий аймгуудад байрлалтай улсын онц чухал объект, байгууламжуудыг хоног тутам офицер, ахлагчийн хүчээр хамгаалж, улс орны дотоод аюулгүй байдлын нэн чухал хэсэг болсон хүн амын амьжиргааны хангамжийн объектуудын аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлж байгаа ба цаашид 16 аймгийн ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж болон стратегийн чухал ач холбогдол бүхий уул уурхайн үйлдвэрүүдийн хамгаалалтыг хүлээж авах ажлыг судалж, үе шаттайгаар зохион байгуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дотоодын цэргийн тухай хуульд улсын онц чухал объектын харуул хамгаалалтын талаар орсон холбогдох заалтуудыг түүвэрлэн авч үзвэл:

- “улсын онц чухал объект” гэж Монгол Улсын Засгийн газраас /цаашид “Засгийн газар” гэх/ тогтоосон онцгой ач холбогдол бүхий байгууллага, үйлдвэр, барилга байгууламжийг;

- “объектын хамгаалалт” гэж улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах цогц үйл ажиллагааг;⁸⁶

“**дотоодын цэргийн алба-ажиллагаа**” гэж улсын онц чухал объектыг хамгаалах, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход оролцох болон хуулиар тогтоосон бусад үүргийг хэрэгжүүлэхээр явуулж байгаа цогц ажиллагааг хэлнэ⁸⁷ гэж томъёолжээ.

Засгийн газар нь бүрэн эрхийн хүрээнд Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм, Улсын онц чухал объектын жагсаалтыг тус тус батлахаар тусгасан бол Дотоодын цэргийн командлагч нь Дотоодын цэргийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж удирдах, анги, салбарын чиг үүргийг тогтоож, үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөө, журмыг батлах, цагдаагийн байгууллагатай харилцан ажиллах удирдамж, төлөвлөгөөг батлах, Цэргийн нийтлэг дүрмээр зохицуулахаас бусад дотоодын цэргийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлэх, биелэлтийг хангуулах, Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт, аюулгүйн арга хэмжээний заавар зэрэг Дотоодын цэргийн үндсэн чиг үүрэг болох онц чухал объектын харуул хамгаалалтын үйл ажиллагааг зохицуулах үндсэн эрх зүйн баримт бичгүүдийг баталж, зохион байгуулахаар тусгасан байна.

Түүнчлэн хамгаалж байгаа объектын хэвийн үйл ажиллагаа алдагдсан, зөрчил илэрсэн үед объектын захиргаа, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага болон бусад анги, салбартай мэдээлэл солилцох, тэдгээрийн хүч хэрэгслийг ашиглах, объектын онцлогт тохирсон шалган нэвтрүүлэх журмыг анги, салбарын захирагч холбогдох байгууллагатай зөвшилцөн тогтоох, объектын захиргаатай хамгаалалтын болон харилцан ажиллагааны гэрээ байгуулан ажиллах талаар тусгажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 283 дугаар тогтоолоор “Дотоодын цэргийн алба ажиллагааны дүрэм”-ийг баталсан нь улсын онц чухал объектын харуул, хамгаалалтын үйл ажиллагааг зохион байгуулахад гол баримтлах эрх зүйн акт болсон юм.

⁸⁶ Төрийн мэдээлэл. 2017. №12. Дотоодын цэргийн тухай хууль

⁸⁷ <https://legalinfo.mn>. //Татаж үзсэн: 25.12.2023. Монгол улсын засгийн газрын тогтоол /283/ 2017.09.27

Уг дүрэмд Дотоодын цэргийн штаб, анги, салбарт алба-ажиллагааг зохион байгуулах, Улсын онц чухал объектын хамгаалалт, хамгаалалтын системд тавигдах шаардлага, тэдгээрийг хэрхэн бүлэглэн зохион байгуулах, шинээр объектыг хамгаалалтад хүлээн авах, хүч нэмэгдүүлэн хамгаалах, шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар тодорхой бүлэглэн тусгаж өгсөн боловч харуулын бие бүрэлдэхүүн /харуулчин ахлагч/-ийн эрх, үүргийг тусгаагүй нь дутагдалтай гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 281 дүгээр тогтоолоор “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт”⁸⁸-ыг баталсан. Үүнд:

Дотоодын цэргийн төсөвт хамгаалалтад байх объект

1. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн төв байр, радио, телевизийн эфирин студи;
2. “Изотоп” төв;
3. Улаанбаатар, Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Ховд, Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж;
4. “Дулааны III цахилгаан станц”, “Дулааны IV цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компаниуд;
5. Дөргөний усан цахилгаан станц;
6. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн төв лаборатори;
7. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лаборатори;
8. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори;
9. Зоонозын өвчин судлалын үндэсний төв;
10. “Биокомбинат” төрийн өмчит үйлдвэрийн газар;
11. Стандарт, хэмжил зүйн газрын төв байр болон Үнэт металлын сорьцын хяналтын газрын байр.
12. Гадаадын иргэн, харьяатын газрын төв байр (Засгийн газрын 2018 оны 368 дугаар тогтоолоор нэмсэн)

Дотоодын цэргийн гэрээт хамгаалалтад байх объект

1. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйлдвэрийн гадна талбай дахь тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэр, тэсэрч дэлбэрэх бодисын агуулах;
2. ”Цагааннуур” худалдааны чөлөөт бүс.

Нийгэм, Эдийн засгийн ач холбогдол бүхий объектуудад: Эрүүл мэндийн хндэсний хүрээлэн, Халдварт өвчин судлалын үндэсний хүрээлэн, Улсын мал эмнэлэг, ЗООНОЗ-ийн өвчин судлалын үндэсний төвүүдийн төв лабораториуд, “БИОКОМБИНАТ” төрийн өмчит үйлдвэрийн газар, Стандарт хэмжил зүйн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын төв болон үйлчилгээний байрууд, Иргэний цахим үнэмлэхийн үйлдвэр, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв, Монголын үндэсний радио телевиз, Радио телевизийн сүлжээний газрын хонхор дахь дахин дамжуулах төв.

Стратегийн ач холбогдол бүхий объектуудад: Аймаг, хотуудын цэвэр усны эх үүсвэрийн барилга, байгууламж, Дулааны цахилгаан станцууд, Цөмийн энергийн изотоп төв, Ховд аймаг дахь дөргөны усан цахилгаан станц, уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр”

⁸⁸ <https://legalinfo.mn>. //Татаж үзсэн: 27.12.2023. Засгийн газрын 2017 оны 9 сарын 26-ны өдрийн 281 дүгээр тогтоол.

хк, “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс, “Цагаан нуур” худалдааны чөлөөт бүсийг тус тус хамааруулж болохоор байна.

Одоогийн байдлаар Дотоодын цэргийн хамгаалалтад байгаа улсын онц чухал объектуудыг үйл ажиллагааны онцлогоор нь төрөлжүүлж авч үзвэл:

Улсын онц чухал объектын харуул, хамгаалалтад хоног тутам мөрдөж ажилладаг гол эрх зүйн баримт бичиг бол “Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагаа стандарт” юм. Уг стандартыг Дотоодын цэргийн командлагчийн 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар батлуулж улсын онц чухал объектын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Уг стандартад улсын онц чухал объектын харуул хамгаалалтын инженер техникийн болон холбоо, дохиолол, теле хяналтын хэрэгслүүдэд тавигдах шаардлага, алба хаагчдын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг дэлгэрэнгүй байдлаар тусгасан байдаг.

Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.9-д “Улсын онц чухал объектын хамгаалалтад дэмжлэг үзүүлэх”⁸⁹ гэж Зэвсэгт хүчний чиг үүргийг тодорхойлсон байна. Хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлж, улсын онц чухал объектын хамгаалалтад аливаа гэнэтийн болзошгүй аюул учирч, нөхцөл байдал хүндэрсэн үед дэмжлэг үзүүлэх Зэвсэгт хүчний томилгоот нэгжүүдийг ажиллуулах журам, төлөвлөгөөг илүү боловсронгуй болгох, хамтарсан дадлага сургалт зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна

Хамгаалж байгаа улсын онц чухал объектуудын үйлдвэрлэл, үйл ажиллагаа, тэдгээрийн хэвийн аюулгүй ажиллагааны горимыг хангахад хамгаалж байгаа объектуудад үүсэж болзошгүй, харуул хамгаалалтад гарч болзошгүй, алба хаагчдын ажлын хариуцлагагүй байдлаас үүсэж болзошгүй, байгалийн гамшиг, үйлдвэр технологийн ослоос учирч болох эрсдэлүүдийг аль болох бодитойгоор үнэлж тодорхойлох, үүсч болзошгүй цагийн байдал, учирч болзошгүй хохирлын сөрөг үр дагаврыг арилгах, бууруулах боломжуудыг тогтоож, хойшлуулшгүй авч хэрэгжүүлэх арга ажиллагааг тодорхойлох нь чухал ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд байгалийн гамшигт үзэгдэл, террорист үйл ажиллагаа болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй, техникийн холбогдолтой ослын давтамж, цар хүрээ улам нэмэгдэж, үүнтэй холбогдон гамшгийн хор уршгийг илрүүлэн, арилгах, таслан зогсоох үйл ажиллагаанд объектыг хамгаалж байгаа Дотоодын цэргийн хүн, хүч хэрэгслийг зөв зохистой хуваарилах, тэдний үйл ажиллагааг зохицуулах, нэгтгэх, харилцан ажиллагааг уялдуулах асуудал чухлаар тавигдаж байгаа юм.

“Манай улсад улсын онц чухал объектод халдахыг завдсан терроризмын шинжтэй 20 орчим гэмт хэрэг бүртгэгдчихээд байна. Гэхдээ мэдээж хор уршгийн хувьд нийгмийг цочроох хэмжээнд хүрээгүй”⁹⁰ хэмээн Монгол улсын терроризмтой тэмцэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга, хурандаа Б.Эрдэнэбаяр 2014 онд өгсөн нэгэн ярилцлагандаа дурьджээ.

Энэ нь манай улсад террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, таслан зогсоох бэлтгэлтэй байх, онц чухал объектуудын харуул, хамгаалалтад онцгой анхаарах шаардлагатайг харуулж байна.

⁸⁹Төрийн мэдээлэл. 2016. №36 Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.9

⁹⁰ <http://www.sonin.mn.//Татаж үзсэн: 27.12.2023.>

Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандартын зорилго нь Улсын онц чухал объектын хамгаалалтыг Монгол Улсын хууль, тогтоомж, дүрэм, заавар, стандартаар зохион байгуулж, хамгаалалтын чанарыг сайжруулах, ашиглах инженер-техникийн хэрэгсэл, харуулын байр, цэгийн байр, шалган нэвтрүүлэх байрыг жигдрүүлэх, албаны нохойн байр, тоног хэрэгсэлд тавих шаардлагыг тогтооход чиглэгддэг байна.

Дотоодын цэргийн анги байгууллага нь хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэлийг ашиглахдаа хүн хүчийг хэмнэх, объектын хамгаалалтын найдвартай байдлыг хангах, зөрчил гарч болзошгүй чиглэлд нягтралыг бий болгох зорилгоор хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл ашигладаг.

Хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл гэдэгт хориотой бүс, мөр хянах зурвас, торон саад, хаалт, хашаа, гэрэлтүүлэг, инженерийн байгууламж, дохиоллын болон хяналтын хэрэгслүүд хамаардаг байна. Хамгаалалт, аюулгүй байдлыг уян хатан, шуурхай тасралтгүй зохион байгуулж, найдвартай байдлыг хангах тогтолцооны нэг томоохон бүрэлдэхүүн нь алба үйл ажиллагаанд мэргэшсэн алба хаагчийг бэлтгэхээс гадна хамгаалалтын инженер, техникийн хэрэгсэл, байгууламж, нэмэгдэл техник хэрэгслийг ашиглан бага хүчээр харьцангуй том нутаг дэвсгэр хамгаалах юм.

Хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл нь хүн хүчийг хэмнэх, объектын хамгаалалтын найдвартай байдлыг хангах, зөрчил гарч болзошгүй чиглэлд хамгаалалтын нягтралыг бий болгох зорилгоор хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийг ашигладаг.

Хамгаалалтыг уян хатан тасралтгүй зохион байгуулах нь хамгаалж байгаа объектын онцлог тэнд үүссэн цагийн байдлын өөрчлөлтийг хурдан мэдэрч, цаг тухайд нь зөв оновчтой шийдвэр гаргаж, объектыг тогтоосон нэг хэлбэр загварчлал буюу нэг аргаар удаан хугацаагаар хамгаалхаас зайлсхийж, улс орны эрүү, хэв журмын нөхцөл байдал, хамгаалалтын цагийн байдал, цаг агаар, газар орны нөхцөл байдалд тохируулан хамгаалалтыг өөрчлөн зохион байгуулахыг хэлнэ.

Дүгнэлт. Дотоодын цэргийн хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн хөгжүүлэн бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх, тодорхой төсөв хөрөнгийг улсын төсөвт жил бүр тусгайлан суулгаж өгдөг байх, бүтэц, зохион байгуулалт, техник хэрэгслийн хувьд боловсронгуй болгох, боловсон хүчнийг сургаж бэлтгэх, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий бусад байгууллагуудын харилцан ажиллах ажиллагааг сайжруулах, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн, зохицуулах, сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хамгаалалтыг өдөр шөнийн аль ч цагт харуулын цамхагаас үүрэг гүйцэтгэх байдлаар хамгаалалтыг зохион байгуулах биш өдрийн цагт хянах цамхагаас үүрэг гүйцэтгэж, шөнийн цагт эргүүлийн бүлгээр үүрэг гүйцэтгэх хэлбэрт оруулж, шөнийн цагт 10 цэгтэй харуулын 4 цэгийг татаж шуурхай бүлэгт үүрэг гүйцэтгүүлэн бусад цэгүүдийг эргүүлээр үүрэг гүйцэтгэдэг хэлбэрт оруулан, үүрэг гүйцэтгэлтийг GPS-ээр хянаж, камерын хяналтыг сайжруулах ажиллах.

2. Дотоодын цэргийн штабын бүтцэд Улсын онц чухал объектын аюулгүй байдлын талаарх мэдээ, мэдээлэл цуглуулах, сан бүрдүүлэх, түүнд дүн шинжилгээ хийх, судалгаанд үндэслэн нөхцөл байдлын болон болзошгүй аюулын талаарх мэдээллээр хангах үүрэг бүхий “Мэдээлэл, дүн шинжилгээний”, “Гүйцэтгэх ажлын” зэрэг нэгжтэй болох;

3. Улсын онц чухал объектын хамгаалалтад теле хяналт, холбоо, дохиоллын хэрэгслийг өргөнөөр нэвтрүүлж, хамгаалалтыг нэг газраас нэгдсэн байдлаар удирдах, давхар хянах камерын хяналтын “Нэгдсэн удирдлагын төв”-ийг шинээр байгуулах;

4. Инженерийн хэрэгслийн мэргэжлийн офицерыг байгууллагын захиалгаар, гадаад, дотоодын их дээд сургуулиудад суралцуулах, эсвэл энэ төрлийн тусгай мэргэжилтэй иргэнийг офицерын дамжаанд сурган бэлтгэх, хүний нөөцийг бэхжүүлэх,

Ашигласан материал.

Монгол Улсын хууль, тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ.,1992.
2. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль. УБ.,1993.
3. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ.,1994.
4. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. УБ.,2001
5. Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хууль. УБ.2016

Сонин, сэтгүүл:

6. Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль.
7. Төрийн мэдээлэл. 2002. №3. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
8. Төрийн мэдээлэл. 2017. №12.
9. Төрийн мэдээлэл. 2016. №36

Цахим эх сурвалж:

10. <http://www.sonin.mn>
11. <https://mfa.gov.mn>
12. <https://legalinfo.mn>.

**УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН ХАМГААЛАЛТЫН ИНЖЕНЕР,
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ, САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ
USE AND IMPROVEMENT OF ENGINEERING AND TECHNICAL EQUIPMENT
PROTECTION OF NATIONAL OBJECTS OF EXTREME IMPORTANCE**

*Э.Буман-Аюуш
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Дотоодын цэргийн албаны
тэнхимийн багш, ахмад
Buman-Ayush.E
Department of Internal Troops Service of the
Police School, University of Internal
Affairs Mongolia Lecturer, capitan*

Хураангуй. Улсын онц чухал объектыг хамгаалах тогтолцооны нэг томоохон бүрэлдэхүүн нь инженер, техникийн хэрэгсэл бөгөөд бага хүчээр харьцангуй том нутаг дэвсгэр, объектыг хамгаалдаг төрийн тусгай хамгаалалтын байгууллага, дотоодын цэргийн хувьд цаашид ихээхэн ач холбогдол өгч мэргэжлийн болон бусад байгууллагын хамтын хүчээр шийдвэрлэх, эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай асуудал болоод байна.

Энэхүү өгүүлэлд улсын онц чухал объектуудын хамгаалалтыг сайжруулахын тулд хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи, инженерийн болон хамгаалалтын техник хэрэгслүүдийг судлан, зөвхөн биет хамгаалалтын зарим аргуудыг алба ажиллагаанд ашиглах талаар товч өгүүлсэн болно.

Abstract. One of the major components of the system of protection of extremely important objects of the state is engineering and technical means, which protect a relatively large territory and objects with a small force, special protection organizations of the state and the domestic military will be given great importance in the future, and the cooperation of professional and other organizations will be solved and legal regulations will be created. is a necessary issue.

In this article, to improve the protection of the state's most important objects, to facilitate human labor, study the latest advanced technologies, engineering and security equipment, and briefly describe the use of only some methods of physical protection in official operations.

Түлхүүр үгс: Улсын онц чухал объект, хамгаалалтын инженер, техникийн хэрэгсэл, хамгаалалт, шалган нэвтрүүлэх цэг, бетонон хаалт

Key words: State objects, security engineering and technical equipment, protection, checkpoint, concrete block

Үндсэн хэсэг. Аливаа барилга байгууламжийн аюулгүй байдлыг хамгаалах асуудал нь 1)Хамгаалалтын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа; 2)Хамгаалалтын ажиллагаа, сөрөг хяналт⁹¹; 3)Биет хамгаалалт /бие бүрэлдэхүүн, хашаа, хаалт гэх мэт/; 4) Хамгаалалтын тоног төхөөрөмж, систем; 5)Кибер аюулгүй байдал гэх хэсгүүдэд хуваагддаг бөгөөд энэ өгүүлэлд зөвхөн биет хамгаалалтын зарим асуудлыг хөндөн авч үзлээ.

⁹¹ Зарим улс оронд тагнуулын ажиллагаа ч гэж нэрлэдэг.

Манай улсад харуул хамгаалалтын чиглэлийн 2 стандарт мөрдөгдөж байдаг. Түүний нэг нь Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Аюулгүй байдал ба хамгаалалтын ажил үйлчилгээ. Тавих ерөнхий шаардлага MNS 6841 : 2020⁹² юм.

Энэхүү стандартаар аюулгүй байдал ба хамгаалалтын хувийн байгууллагаас үйлчлүүлэгч этгээдэд үзүүлэх ажил үйлчилгээний хүртээмж, чанарыг тасралтгүй сайжруулах зорилгоор зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлагыг тогтоож, мөрдлөг болгох харилцааны ерөнхий стандартыг тогтоосон байна.

Харин дараагийн нэг стандарт нь Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт” гэх CS 11-0129 : 2017⁹³ юм.

Манай улсын хэмжээнд улсын онц чухал объектын хориглон хамгаалалтын асуудлыг ихэвчлэн тухайн объектыг хамгаалахаар томилогдсон хүч болон объектын хашаа түүнийг ашиглан хийсэн тор, мөр хянах зурвас, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, автомашины хурд сааруулах зориулалттай хийцлэл, хаалга, автомат хаалт, төрөл бүрийн дохиолол, камерын хяналтын төхөөрөмжөөр ихэвчлэн шийдвэрлэж ирсэн.

Техник технологийн хөгжил өндөр хурдтай явагдаж байгаа өнөө үед энэ байдлаар улсын онц чухал объектын хориглон хамгаалалтын үйл ажиллагааг “...хамгаалалт, аюулгүй байдлыг уян хатан, шуурхай тасралтгүй зохион байгуулах...”⁹⁴ боломж цаашид улам бүр хязгаарлагдана гэдгийг бүх шатандаа хүлээн зөвшөөрч, хамтран ажиллах шаардлагатай болоод байна. Тухайлбал: Анх төлөвлөхдөө суурьшлын бүсээс харьцангуй зайтай төлөвлөж барьсан объектууд суурьшлын бүстэй хиллэх болсон, биет байсан мэдээллүүд цахим хэлбэрт шилжсэн, нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг дуртай газраасаа олж авах, дуртай хэлбэрээрээ ашиглах боломжтой болсон гэх мэт бидний өмнө сорилт болж байгаа олон асуудал тулгарч байна.

“Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт” гэх **CS 11-0129 :2017** стандартад “Хүн хүчийг хэмнэх, объектын хамгаалалтын найдвартай байдлыг хангах, зөрчил гарч болзошгүй чиглэлд хамгаалалтын нягтралыг бий болгох зорилгоор хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийг ашиглана. Хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл гэдэгт хориотой бүс, мөр хянах зурвас, торон саад, хаалт, хашаа, гэрэлтүүлэг, инженерийн байгууламж, дохиоллын болон хяналтын хэрэгслүүд хамаарна...”⁹⁵ гэж заажээ.

Хамгаалалтын инженер, техникийн хэрэгслийг идэвхитэй болон идэвхигүй гэж ангилан үздэг бөгөөд идэвхитэй хэрэгсэлд механик болон бусад байдлаар хөдөлгөөн хийх замаар хориглох үүрэгтэй хэрэгслийг ойлгодог бол идэвхигүй хэрэгсэлд өөрийн хийц, төлөвлөлтийн байдлаараа хориглолтын бүрэлдэхүүн болдог хашаа, хаалт, шуудуу, бусад байгууламжийг ойлгодог.

Төрийн болон хувийн өмчийн чухал газруудыг хамгаалах нь хууль ёсны хэрэгцээ хэдий ч үзэмжгүй саад хашилт нь олон нийтийн газрыг багасгаж, бэхлэлтийн орчиндоо зохицоогүй, өнгө үзэмжгүй, шорон санагдуулам таагүй уур амьсгалыг бүрдүүлж байна.

Улсын онц чухал объектын хамгаалалтын найдвартай байдлыг дээшлүүлэхэд ашиглаж болох олон арга, төрлүүдээс Америкийн Нэгдсэн Улсын туршлагад тулгуурлан зарим зүйлсэд та бүхний анхаарлыг хандуулж байна.

⁹² <https://www.eStandart.gov.mn>. //Татаж үзсэн: 25.12.2023. Аюулгүй байдал ба хамгаалалтын ажил үйлчилгээ MNS 6841 : 2020

⁹³ <https://fliphtml5.com>. //Татаж үзсэн: 25.12.2023. **CS 11-0129:2017** Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт

⁹⁴ Төрийн мэдээлэл. 2017. №12. Дотоодын цэргийн тухай хуулийн 3 дугаар зүйл

⁹⁵ <https://fliphtml5.com>. //Татаж үзсэн: 25.12.2023. **CS 11-0129 : 2017** Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт

Дээрх асуудал дэлхий дахинд терроризмийн аюул занал бодитойгоор тулгарсан 2000 оны эхнээс томоохон улс орнуудад анхаарал татсан асуудал болсон бөгөөд улс орны аюулгүй байдалд ач холбогдол бүхий барилга байгууламжид тэсрэх бодис бүхий тээврийн хэрэгслээр халдахаас сэргийлэх зорилгоор судлагдаж эхэлсэн байна.

Америкийн Нэгдсэн Улсын Үндэсний нийслэлийн төлөвлөлтийн комисс /NCPC/ нь хамгаалалтын загвар дизайны асуудлыг анх 2001 оны 3 сараас эхлэн шийдвэрлэж ирсэн. Аюулгүй байдлыг зохицуулах ажлын хэсгээр дамжуулан NCPC нь 2001 оны 10-р сард “*Үндэсний Нийслэлд зориулсан хамгаалалтын загвар дизайн*” гэх тайлан гаргажээ. Уг тайланд Вашингтон хотын өнгө үзэмжийг сайжруулах, олон нийтийн талбайг хүртээмжтэй болгох зэрэг төлөвлөлтийн стратегийг тусгасан байна. Энэ тайлангийн гол зөвлөмжүүдийн нэг бол хамгаалалтын шийдлүүдийг өнгө үзэмж сайтайгаар зохион бүтээх талаар дэлгэрэнгүй төлөвлөгөөг холбооны агентлагуудад санал болгосон байна.

Энэ ажлыг хэрэгжүүлэхдээ 2000 оны 1-р сард холбооны болон орон нутгийн төлөөлөл бүхий 75 гаруй байгууллага, иргэний болон бизнесийн бүлгүүд, мэргэжлийн дизайны нийгэмлэг, олон нийтийн байгууллагуудыг хамруулсан бөгөөд “*Үндэсний нийслэлийн загвар дизайн ба хамгаалалтын төлөвлөгөө*”-г 2002 оны 10 дугаар сард анх гаргасан байна.

Уг төлөвлөгөө нь нийслэлийн хот төлөвлөлтийн орон зайг хадгалж, тэсрэх бөмбөг ачсан тээврийн хэрэгслийн эсрэг арга хэмжээ авах зорилгоор үзэмж сайтай тоноглол болон гаднах орчны үзэмжийг хадгалах өргөн сонголттой шийдлүүдийг санал болгосон байдаг. Зураг төслийн хүрээнд Вашингтон хотын хөшөө дурсгалын цөм болсон газрын өвөрмөц шинж чанарыг хадгалах хамгаалалтын шийдлүүдийг тусгасан байдаг.

Уг төлөвлөгөө нь зөвхөн Вашингтон хотын хамгаалалтын шийдлүүдэд анхаарлаа хандуулсан хэдий ч тухайн орчинд зохицсон дизайны зарчмуудыг Монгол Улсын төрийн тусгай хамгаалалттай болон улсын онц чухал объектод хэрэгжүүлэх боломжтой юм.

Энгийн хүн нь хотын төв хэсэгт байрладаг объектын периметрийн хамгаалалтын идэвхигүй хэлбэрийн арга хэмжээг авахдаа хотын өнгө төрх, орон зай, түүх соёл, хэлбэр дизайныг харгалзан үзэж үр дүнтэй төлөвлөсөн орчин дахь сандал, гэрлийн шон, ундны усан оргилуур зэрэг хамгаалалтын хийцлэлүүдийг аюулгүй байдлын үүднээс хийгдсэн хамгаалалтын саад гэж авч үздэггүй, өөрөөр хэлбэл хамгаалалтын найдвартай байдлыг бууруулахгүйгээр хэт нүсэр, хориотой, айдас төрүүлсэн өргөст тор бүхий хашаанаас огт өөр сэтгэгдэл төрүүлж, иргэд, объектод ажиллагсадад төрдөг сөрөг ойлголтыг үгүй болгох боломж бий болгодог давуу талтай.⁹⁶

Периметрийн идэвхигүй хамгаалалтын хийцлэлүүдийн байршил, загвар дизайны нийцлийг нарийвчилсан зураг, төлөвлөлтөөр хангахаас гадна хамгаалалтад байгаа объектын эрсдэл, ач холбогдлоос шалтгаалан хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд тухайн объектын эрсдэл, байрлаж байгаа байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа, дотоод дэг журмын талаар хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ (тандалт, шинжилгээ хийх гэх мэт аргаар)-ний мэдээллийг авч үзэхээс гадна загвар дизайны стратеги (байгууламжийн архитектурын шийдэл, барилгын бүтээц, барилга, байгууламжид хамаарах талбай, түүний дэд бүтэц, эмзэг хэсгүүдтэй уялдуулан цонхны шил, периметрийн биет саадыг хэрхэн байрлуулах, ямар хэлбэр, материалаар хийх гэх мэт) зэргийг бодолцож үзэх хэрэгтэй.

Зохимжтой загвар дизайн, инженерчлэлийн тусламжтайгаар тээврийн хэрэгслийг зогсоох саадыг бий болгохын тулд төрөл бүрийн үзэмж сайтай элементүүд болон газар

⁹⁶ Төрийн мэдээлэл. 1995. №7. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль

орны онцлогийг өргөнөөр ашигладаг. Ийм хийцлэлүүд нь явган зорчигч болон унадаг дугуйнд нэвтрэх боломжийг олгож, тэдэнд нээлттэй байдлын мэдрэмжийг төрүүлдэг.

Автомашин шалган нэвтрүүлэх хаалганд ашиглах хурд сааруулагч төхөөрөмжийг объектын онцлогт тохируулж, хаалганы 2 талд 4 метрээс багагүй зайд, “Зогс” шугамыг хурд сааруулагчаас 2 метрийн зайд тус тус хийж байрлуулна⁹⁷ гэж заасан байна.

Барилга болон периметрийн хамгаалалтын загвар дизайныг гаргахдаа барилгын зураг төсөл ба байршлын хүчин зүйлсийг зайлшгүй бодолцох хэрэгтэй. Байшин барих суурь, замын зураг төсөл, ландшафт зэрэг нь периметрийн аюулгүй байдалд маш чухал юм. Эдгээр асуудлууд нь барилгын периметрт багтсан аюулгүй байдлын хамгаалалтын түвшинг тодорхойлж өгөх гол үүргийг гүйцэтгэдэг. Жишээ нь: задгай талбай ба гудамжны байршил, хэлбэр нь периметрийн хамгаалалтын элементүүдийн хэрэгцээ бага бөгөөд шаардагдах түвшин ч доогуур байна. Шаардагдах түвшин доогуур байх үед загвар дизайн уян хатан байх боломж бүрддэг. Загвар зохион бүтээгчид нь периметрийн хамгаалалтын төлөвлөгөөг амжилттай хийхийн тулд байршлын онцлог давуу талыг харгалзаж үзэх хэрэгтэй.

Барилгын зураг төсөлд барилга, байгууламжийн өнцөг болон гудамжны хоорондох зайг харгалзан тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжтой зөвшөөрөгдөх хэмжээг тодорхойлдог. Тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжтой зөвшөөрөгдөх зай (саад ба хамгаалагдсан барилга хоорондын зай) бол маш чухал үзүүлэлт бөгөөд хангалттай зайтай байх тусам том хэмжээний, үнэтэй тусах хамгаалалтын арга хэмжээнээс татгалзаж, шаардагдах түвшинээс доогуур хамгаалалтын элементүүдийг ашиглах боломж олгодог бөгөөд хамгаалалтын хэд хэдэн бүс төлөвлөх боломжтой бол тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжтой зөвшөөрөгдөх зай бага байх тохиолдолд гүйцэтгэлийн өндөр стандарт, бүтээлч оновчтой загвар дизайн шаардах шаардлагатай болдог.

Хамгаалалттай объектыг орчны автозамын аюулгүй байдалд нөлөөлөх эрсдлийн нарийвчилсан үнэлгээг хийхдээ төлөвлөсөн болон одоо байгаа хамгаалалтын саадыг тээврийн хэрэгсэлд ашиглан давах хамгийн их хурдыг тооцоолох хэрэгтэй. Барилга чиглэсэн шулуун замаар зорчих тээврийн хэрэгслийн хурд маш өндөр байдаг тул бат бөхийн хувьд маш өндөр түвшний хамгаалалтын саадыг байрлуулах шаардлагатай. Харин эсрэгээр нь давчуу муруй зам, нарийн гудамж, замын түгжрэл, огцом эргэлт зэрэг нь аюулгүй байдлыг хамгаалахад зайлшгүй шаардагдах хийцлэлд тавигдах шаардлага, бат бөхийн түвшинг бууруулдаг тул барилга байгууламжийн орц, гарцыг төлөвлөхдөө тооцоолох шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл хамгаалалттай объектын орц, гарц нь тээврийн хэрэгсэл шулуунаар өндөр хурдтай ирэх боломжийг хязгаарласан байдлаар төлөвлөх нь зүйтэй.

Тээврийн хэрэгслийг саатуулах идэвхигүй хаалтыг гоёлын тохижуулалттай хослуулснаар дээрх элементүүдийг хялбархан бэхжүүлж болно. Сонин борлуулах цэг, автобусны зогсоол, гэрлийн шонгийн дэргэд хамгаалалтын шонг давхар суурилуулан хослуулснаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хорьж болно. Түүнчлэн унадаг дугуйны зогсоол, сандал, ундны усан оргилуур нь периметрийн хамгаалалтын найдвартай элементүүдэд тооцогдоно. Зарим тохиолдолд хамгийн сайн шийдэл бол хотын гудамж талбайтай уялдуулан сайтар тохижуулах явдал юм. Вандан сандал, автобусны буудал, сонин борлуулах цэг гэх мэт цөөн хэдэн элементийг сайтар зохиомжлон байрлуулахад тээврийн хэрэгслийн саад болж чаддаг. Түүнчлэн хамгаалалтын элементэд тооцогдох замын

⁹⁷ <https://fliphtml5.com>. //Татаж үзсэн: 25.12.2023. CS 11-0129 : 2017 Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт

хашлага, хайс, зам дагуух таримал ургамалыг хүрээлэн буй орчны архитектурын дагуу тохируулан өөрчлөж болдог.

Вашингтон хотын хувьд нэгэнт хот тохижилтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн загвар дизайн, бат бөхийн туршилтын ажлууд хийгдэж дууссан хойно зохион бүтээгчид дээрх хэсгүүдээс сонголт хийн хамгаалалтын цогц саадыг багтаасан төлөвлөгөөг зохиодог байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлахад ашигладаг зарим идэвхигүй хамгаалалтын хийцлэлийг дурьдвал:

1. Хана, барилгын гадна талбай, тусгай саванд /хайрцагласан газар/ тарьсан ургамал:

- Хана нь тээврийн хэрэгслийг барилгад ойртохоос хамгаалж өгдөг бөгөөд объектын хамгаалалтын бүсийн хязгаараар барилгыг тойруулан явган хүний замын хажуугаар байрлуулна.

- Барилгын гадна талбай нь тэгш болон шаталсан хэлбэртэй, хатуу хучилттай байж болно.

- Хайрцагласан ургамал нь ихэвчлэн барилгын нэг давхрын өргөтгөл хэсэг болдог бөгөөд барилгын гаднах талбайд байрлана.

2. Намхан хана /өвдгөөр татсан/, хашаа, хайс:

- Барилга архитектурын нэг хэсэг болж өгдөг намхан ханыг цэцэрлэг болон таримал ургамалтай хослуулж өгдөг.

- Аюулгүй байдлын шаардлагыг хангахын тулд гоёл чимэглэлийн төмөр хашаа хайсыг нэмж хийдэг.

3. Хамгаалалтын шон:

Замын хашлагын дагуух хамгаалалтын шон нь тээврийн хэрэгслийн дайралтаас хамгаалах зорилготой. Гоёмсог загвар хийцтэй, зөв байрлуулсан хамгаалалтын шон нь явган хүний замын эргэлтийг чиглүүлэх, объектод ойртох хязгаарыг зааж өгөх, гудамжны үзэмжийг сайжруулах зэрэг олон ач холбогдолтой.

Материал бүрийн давуу, сул талыг харгалзан аюулгүй байдлын шийдлийн онцлогт тохируулан загвар гаргах шаардлагатай. Төмөр болон ширэм нь бусад материалыг бодвол суурилуулахад хялбар бөгөөд аливаа хэлбэр дизайн сайтай болж чаддаг. Төмөр болон ширэм нь бетон материалыг бодвол илүү бат бөх шинж чанартай. Төмөр саад, хашаа нь бусад материалыг бодвол тогтмол будах зэргээр арчилгаа тордолгоо их шаарддаг.

Сайжруулсан бетон саадыг суурилуулахад хүний хүч болон цаг хугацаа нэлээд зарцуулагдах боловч арчилгаа бага шаардагдахын дээр төмөр, ширмийг бодвол илүү бага зардалтай байдаг. Учир нь бетонон барилга нь хотод элбэг бөгөөд хүрээлэн буй орчинтойгоо илүү сайн нийцдэг. Боржин болон бусад чулуугаар хийгдсэн хамгаалалтын элементүүд нь бусад төмөр, бетоноор хийгдсэн элементүүдээс илүү овор ихтэй бөгөөд тэдгээрийг хэлбэрт оруулахгүйгээр газарт суурилуулах эсвэл хэлбэрт оруулан сандал маягаар ашиглаж болно. Боржин чулуу нь барилга байгууламжийн архитектурт маш сайн нийцдэг бөгөөд маш бат бөх, удаан хугацаагаар ашиглах боломжтой, өнгө үзэмжтэй материал юм.

Периметрийн хамгаалалтын идэвхигүй хийцлэлийн нэг төрөл шуудуу болон овоолго бөгөөд тээврийн хэрэгслийг зогсоох бусад элементүүдийн адил маш чухал арга юм. Объектын нөхцөл байдал, газрын гадаргаас хамааран тохирох хамгаалалтын шуудуу, овоолгын хэлбэрийг сонгох нь чухал юм. Тодорхой хурд, жинтэй тээврийн хэрэгслийг зогсоохын тулд хамгаалалтын шуудуу, овоолго нь хангалттай бат бэх хийцлэлтэй байх ёстой.

Газар доор байрлах цахилгааны, утасны кабель, бусад шугам сүлжээ, хөрсний нөхцөл байдал нь ямар төрлийн шуудууг байрлуулах шийдвэрт нөлөө үзүүлнэ. Эдгээр нөхцөл байдлыг тогтоосны дараагаар үндсэн гурван төрлийн шуудууг сонгож болно.

Нью-Йорк хотод нийтийн эзэмшлийн талбайн хамгаалалтын идэвхигүй хэлбэрийн нэгэн шийдлийг иргэдэд хамгаалалтын байгууламж гэж мэдэгдэхгүй байхаар бүтээлчээр хийжээ. Уг шийдлийг *Tiger Trap* /Барын урхи/ систем гэж нэрлэдэг бөгөөд барилга байгууламжийн периметрийн хамгаалалтын хязгаараар газрын түвшинд байхаар тооцож бүтээжээ.

Дээрх систем нь ердийн дугуй болон явган хүний зам байдлаар автозамын хажууд хийгдсэн бөгөөд дугуй гэх мэт хөнгөн тээврийн хэрэгслийг хангалттай даах чадвартай юм. Харин түүний гадаргуу дээр тээврийн хэрэгсэл нэвтэрсэн тохиолдолд уг материал нь доош нурж /эсвэл ус нь гадагшилж/, хөдөлгөөнийг нь зогсоодог. Уг шийдэл нь олон нийтийн газар явган хүний хөдөлгөөнийг зохицуулах боловч зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шууд зогсоох чадвартай. *Tiger Trap* системийг АНУ-ын Инженерийн армийн корпуст туршин үзэхэд 50 км/цагт хурдтай 6.2 тонн жинтэй ачааны машиныг амжилттай зогсоож байсан байна.

Энэ төрлийн дүн шинжилгээ нь объектын эргэн тойронд тээврийн хэрэгслийн аюул учруулж болох боломжит өнцөг болон хурдыг тооцоолох юм. Халдлага гарах нөхцөлд хамгийн муу хувилбар гаргаж болох чанх урд болон перпендикуляр талын хамгаалалтын саадыг тооцоох явдал билээ. Ихэнх тохиолдолд тээврийн хэрэгсэл нь барилгын чанх урдаас бус харин өнцөгдөж чиглэх явдал байдаг. Ийм чиглэлээр ирж буй тээврийн хэрэгсэл нь хэд хэдэн метал, бетон багана, гудамжны хашлага болон бусад саадыг цохисноор хурд удааширч саадыг устгах эрчийг бууруулж өгдөг. Үүнийг харгалзан үзэж, зохион бүтээгчид шаардлагагүй олон элемент болох метал, бетон нүсэр том багана, таримал ургамал гэх зэргийг хэтрүүлэн хийх албагүй. Объектын агуулга, хамгаалалтын шаардагдах түвшинг мэдсэнээр мөнгө хэмнэж, гудамжны гоо зүйн талаас үзэмжтэй хийх хэрэгтэй. Эцэст нь хамгаалалтын идэвхитэй хэлбэрийн талаар цоон асуудлыг хөндөж байна. Улсын хэмжээнд хувийн болон төрийн байгууллагын аль ч салбарт хамгаалалтын гэх автомат хаалтыг түгээмэл ашиглаж байгаад улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хамгаалах ёстой байгууллагууд зүй ёсны анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Хамгаалалтын гэх энэ хаалт, хөнгөн гүйдэг хаалгууд олон газар тэр дотроо улсын онц чухал объектын хамгаалалтад ч ашигладдаг. Энэ бол хамгаалалт биш, замын цагдаагийн автомат дохиур гэдэгтэй санал нийлэх байх. Периметрийн хамгаалалтын идэвхитэй хэлбэрийн нэг болох автомат хаалт, хаалгыг цохилт, мөргөлтөд тэсвэртэй материал, хийцлэлээр хийх шаардлагатай бөгөөд холбогдох бат бөхийн тушилт тооцоололтойгоор өөрийн эх оронд үйлдвэрлүүлэн хэрэглэх бүрэн боломжтой байгаа юм.

Автомат хаалтын бас нэг төрөл бол газрын түвшинтэй адил түвшинд суулгах зориулалттай хаалт юм. Энэ нь хаалт бүхэлдээ дээш болох замаар хаалт тавьдаг болон автомашины дугуй хагалах замаар хөдөлгөөнийг хязгаарладаг гэсэн хэлбэртэйгээр ашиглагдаж байна. Эдгээртэй уялдуулан автомашины доод хэсэгт үзлэг хийх зориулалттай бодит камерын хяналтыг ч суурилуулан ашиглах боломжтой.

Бид олон жил хамгаалалтын цэгийн ажиглалтаар хяналтыг явуулж ирсэн бөгөөд одоо ч явуулж байна. Сүүлийн жилүүдэд хэт ягаан туяаны, дулааны, ердийн гээд олон төрлийн камераар хяналтын нягтралыг нэмэгдүүлсэн боловч техникийн гэмтэл, улирал, цаг агаар, гэрэлтүүлэг гээд олон шалтгаанаар хяналтыг бүрэн явуулах асуудал тулгамдаж байна. Дэлхий олон орон энэ асуудлаа радарын хяналтыг хяналтын камертай хослуулах

замаар шийдвэрлэж байна. Би энд Blighter радарын системийг онцолж байгаа юм. Энэ төхөөрөмж нь хөдөлж буй тээврийн хэрэгсэл болон хүн (мөлхөж буй биет)–ийг 8 км радиуст хайж илрүүлэх чадвартай. Радар өөрийн дэлгэцэнд илрүүлсэн байг автоматаар камеруудад мэдээлж, дулаан мэдрэгч бүхий камер нь байг таньж, тодорхойлон утсан болон утасгүй TCP/IP сүлжээгээр хамгаалалтад харуулдаг. Энэ системийн давуу тал нь зөрчигчийн байршлын үнэн зөв мэдээлэл /байны координат, хүрээ, хөдөлгөөний чиглэл/-ийг тодорхойлон гаргадаг. Үүнийг хамгаалалтад ашиглаж эхлэснээр хамгаалалтын цэгийн тоог багасгах замаар хөдөлгөөнт бүлэг байгуулан хамгаалалтын найдвартай байдлыг дээшлүүлэх боломжтой.

Дүгнэлт. Улсын онц чухал объектын хамгаалалтыг боловсронгуй болгох миний энэ илтгэлд дурьдсан дэвшилтэт аргуудыг ашиглах боломж аль нэг байгууллага, салбарын дангаар хийж хэрэгжүүлэх ажил биш гэдэг нь ойлгомжтой.

Энд хамгаалалтын чиг үүрэг хэрэгжүүлж байгаа байгууллагаас баримтлах бодлого, төлөвлөлтөөс гадна нийслэл, орон нутгийн төлөвлөлтийн байгууллага, нэг, барилга, барилгын материалын судлаач, үйлдвэрлэгчид, автомажуулалтын мэргэжилтнүүд, хамгаалуулагч байгууллагын хамтын ажиллагаа, мэргэжлийн хэмжээнд хийгдсэн тандалт, судалгаа, дүн шинжилгээ шаардлагатай болно.Түүнчлэн эдгээрийг улсын онц чухал объектын хамгаалалтад нийтлэг байдлаар хэрэгжүүлэхэд нэгдсэн зохион байгуулалт, бодлого, төлөвлөлт зайлшгүй шаардлагатай. Иймээс улсын хэмжээнд цэргийн болон бусад онц чухал объект, улсын хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийн шийдэл, судалгаа хийх, зөвлөмж гаргах чиг үүргийг хамгаалалтын мэргэжлийн байгууллагад хуулиар олгож, хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Ингэснээр улсын онц чухал объектын хамгаалалтын найдвартай байдал дээшлэх, аюулгүй байдлыг хангахтай холбоотой төлөвлөлтийг уялдуулах, үр ашиг муутай үйл ажиллагаанаас татгалзах, зарим объектод хот тохижилтийн хөрөнгийг зарцуулах замаар төсвийг хэмнэх боломж бүрдэх ач холбогдолтой.

САНАЛ

1. Улсын онц чухал объектуудын хамгаалалтыг сайжруулахын тулд хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи, инженерийн болон хамгаалалтын техник хэрэгслүүдийг судлан нэвтрүүлж алба ажиллагаанд өргөнөөр ашиглах
2. Сүүлийн үеийн дэвшилтэт техник, хэрэгслүүдийн үнэ болон үзүүлэлтийн судалгааг хийж улсын төсөвт оруулах

Ашигласан материалын жагсаалт

Монгол Улсын хууль:

1. Монгол Улсын Дотоодын цэргийн тухай хууль
2. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль

Монгол Улсын стандарт:

3. Улсын онц чухал объектын хамгаалалтад тавих шаардлага **CS 11-0129 : 2017** стандарт
4. Аюулгүй байдал ба хамгаалалтын ажил үйлчилгээ **MNS 6841 : 2020** стандарт

Сонин сэтгүүл:

5. Төрийн мэдээлэл. 1995. №7
6. Төрийн мэдээлэл. 2017. №12

Цахим эх сурвалж:

7. <https://www.eStandart.gov.mn>
8. <https://fliphtml5.com>